

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

2018 оны 11 дүгээр сарын 27

№	Агуулга	Бүгд	Зорилго 1 Иргэдийн оролцоотой Сүхбаатар дүүрэг	Зорилго 2 Боловсролд ээлтэй Сүхбаатар дүүрэг	Зорилго 3 Амьдрахад таатай Сүхбаатар дүүрэг	Зорилго 4 Иргэндээ үйлчлэх Сүхбаатар дүүрэг	Зорилго 5 Дэвжин дээшлэх Сүхбаатар дүүрэг	
1	Нийт заалтын тоо	165	18	22	44	45	36	
2	Биелсэн /100%/	152	17	20	41	40	34	
3	Хэрэгжих шатандаа							
		70.0%	11	1	2	2	5	1
		40.0%	2	-	-	1	-	1
4	0%	-	-	-	-	-	-	
5	Хугацаа болоогүй.	-	-	-	-	-	-	
		97,3%	98,3%	97,2%	97,2%	96,6%	97,5%	

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

2018 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2018 онд хүрэх түвшин, үр дүн	Батлагдсан хөрөнгө	Хариуцсан хэлтэс, алба	Хувь	
1	2	3	4	5	6		7	
1. Иргэдийн оролцоотой Сүхбаатар дүүрэг								
1.1 Иргэдийн санаачилгыг дэмжин хамтран бүтээнэ.								
1	1.1.1	ДЗДҮАХ-ийн 1.1.1 Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг тогтолцоог тогтмолжуулна.	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар олон нийтийн санал асуулгыг авч, түүнд үндэслэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ТГХШХ	100%
			Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.4, Төвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.5.1-т заасны дагуу улс, нийслэлийн төсөвт тусгах хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд дүүргийн иргэд, дэргэдэх хэлтэс, албадаас ирүүлсэн 45,056.89 мянган төгрөгийн 245 төслийн саналыг нэгтгэн боловсруулж, 38,019.24 мянган төгрөгийн 48 төслийг 2019 оны улс, нийслэлийн хөрөнгө оруулалтад, 1,984.5 мянган төгрөгийн 34 төслийг нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад тусгахаар тус тус бэлтгэн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсны үндсэн дээр дүүргийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 21–ний өдрийн 1/1687 дугаартай албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 20,387.4 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэгдээд байна. Иргэд, байгууллагаас хөрөнгө оруулалтын саналыг авсны үндсэн дээр дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хүрээнд нийтийн эзэмшлийн 11,531,082.3 мянган төгрөгийн 109 төсөл, эрүүл мэнд, боловсрол, төрийн захиргааны байгууллагуудын барилга, өргөтгөл, засвар, шинэчлэл, тохижилтын 7,727,022.9 мянган төгрөгийн 63 төсөл, дүүргийн 12-н дэргэдэх хэлтэс, албадаас ирүүлсэн төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай 200 нэр төрлийн 8932 ширхэг бараа худалдан авалтын 2,765,945.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, 8-н дэргэдэх хэлтэс, албадаас ирүүлсэн 4,687,684.4 мянган төгрөгийн тохижилт, засварын ажлын 73 төсөл, нийт 26,711,734.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсруулаад байна.					
2	1.1.2	ДЗДҮАХ-ийн 1.1.2	Сангийн сайдын 244 дүгээр тушаалын дагуу	Үйл ажиллагааны	Орон	7 000 000	ТГХШХ	100%

		Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлын саналыг иргэдээс хууль тогтоомжийн дагуу авч, иргэдийн оролцооны түвшнийг дүүргийн хэмжээнд нэмэгдүүлнэ.	орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг тухайн хорооны иргэдийн санал, хэрхэн тохижуулах тухай ерөнхий зураглалыг авч, зөвшилцөн шийдвэрлэнэ.	хэрэгжилт, хувиар	нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг иргэдээс санал авч хэрэгжүүлсэн байна.				
			<p>Дүүргийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/72 дугаар захирамжийн дагуу 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөх зорилгоор иргэдээс авах нээлттэй санал асуулгыг 5,17 дугаар хороодод цахимаар, бусад хороодод санал асуулгын хуудсыг айл өрх бүрт хүргэх, иргэдээс нээлттэй санал асуулга авах хэлбэрээр 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 6-ны өдрийн хооронд зохион байгуулан ажиллалаа.</p> <p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийгдэх нээлттэй санал асуулгыг 5,17-р хороодод цахимаар авахаас цахим санал асуулга хангалтгүй явцтай байсан учир нийт иргэдийн 60%-д нь цаасаар авсан. Бусад хороодод саналын хуудсаар нээлттэй санал асуулга авлаа. Санал асуулгад 20 хорооны байнгын хаяг дээрээ оршин суудаг нийт 25433 өрх санал өгөхөөс 13 ажлын төрлөөр 1962 байршилд 23588 өрх буюу давхардсан тоогоор 69148 санал өгч дүүргийн хэмжээнд санал асуулга 93,4%-ийн хэрэгжилттэй зохион байгуулагдлаа. 20 хорооны санал асуулгын маягыг хэсэг тус бүрээр архивлан авсан. Иргэдээс ирүүлсэн санал асуулгыг нэгтгэн байршил дээр нь очиж судалгаа хийсэн. Нээлттэй санал асуулгаар иргэдээс ирүүлсэн боломжтой саналаас үндэслэн байршил дээр судалгаа хийж хороо тус бүрээр нийт 189 үрдчилсэн жагсаалт гарсан. Нийт 7 сая төгрөг зарцуулсан.</p> <p>1.2 Төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй ил тод мэдээлнэ</p>						
3	1.2.1	ДЗДҮАХ-ийн 1.2.1 Шилэн дансны хуулийн дагуу дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан мэдээлж, тайлагнаж ажиллана.	Шилэн дансны хуулийн дагуу дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан улирал бүр тогтмол мэдээлж, тайлагнаж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд холбогдох мэдээллийг түгээсэн байна.	-	ТЗУХ, МХХ	100%	
			Шилэн дансны хуулийн дагуу дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой дүүргийн Засаг даргын 170 захирамж, Засаг даргын Тамгын газрын 214 тушаал, шийдвэрийг shilendans.gov.mn сайтад сар бүр байршуулсан. 2018 оны 12 дугаар сарын шийдвэрүүдийг байршуулах хугацаа болоогүй болно. Хэрэгжилт 90 хувь						

			Шилэн дансны хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 111 байгууллагын төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан улирал бүр тогтмол мэдээлж, байгаа эсэхэд хяналт тавьж, тайлагнаж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Төсвийн зарцуулалт ил тод нээлттэй болно. Иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох боломж бүрдсэн байна.	-	ДАА	100%
4	1.2.2		<p>2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр дүүргийн ЗДТГ-ын байрны 9 давхрын хурлын Б зааланд Биеийн тамир спортын хороо, 14, 16, 25, 40, 54, 69, 135, 166-р цэцэрлэгийн нягтлангуудад 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдөр, 42, 109-р цэцэрлэгүүдэд, 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр, СБД-ийн Спорт хороо, 2, 40, 54, 130, 225-р цэцэрлэгүүдийн шинээр ажилд орсон нягтлан бодогч нарт СБД-ийн 08-р хорооны байранд Дотоод аудитын албаны 207 тоот өрөөнд "Шилэн дансны тухай хууль" болон МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын хэрэгжилтийн талаар сургалтуудыг тус тус зохион байгуулсан.</p> <p>ТЕЗ-ийн хамрах хүрээний төрийн болон орон нутгийн өмчит 62 байгууллагад, хуулийн хэрэгжилтийг цахим хуудсаар дамжуулан улирал бүр тогтмол мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж зөвлөмж өгч ажиллав. 2018 онд санхүүгийн хяналт шалгалт хийсэн 1, дотоод аудит хийгдсэн 29 байгууллагын төлөвлөгөө хөтөлбөрт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар тусган шалгаж зөвлөмж өгсөн бөгөөд ил тод байдлыг хангахад хяналт тавьж мэдээллээ байршуулаагүй, хугацаа хоцорсон 71-р сургуульд 2018 оны 04 дүгээр сарын 27-нд албаны 23 тоотоор зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан тухай тус сургуулийн 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 85 тоотоор хариу ирүүлсэн, БТСДСургуульд 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 50 дугаартай албан тоотоор зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж хариуг тус сургуулийн 2018 оны 10-р сарын 16 ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн болно.</p> <p>2017 онд дүүргийн ТЕЗ-ийн хамрах хүрээний нийт 62 байгууллагын хуулийн хэрэгжилт 78 хувь байсан бол 2018 оны 11-р сарын 20-ны байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 97 хувьтай болж сайжирсан байна.</p> <p>2018 оны төлөвлөгөөний дагуу 12-р сард дүүргийн ТЕЗ-ийн хамрах хүрээний төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийхээр төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.</p>					
5	1.2.3		Үйл ажиллагааны талаарх мэдээллийг	Үйл ажиллагааны	100	-	ТЗУХ	100%

			цахим хуудсаар байнга мэдээлнэ.	хэрэгжилт, хувиар					
			Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албадаас зохион байгуулсан 402 удаагийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг бэлтгэн олон нийтэд сурталчилж ажиллалаа. Дүүргийн албан ёсны www.sbd.gov.mn цахим хуудас, Ulaanbaatar.mn , Zasag.mn болон Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар пейжүүд, олон нийтийн ikon.mn , news.mn , bestnews.mn , undesten.mn , arslan.mn сайтуудаар агуулга давхардаж 1020 удаа нийтлэв.						
6	1.2.4	ДЗДҮАХ-ийн 1.2.2 Алслагдсан хороодод төрийн үйлчилгээг Хөдөлгөөнт оффис-оор үзүүлнэ.	“Хөдөлгөөнт оффис” ажиллуулах журам боловсруулан үйл ажиллагааг тогтмолжуулж, хамрах хүрээ, үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, үр дүнг тооцон ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ТЗУХ	100%	
			Төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх, алслагдсан гэр хороодын иргэдэд үйлчилгээг ойртуулах зорилгоор дүүргийн Засаг даргын 2018.01.08-ны өдрийн А/01 дүгээр захирамжаар Хөдөлгөөнт оффис ажиллуулах журмыг боловсруулан батлуулж улирал тутам 2 баг хороодод ажиллахаар хуваарийг гарган Дүүргийн Засаг даргын зөвлөх П.Мөнхбаяр, Засаг даргын орлогч Ц.Шижир, П.Давхарбаяр нараар ахлуусан 2 баг хороодод ажиллалаа. Хуваарийн дагуу <u>1-р багт</u> : ТЗУХ, ТГХШХ, НХХ, Татварын хэлтэс, Боловсролын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс, Цагдаагийн-1, Хог тээвэрлэгч компани, <u>2-р багт</u> : СТСХ, ХХҮХ, ТНААХ, Газрын алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн-2, Хог тээвэрлэгч компани тус тус ажиллаж, журмын дагуу хэлтэс, нэгжийн хэмжээнд хийж хэрэгжүүлж буй ажлаа иргэдэд сурталчлан тайлагнасны зэрэгцээ 817 иргэнтэй уулзалт хийж, 150 гаруй иргэн санал хүсэлтээ илэрхийлсэний 95-ийг газар дээр нь шийдвэрлэн, 55 иргэний хүсэлтийг холбогдох хэлтсүүд эргэж судлан хариуг хүргүүлэв.						
7	1.2.5	НЗДҮАХ-ийн 1.6.3 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 1.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, иргэдэд нээлттэй ил тод болгоно.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын гүйцэтгэлийн мэдээг сангийн яамны сайт болон шилэн дансны сайтад байршуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	СТСХ	100%	
			Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 6 төсөл арга хэмжээний 356,933.6 мянган төгрөгийн ажил батлагдсанаас 6 төсөл арга хэмжээний 235,877.7 мянган төгрөгийн ажлыг хүлээн авч, гүйцэтгэлийн						

			санхүүжилтийг олгосон. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг иргэд олон нийтэд дүүргийн вэб сайт болон шилэн дансны цахим хуудсанд мэдээллэн ажиллаж байна.					
8	1.2.6	<p>ДЗДҮАХ-ийн 1.2.4 Дүүрэг, хороодын иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлэх, төр засгийн шийдвэрийг тогтмол мэдээлж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.</p>	<p>Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиглэлээр холбогдох хэлтэс, хороодтой хамтран ажиллаж дүүрэг, хороодын Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	-	ТЗУХ	100%
			<p>Иргэд олон нийтийн дунд “Газрын тухай” хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хэрэгжилт үр нөлөөг тодорхойлох, иргэд, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон хуулийн зохицуулалтын талаар санал авч, иргэдийн оролцоог хангах зорилгоор ДИТХ, Газрын албатай хамтран “Олон нийтийн хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 01 дүгээр сарын 9-13-ны өдрүүдэд, дүүргийн ЗДТГ-аас ОНХС-н хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх ажлын санал асуулгыг эрэмбэлүүлэх хэлэлцүүлэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны Хөтөлбөр батлах тухай 50 дугаар тогтоолоор батлагдсан Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд дүүргийн иргэдэд Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Газрын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган иргэдэд “Хууль бидний амьдралд” сэдэвт сургалтыг Хууль зүйн тасгаас 2018 оны 05 дугаар сарын 08-18-ны өдрүүдэд дүүргийн 1-20 дугаар хороодод зохион байгуулж, 450 гаруй иргэдэд мэдээлэл хийж, 3000 гаруй үзүүлэн таниулах материал тарааж, 30 гаруй иргэдэд биечлэн хуулийн зөвлөгөө өгөн, 188 иргэн санал асуулгад хамрагдаж шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн идэвх оролцоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Тайлант хугацаанд хороодын Иргэний танхимд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, хэлэлцүүлэг, өдөрлөг, уулзалт, спорт, урлагийн уралдаан тэмцээн, эрүүл мэндийн үзлэг оношилгоо зэрэг чиглэлээр зохион байгуулсан 130 гаруй удаагийн арга хэмжээнд 5164 иргэн, тогтмол зохион байгуулагддаг аэробик, хийн дасгал, нийтийн бүжиг, ширээний теннис, англи хэл, шатрын зэрэг сургалт, дугуйлангуудад давхардсан тоогоор 7000 гаруй иргэн хамрагдаж хороодын Иргэний танхимын үйл ажиллагаа тогтмолжлоо.</p>					

9	1.2.7	НЗДҮАХ-ийн 1.6.5 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 1.2.7 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг хуульд заасан хэрэгслээр ил тод мэдээлнэ.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэд олон нийтэд худалдан авах ажиллагааны мэдээллийг шуурхай хүргэснээр олон нийтийн оролцоо нэмэгдэж, хяналт сайжирсан байна.	-	XAAA	100%
			<p>Дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь 2018 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан 3227,1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 64 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлбэл зохих төлөвлөгөөт ажлыг бүрэн хэрэгжүүллээ. Мөн дүүргийн цаг үеийн үйл ажиллагаатай холбоотой төсвийн хөрөнгийн бусад эх үүсвэрээс санхүүжих 1751,7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 36 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгууллаа.</p> <p>Тендерийн урилга, гүйцэтгэл, үр дүнгийн мэдээллийг тухай бүрт шинэчлэн боловсруулж tender.gov.mn shilendans.gov.mn, sbd.gov.mn сайтад болон албаны мэдээллийн нээлттэй самбарт тогтмол байршуулан ил тод мэдээлэн ажилласан.</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны системээр 19 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж, батлагдсан төлөвлөөний 29 хувийг цахимаар хэрэгжүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд, худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх явцад ямар нэгэн гомдол маргаан гараагүй болно.</p> <p>Хуульд заасан мэдээллээр ил тод мэдээлэх хүрээнд тус алба нь Захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга зарыг өдөр тутмын сонинд байршуулахад 1,4 сая төгрөгийн зардал гаргаж, тендерийн баримт бичгийг зарж борлуулснаар төсөвт байгууллагын өөрийн орлогоор 14,7 сая төгрөгийн орлого оруулж ажилласан байна.</p>					
10	1.2.8	ДЗДҮАХ-ийн 1.2.8 Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээнд иргэд, олон нийтийн оролцоог хангаж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулна.	Сангийн сайдын 39 дүгээр тушаалын дагуу иргэдийн бүлгийн жагсаалтыг үүсгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээнд Иргэдийн бүлгийн жагсаалт үүсгэж, иргэдийг бүтээн байгуулалтын ажилд идэвхтэй оролцуулсан байна.	-	ТГХШХ	100%
			<p>Нийслэлийн ИТХ-аас 2018 оныг “Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах” жил болгон зарласантай холбогдуулан Манай хороо-Миний гудамж аяны хүрээнд Сүхбаатар дүүрэг нь дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийгмийн хариуцлагыг өндөрсгөх хүрээнд нийт 1500 орчим аж ахуй нэгж байгууллага 3000 орчим өрхөд аяны тухай</p>					

			<p>уриалгыг хэвлэж тараан сурталчлан таниулсан байна. Тус аянаар 2018 оны 03-10 дугаар саруудад иргэд, аж ахуй нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэхээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> • Дүүргийн 11-20 хорооны 360 айл өрхөд Ургамлын далай ХХК-ны захирал Ц.Түмэнбаяр урилгаар хүрэлцэн ирж, Хашаандаа сайхан амьдаръя төслөө танилцуулж зөвлөгөө мэдээлэл өгсөн. • Шаргаморьтын 2 дугаар хэсгийн ахлагч Алтанцэцэг нь хэсгийнхээ иргэн Сэлэнгээтэй хамтран баяр наадмын өдрүүдэд иргэдээ цэвэрхэн орчинд наадацгаахыг уриалж уриалга тарааж мөн хулдаасан хэвлэлийг айлуудын хашаа болон боломжит газруудад хадлаа. • Тус аяны хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг гаднах орчноо удирдамжийн хүрээнд хэрхэн тохижуулж буйтай танилцан бусдаа манлайлан оролцож буй аж ахуйн нэгж байгууллага иргэдээ “Сайн” тэмдгийг нааж олон нийтэд мэдээлэн ажиллалаа. • Хороодын ажлын хэсэг Манай хороо-Миний гудамж аян сурталчлан таниулах мөн, дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, хүүхдийн тоглоомын талбай угаалга, ногоон байгууламжийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг иргэд, СӨХ, ААНБ-тай хамтран зохион байгуулан ажилласан байна. • Мөн 12,20 дугаар хороо 70 айл өрх Хашаа арга хэмжээ зохион байгуулан гудамжны хашааг будаж зассан байна. • Бүх нийтийн их цэвэрлэгээнд 2142 аж ахуйн нэгж байгууллага гаднах орчны цэвэрлэгээ, хашаа хайс, хаягжилт, цонхоо угааж засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ. • 2018 оны байдлаар Дүүргийн Засаг даргын 4 удаагийн захирамж гарч бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж 4963 аж ахуйн нэгж байгууллага, 18096 иргэн оролцож, 832 тн хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлээд байна. • 20 дугаар хорооны Засаг даргын ажлын алба бүх гудамжны эхлэлд өөрсдийн нөөц бололцоог ашиглан 80 ширхэг мэдээллийн чиглүүлэгч самбар хийж байршуулсан. Чиглүүлэгч самбарт гудамжны дугаар, хэдээс хэдэн тоот энэ гудамжинд байгааг заахаас гадна чухал шаардлагатай утасны дугаар /цагдаа, гал команд, эмнэлэг, ойн байцаагчийн утасны дугаарыг багтаасан байгаа. • Тус аяны хүрээнд дүүргийн 291 аж ахуй нэгж байгууллага 18988 ш мод, бут сөөг нэмэгдсэн байна. • Дүүргийн 1-10 дугаар хороонд орон сууцны хороолол дундах нийтийн эзэмшлийн орон сууцны гаднах 18500, 15 м2 орц дундын ногоон байгууламжийн зүлэгт талбай болон 2483 ш мод, бут сөөгний усалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, арчлалт хамгаалалтыг хийлгэхээр 3 аж ахуйн нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавин ажиллалаа. 					
1.3 Эко дүүрэг бий болгоход иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ								
11	1.3.1	ДЗДҮАХ-ийн 1.3.1 Иргэдийн оролцоотой “Ногоон хөгжил-Сүхбаатар” хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Эко орчин бүрдүүлэх чиглэлээр ухуулга, сургалт, сурталчилгаа явуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Эко орчин бий болгосон байна.	-	ТНААХ	70%
			2018 онд 3 удаагийн арга хэмжээгээр 112 иргэнд мод тарих талаар сургалтыг зохион байгууллаа. Үүнд: 04 дүгээр сарын 20-оос 5 дугаар сарын 08-ны өдрийн хооронд мод тарьж ,арчлах талаар анхан шатны мод тарих талаар заавар зөвлөгөөг 20 иргэнд, 09 дүгээр сарын 18 өдөр ЗДТГ хурлын танхимд мод тарьж ,арчлах					

		талаар анхан шатны онолын мэдлэг зөвлөгөөг 47 иргэнд, оны 10 дугаар сарын 2-ны өдөр 1-20 хорооны 45 иргэнд сургалт зохион байгууллаа. Саут Волли ХХК, Оргил ТББ-д дүүргийн 7 дугаар хороо Сэлбэ голын хамгаалалтын бүс дотор мод тарих газрыг зааж өгөн 15 ширхэг навчит модыг тариуллаа.					
12	1.3.2	Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Ногоон байгууламжийг бий болгосон байна.	-	ТНААХ	100%
		2018 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Мод тарих үндэсний өдрийг зарлах тухай 63 дугаар зарлиг хангах ажлын хүрээнд 05 дугаар сарын 10-ны өдрийн А/155 дугаар захирамж гарч, бүх нийтээр мод тарих өдрийг 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, 10 дугаар сарын 09-ны өдрийн 02/10 дугаар албан даалгавар гарч бүх нийтээр мод тарих өдрийг 10 дугаар сарын 13-ны өдөр амжилттай зохион байгуулж дүүргийн хэмжээнд нийт 1001 ААНБ, 5400 гаран иргэн оролцож 7813 ширхэг мод, 444м2 цэцэг, 4971,1 м2 зүлэг ногоон байгууламж шинээр тарьж өмнөх онуудад тарьсан мод бутанд арчлалт хамгаалалт, усалгаа хийж, модны тогоог засварлах, хатсан ургаагүй модыг авч шинээр тарих, зэрлэг ургамал болон хогийг цэвэрлэх ажлуудыг зохион байгууллаа.					
13	1.3.3	Олон улсад ашиглагддаг "Аз жаргалтай хот"-ын индексэд тулгуурлан Сүхбаатар дүүргийн индексийг тооцох, индексийг сайжруулах үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн "Аз жаргалтай хот"-ын индексийг үнэн зөв тооцож, индексийг сайжруулсан байна.	-	СХ	100%
		Дүүргийн Засаг даргын "Аз жаргалтай хотын индекс" тооцох аргачлалыг хэрэгжүүлэн ажиллах тухай 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хуралдаанаар дүүргийн индексийг үнэн зөв бодитой гаргах тал дээр хороод, дэргэдэх хэлтэс албад ажиллахаар болсон. Тус ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу индексийн тоон мэдээллийг үнэн зөв, бодитой гаргах зорилгоор анхан шатны нэгж болох хороодын албан хаагч, хэсгийн ахлагчдыг оролцуулан сургалтад хамруулахаар болсон. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүсэлт гаргасны дагуу 2018 оны 03 дугаар сарын 28-нд Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Р.Ягаанцэцэг болон Үндэсний статистикийн хорооны Олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Батбаяр нар индексийг тоон мэдээллийг хэрхэн гаргах сургалтыг явууллаа. Нийслэлийн Аз жаргалтай хотын индексийн 2017 оны түвшинг тогтоох, мэдээллийн бодит байдалд үнэлгээ өгөх мониторингийн нийслэлийн ажлын хэсгийн удирдамжийн дагуу 2018 оны 05 дугаар сарын 10-25 өдрийн хооронд 1-20 дугаар хороодоор явж шалгалт хийсэн. Хороод, дэргэдэх хэлтэс албадаас тоон мэдээллийг авч дүүргийн 2017 оны индексийн түвшинг гаргасан.					

14	1.3.4	ДЗДҮАХ-ийн 1.3.2 Ногоон байгууламж шинээр бий болгосон иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжиж ажиллана. Ногоон байгууламж тэдгээрийг арчлан хамгаалах ажилд иргэдийн оролцоог хангаж ажиллана.	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн мод бутыг хэлбэржүүлэх, шохойдож шуулт хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Ногоон байгууламжийн ургалтыг сайжруулж хортон шавьжнаас хамгаалсан байна.	-	ТНААХ	100%
			Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хашаан доторх мод бутыг хэлбэржүүлэх дүүргийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/108 дугаар захирамж гарч, 1-10 дугаар хорооны 140 байршлын 1867 мод, ургамалан хашлага хэлбэржүүлэх, шохойдох, шуулт хийх ажлыг “Усан бөлбөө” ХХК-тай гэрээ байгуулан 2018 оны 05 дугаар сарын 07-ноос 5 сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгүүлэн үндэслэн 70,522,250 төгрөгийн санхүүжилтийг олголоо.					
15	1.3.5	Ногоон байгууламж тэдгээрийг арчлан хамгаалах ажилд иргэдийн оролцоог хангаж ажиллана.	Рашаан булгийн эх хамгаалах гэрээт ажилтан ажиллуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Тохижуулсан рашаан булгийн эхийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан орчны бохирдлыг арилгасан байна.	-	ТНААХ	100%
			15 дугаар хороо Зуун модны рашаан, 16-р хороо Дамбадаржаагийн рашаан, 20-р хороо Гүнжийн булгийн эхийг хамгаалах, орчны хог хаягдлыг цэвэрлэх сайн дурын идэвхтэй байгаль хамгаалагч 3 иргэнтэй гэрээ байгуулж сар бүр 100,000 төгрөгийн урамшуулал олгон ажиллаж байна. 2018 онд 3 600 000 төгрөгийн санхүүжилтийг олголоо.					
16	1.3.6	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан Нийслэлд мал аж ахуй эрхлэх журмын 4.1 дэх хэсэг: Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэхийг хориглоно. ДЗДҮАХ-ийн 1.3.3 Ногоон байгууламж тэдгээрийг арчлан хамгаалах ажилд иргэдийн оролцоог хангаж ажиллана.	Төв аймгийн Эрдэнэ сумын фермерийн аж ахуйтай танилцах аялал-сургалт зохион байгуулна.	Дүүргийн 30 залуу малчдад фермерийн аж ахуй эрхлэх туршлага судлуулна.	Өрхийн аж ахуйгаас фермерийн аж ахуй эрхлэх чиглэл рүү шилжих боломж нээгдсэн байна.	-	ХХҮХ	100%
			Мал аж ахуйн салбарын хөгжлийг нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүн амын өсөлт, суурьшилтай уялдуулж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар болгох зорилтын хүрээнд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, дэмжих зорилгоор Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэстэй хамтран Төв аймгийн Баяндэлгэр сумын Нүүдэлчин агро ферм ХХК-ийн Франц улсын Монбелиард үүлдрийн Загвар өрхийн фермийн аж ахуйтай дүүргийн малтай 40 гаруй айл өрхүүдийг танилцуулж, туршлага судлах ажлыг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Өрхийн аж ахуйг фермийн цогцолбор хотхон хэлбэрээр хөгжүүлэх уг төсөлд дүүргийн мал бүхий иргэд хамрагдах боломжийг олгож, хөдөө аж ахуйн мэргэжлийн багийн үйл ажиллагаатай танилцуулан, тэдгээрийн арвин их туршлагаас хуваалцаж, фермерийн үйл ажиллагаатай танилцах зохион байгуулалтын ажилд					

		<p>дүүргийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/89 дүгээр захирамжаар Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 1 678 000 төгрөгийн зардлыг гаргаж, санхүүжүүлсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Мал аж ахуй эрхлэх зөвшөөрөгдсөн бүс рүү мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах тухай А/89 дүгээр захирамжаар мал бүхий иргэдээс гаргасан саналыг үндэслэн УБ хотын ЗАА-аас гаргасан мал бүхий айл өрхүүдэд газар олгох шийдвэрийн дагуу шилжин суурьших боломжтой газруудын мэдээллийг мал бүхий айл өрхүүдэд хүргүүлж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан хуваарийн дагуу зөвшөөрөгдсөн бүсийн газартай танилцуулах ажлыг 3 чиглэлд зохион байгуулж, Шарга морьт, Сэлх, Дамбадаржаа дахь хороодын байрны дэргэдээс малтай айл өрхүүдэд автобусаар үйлчилж, 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр БЗД-ын Арцатын амыг, 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр СХД-ийн Нарийны хэсэг, 335-ын гармын газар үзүүлэх ажлыг тус тус зохион байгуулж, газар үзэх арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 149 малтай өрх хамруулж, газрын байршил, онцлог давуу болон сул тал, цаашид авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй тайлбар өгснөөр дүүргийн мал бүхий иргэдээс нийт хөдөө орон нутаг руу 4, хот дотроо шилжин суурьшихаар 111 иргэдийн хүсэлтийг авч, холбогдох дүүргүүдийн Газрын алба болон УБ хотын ЗАА-д хүргүүлж, нүүлгэн шилжүүлэх бүхий л арга хэмжээг авч ажилласан.</p>						
17	1.3.7	<table border="1" data-bbox="741 691 2089 879"> <tr> <td data-bbox="741 691 1070 879">Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа малыг зөвшөөрөгдсөн бүс рүү гаргах, хөдөө аж ахуйн бирж дээр худалдаалах ажлыг зохион байгуулна.</td> <td data-bbox="1070 691 1301 879">Дүүргийн 199 өрхийн 3051 малыг зөвшөөрөгдсөн бүс рүү гаргана.</td> <td data-bbox="1301 691 1641 879">Дүүрэг малгүй болсон байна.</td> <td data-bbox="1641 691 1816 879">-</td> <td data-bbox="1816 691 1980 879">ХХҮХ</td> <td data-bbox="1980 691 2089 879">100%</td> </tr> </table> <p>Хориглосон бүсэд байгаа мал бүхий иргэдийг зөвшөөрөгдсөн бүс рүү нүүлгэн шилжүүлэх, малыг гаргах ажлыг зохион байгуулах нийслэл, дүүргийн Ажлын хэсэг дүүргийн 189 мал бүхий өрхүүдтэй уулзалт зохион байгуулж холбогдох хууль эрх зүйн актуудыг танилцуулах, ухуулга таниулга хийх, мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх, тэдний санал бодлыг сонсох зэрэг ажлуудыг хийж, УБ хотын ЗАА-аас гаргасан мал бүхий айл өрхүүдэд газар олгох шийдвэрийн дагуу шилжин суурьших боломжтой газруудыг танилцуулж, нүүх айлуудын хүсэлтийг УБ хотын ЗАА-д хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/592 дугаар, 2018 оны А/578 дугаар захирамжууд, дүүргийн Засаг даргын 2018 оны А/89, А/146, А/165, А/190, А/222 дугаар захирамжуудын хэрэгжилтийг хангаж, дүүргийн 189 өрхийн 3130 малыг зөвшөөрөгдсөн бүс рүү 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдөр бүрэн гаргаж, нүүлгэн шилжүүлэх ажлыг дуусгавар болгон, дүүрэг малгүй болсон.</p> <p>Мал аж ахуй эрхлэх зөвшөөрөгдсөн бүс болох СХД-ийн 21 дүгээр хороо, Нарийны хэсэг рүү нүүх 22 өрх, Ногоон толгой-335 гарам руу нүүх 50 өрх, бусад байршил руу нүүх 4 өрх, нийт 76 өрхийн газар хүссэн өргөдөл, холбогдох 170 хуудас материалыг 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 8/1595 тоот албан бичгээр Сонгинохайрхан дүүргийн Газрын албанд, Баянзүрх дүүргийн Арцатын ам руу нүүх 18 өрх, бусад байршилд нүүх 17 өрх, нийт 35 өрхийн газар хүссэн өргөдөл, холбогдох 85 хуудас материалыг Баянзүрх дүүргийн Газрын албанд 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 8/1596 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>Хөдөө орон нутаг руу малаа гаргах хүсэлт өгсөн 4 иргэний малд Нийслэлийн Мал эмнэлгийн газраас цусны шинжилгээ авч, эрүүл гэсэн баталгаа гаргаж өгсөн. Мөн дахин хөдөө орон нутаг руу малтайгаа нүүх хүсэлт өгсөн 10 иргэний судалгааг УБЗАА-ны ХХҮХ-т хүргүүлсэн.</p>	Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа малыг зөвшөөрөгдсөн бүс рүү гаргах, хөдөө аж ахуйн бирж дээр худалдаалах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн 199 өрхийн 3051 малыг зөвшөөрөгдсөн бүс рүү гаргана.	Дүүрэг малгүй болсон байна.	-	ХХҮХ	100%
Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа малыг зөвшөөрөгдсөн бүс рүү гаргах, хөдөө аж ахуйн бирж дээр худалдаалах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн 199 өрхийн 3051 малыг зөвшөөрөгдсөн бүс рүү гаргана.	Дүүрэг малгүй болсон байна.	-	ХХҮХ	100%			

			<p>Зөвшөөрөгдсөн бүсэд хийгдэж байгаа дэд бүтцийн ажилтай танилцах, малтайгаа нүүж очсон дүүргийн иргэдтэй уулзах зорилгоор СХД-ийн Ногоон толгой, Нарийны хэсэг рүү нийт 4 удаа, Арцатын ам руу 3 удаа очиж, нөхцөл байдалтай танилцан, УБ хотын ЗАА, НХХААГ-т холбогдох саналуудыг тухай бүр нь тавьж ажилласан.</p> <p>НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/592, А/578 дугаар захирамжууд, Улсын Онцгой комиссын 2017 оны 02 тоот албан даалгавар, Нийслэлийн онцгой комиссын 2018 оны 01 тоот албан даалгавар, дүүргийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал бүхий иргэдийн малыг нүүлгэн шилжүүлэх тухай А/222 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд малаа зөвшөөрөгдсөн бүс рүү гаргаж, нүүсэн айл өрхүүдийн хашаа саравчийг буулгах, ариутгал халдваргүйтлийн ажлыг Хороодын Ажлын алба, Онцгой байдлын хэлтэс, мал эмнэлгийн нэгж Овоот гол ХХК, Сүхбаатар дэвшил, Тохижилт үйлчилгээний компаниудтай хамтран зохион байгуулж, дүүргийн хэмжээнд нийт 185 хашаа саравч байснаас 135-ыг нь буулгаж, 50 өрх өөр зориулалтаар ашиглах санал ирүүлэн, малаа гаргасан айл өрхүүдийн өтөг бууцыг ачиж тээвэрлэн, нийт 169 өрхийн 16758 м² талбайг халдваргүйжүүлсэн. Энэ арга хэмжээнд нийт 19 180 050 төгрөг зарцуулсан.</p> <p>ХАА-н биржийн үйл ажиллагааг судлан үзэж, малын арилжаа хийгддэггүй тул дүүргийн малаа худалдаалах санал өгсөн айл өрхүүдийг Төв аймгийн Борнуурын фермерийн аж ахуйтай холбон өгч, нийт 5 өрхийн 36 үхрийг худалдах ажиллагааг дэмжин ажилласан.</p> <p>Зөвшөөрөгдсөн бүс рүү нүүх санал өгсөн иргэдэд санхүүгийн дэмжлэг болгон УБ хотын ЗАА-аас 96 иргэнд 78000 төгрөгний бензин талон, дүүргийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/165 дугаар захирамжаар 189 өрхөд тус бүр нь 100000 төгрөгний буцалтгүй тусламж олгож, нийт 18 900 000 төгрөгийг Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас гаргаж, санхүүжүүлсэн.</p>				
18	1.3.8	<p>Хөдөө орон нутгаас зуслангийн бүсэд зөвшөөрөлгүй бууж буй мал бүхий иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор Шарга морьтын гүүрний дээд хэсгийн гол дагуух 5000 орчим м² талбайг дүүргийн Засаг даргын Тамгын газрын эзэмшилд авч, газрыг хашаалж, хамгаалалтын бүс тогтооно.</p>	<p>Уг 5000 м² талбайд нийт 300 м төмөр хашаа татаж, тухайн газарт мал аж ахуй эрхлэхийг хориглосон тэмдэг, тэмдэглэгээ бүхий самбар байрлуулна.</p>	<p>Хориглосон бүсэд мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаа зогссон байна. Зуслангийн айл өрхүүдийн гомдол саналыг барагдуулсан байна.</p>	-	ХХҮХ	100%
<p>Монгол Улсын Байгаль хамгаалах багц хууль, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”, 2010 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн ногоон бүсийн ашиглалт хамгаалалтын журам”-ын</p>							

			<p>хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хөдөө орон нутгаас зөвшөөрөлгүй дүүргийн зуслангийн бүсэд бууж, мал аж ахуй эрхэлж буй байдлыг таслан зогсоох зорилгоор Шарга морьтын гүүрний хойд хэсэгт хамгаалалтын бүс тогтоож, хашаалах арга хэмжээний бэлтгэлийг хангаж дүүргийн Газрын албанд холбогдох газрын зөвшөөрөл олгуулахаар 2018 оны 02 дугаар сарын 8/414 тоот албан бичгээр хандаж, Аж ахуйн тасагтай хамтран газрын кадастрын зураг хийлгэж, ТГХШХ-ээр хашааны төсвийг гаргуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Туул голын онцгой хамгаалалтын бүс, Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн талаар авах зарим арга хэмжээний тухай А/801 дүгээр захирамжаар Сэлбэ голын ай сав газрын ногоон бүсэд мал хашаалахыг хориглосон тул уг газарт хамгаалалтын бүс тогтоож, хашаа барих ажил хийгдээгүй бөгөөд дотоод нөөц бололцоогоо ашиглан зөвшөөрөгдсөн бүс рүү мал бүхий айл өрхүүдийн малыг гаргах Ажлын хэсгийн шийдвэрээр 19 дүгээр хорооны байрны дэргэд 1, 20 дугаар хорооны СБД ОНӨААТҮГ-ын хашаанд 1, нийт 2 мал хашаалах цэгийг байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрт хариуллагагүй бэлчиж байгаа малыг журмын дагуу хашиж, холбогдох арга хэмжээ авч, ажилласан. Үүнд:</p> <p>Зуслангийн бүсэд дүүргийн МХХ, ОБХ, ЦХ, 19-20 дугаар хороодын Ажлын албатай хамтран Хандгайт, Санзай, Хадатын амуудад байнгын хяналт шалгалт явуулж, хориглосон бүсэд мал оруулж ирсэн зөрчил гаргасан нийт 17 өрхийн 56 адуу, 40 үхэр, 1 тугалыг буцаан зөвшөөрөгдсөн бүс рүү нь гаргаж, малын эздэд Зөрчлийн тухай хуулийн дагуу 50,0 мянган төгрөгөөр торгож, дахин зөрчил гаргахгүй байх талаар сануулга өгсөн.</p>					
2. Боловсролд ээлтэй Сүхбаатар дүүрэг								
2.1 Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг сайжруулна								
19	2.1.1	ДЗДҮАХ-ийн 2.1.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх болон шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ.	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдах 54 дүгээр цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц, хувиар	Цэцэрлэгийн орны тоо 150-аар нэмэгдсэн байна.	-	НХХ	70%
			Нийслэлийн 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар өртгөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Тералинк” ХХК 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрүүдэд ажиллах гэрээ байгуулсан. Барилгын өргөтгөлийн дотор заслын ажлууд хийгдэж байна.					
20	2.1.2	ДЗДҮАХ-ийн 2.1.3 Хүүхэд бүрийг судлан оношлох, оношилгоонд тулгуурлан хөгжүүлэх арга зүйг багш бүрд эзэмшүүлэх, сургалтыг шат дараатай хэрэгжүүлэх, багш, удирдах ажилтны нэр хүнд, мэргэжлийн ёс зүй,	Сургалт-судалгаа, хөгжлийн бодлогын зөвлөл байгуулна.	Үйл ажиллагаа, төлөвлөгөө гарсан байна.	Зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжсон байна.	-	НХХ, БХ	100%
			Сургалт-судалгаа, хөгжлийн бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 28 дугаар тогтоолоор батлуулсан. Журамд төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, багшийн хөгжлийг дэмжих 2018 онд дэвшүүлсэн зорилт, Нийслэлийн боловсрол-2020 хөтөлбөр, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Боловсролын хэлтсийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, дүүргийн боловсролын салбарын хөгжлийг сурталчилахад чиглэгдэн ажиллаж байна.					

		мэргэжил, ур чадварыг сайжруулах зорилго бүхий сургалт-судалгаа, хөгжлийн бодлогын зөвлөл байгуулж, дэмжин ажиллана.						
21	2.1.3	ДЗДҮАХ-ийн 2.1.4 Сургууль, цэцэрлэгийн засвар, тохижилтын хөрөнгө оруулалтыг тухай бүр шийдвэрлэнэ	Сургалтын орчныг сайжруулах зорилгоор засварын ажлыг гүйцэтгэнэ.	Ажлын явц, хувиар	100	-	ТГХШХ	100%
			<p>Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 175,830.6 мянган төгрөгийн төсөвтэй 1-р сургуулийн дээвэр засвар, 135-р цэцэрлэгийн фасад засвар, 131 сургууль, 216-р цэцэрлэгийн гадна тохижилтын 3 төсөл арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.</p> <p>Дүүргийн тусгай зориулалтын шилжүүлгийн хөрөнгөөр нийт 140,745.3 мянган төгрөгийн төсөвтэй 2, 4, 6, 16-р сургуулийн ариун цэврийн өрөөний засварын ажлын 4 төсөл арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.</p> <p>Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 54, 143 дугаар цэцэрлэгүүдийн дээврийн засварын нийт 81,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, зөвлөмжийг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.</p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр 31-р сургууль, Өсвөрийн зохион бүтээгчдийн лаборатори ахлах сургууль, 68-р цэцэрлэгийн барилгын их засвар, 143 дугаар цэцэрлэгийн гадна тохижилтын ажлуудын батлагдсан зураг, төсөв, холбогдох материалыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлж, 672,637.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлсэн.</p>					
22	2.1.4	ДЗДҮАХ-ийн 2.1.5 СӨБ, Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын чанарт тавих хяналтыг сайжруулна.	Бага, дунд боловсролын багш нарын сайн туршлагыг хөгжүүлэх, арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг дэмжинэ.	Сургууль, багш, удирдлагын үйл ажиллагааг дэмжинэ.	Дүүргийн нийт 393 багшид түгээсэн байна.	-	НХХ, БХ	100%
			<p>-Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын чанар хүртээмжийн үр дүнг индексээр дүгнэх журмын дагуу шалгаруулалтад төрийн өмчийн 31 цэцэрлэг оролцсноос 10 цэцэрлэг 90%-ээс дээш үнэлэгдэж, нийслэлийн шалгаруулалтаар 68, 135, 42-р цэцэрлэг болзол ханган өмнөх оноос ахисан амжилттай ажилласан. Нийслэл, дүүргийн эрүүл мэндийг дэмжигч байгууллага"-аар 16, 166-р цэцэрлэг, "Нийслэлийн тэргүүний цэцэрлэг"-ээр 42-р цэцэрлэг тус тус шалгарч, сургалтын чанар, заах арга зүй, ахиц гарган орчны таатай нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.</p> <p>-Сургуулийн өмнөх боловсролын багш нарын "Ур чадварын уралдаан-2018"-ыг сууралцахуйн 6 чиглэлээр зохион байгуулж, 32 цэцэрлэгийн багш оролцсноос бүлгийн багшаас 175-р цэцэрлэгийн багш Ө.Болорцэцэг,</p>					

			<p>хөгжмийн чиглэлээр 1-р цэцэрлэгийн хөгжмийн багш Ө.Буянхишиг, хөдөлгөөн-эрүүл мэндийн чиглэлээр 135-р цэцэрлэгийн биеийн тамирын багш Э.Эрдэнэчимэг нар шалгарч, НИЙСЛЭЛ-ийн шалгаруулалтад оролцохоор бэлтгэл хангаж байна. Багш нарын дунд “Багшийн хөгжил-сурах бичиг, сургалтын хэрэглэгдхүүний хэрэглээ” сэдэвт илтгэлийн уралдаан 3 үе шаттай зохион байгуулж, 31 цэцэрлэгийн 198 багш оролцсноос 1-р байранд 69-р цэцэрлэгийн багш Ш.Одонгэрэл “Сургалтын хэрэглэгдхүүний оновчтой шийдлээр сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх нь” сэдвээр, 2-р байранд 135-р цэцэрлэгийн багш Д.Өнөргэрэл “Багшийн хөгжилд цахим хэрэглэгдэхүүн нөлөөлөх нь” сэдвээр, 3-р байранд 166-р цэцэрлэгийн багш О.Оюунтуяа “Сургалтын хэрэглэгдхүүнээр дамжуулан хүүхдийн хөгжилд нөлөөлөх нь” сэдвээр илтгэл бичиж, тус тус шалгаран НИЙСЛЭЛ-ийн эрдэм шинжилгээний хуралд оролцох эрх авлаа. Өмнөх оныхоос амжилт үзүүлсэн багшийн тоо 2-оор нэмэгдсэн.</p> <p>“СӨББ-ын сургалтын орчны стандарт, хэрэгжүүлэх зөвлөмж”-ийн сургалтад 1 мэргэжилтэн, 7 арга зүйч хамруулан сургагч багшаар бэлтгэн, дүүрэгт сургалт зохион байгуулж, 65 цэцэрлэгийн 87 удирдлага, арга зүйч хамрагдан, байгууллагын түвшний сургалтад 65 цэцэрлэгийн 982 багш, ажилтан тус тус хамрагдаж, орчны стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийж байна. “Бага насны хүүхдийн хөгжлийн онцлог-сургалтын арга зүй” сургалтад 7 арга зүйчийн хамруулан, дүүрэгтээ түгээн дэлгэрүүлэх сургалт зохион байгуулж, нийт 51 цэцэрлэгийн арга зүйч, багшийн хамруулан сургалтын шинэ технологи арга зүйд суралцсан.</p> <p>-БСШУСЯ, Жайка ОУБ-ын хамтран зохион байгуулсан “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийн сургагч багш бэлтгэх 4 өдрийн сургалтад СӨБ-ын мэргэжилтэн хамрагдан, Онцгой байдлын хэлтэстэй хамтран дүүргийн хэмжээнд “Гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх “ 1 өдрийн сургалт дадлага зохион байгуулж, төрийн өмчийн цэцэрлэгийн 28 удирдлага хамрууллаа. 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар сургагч багшийн тоо 16-аар нэмэгдлээ.</p> <p>Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд:</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн XII ангийн сурагчдын сурлагын чанарт хяналт тавих, элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл хангах зорилгоор “Амжилтын гараа”1, 2 уралдаан зохион байгуулж, дүүргийн 2, 11, 45-р сургууль бусдыгаа түүчээллээ. 2018 оны 12 дугаар сард зохион байгуулагдах Амжилтын гараа 3, 4 уралдаанд оролцох 18 сургуулийн сурагчдыг 10 судлагдахуунаар гаргаж бэлтгэл ажил хийгдэж байна. Өмнөх тайлангийн үеэс 7 судлагдахуун нэмэгдэж, сургалтын чанарын хүртээмж нэмэгдэж байна.</p>					
2.2 Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжинэ								
23	2.2.1	НЗДҮАХ-ийн 4.6.2. дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.2.1 Залуучуудыг хотын соёлд суралцуулах сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён	Оюутан залуучуудад чиглэсэн эерэг хандлага, эрүүл оюутан, залуус сургалт уулзалт зохион байгуулна.	Нийт 500 оюутныг хамруулж, үр дүнд хүрсэн байна.	Коллеж, их дээд сургуулийн оюутан залуучуудын харилцаа хандлага, эрүүл мэндийн боловсрол дээшилсэн байна.	-	НХХ, ГБХЗХХ	100%

		гэгээрүүлэх ажиллагааг байгуулна.	үйл зохион	<p>-Өсвөр үе, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлж, хувийн ариун цэвэр халдварт өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, харилцааны зөв арга барил эзэмших, тулгамдаж буй асуудлаа оновчтой шийдвэрлэхэд нь дэмжлэг өгөх зорилгоор Ажилчин залуучуудын ээлжийн сургуулийн 10-12 дугаар ангийн нийт 50 сурагчдад “Өсвөр үе, залуучууд-ээрэг хандлага, эрүүл залуус, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол сургалт” зохион байгуулсан.</p> <p>-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Ирээдүйн эзэд” аяны хүрээнд ерөнхий боловсролын нийт 34 сургуулийн 10-12 дугаар ангийн 4500 сурагчид мэргэжил сонголтын талаар зөвлөгөө, заавар, мэдээлэл өгч ажилласан.</p> <p>-Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэдэх Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн “Жендэрийн боловсролыг олгох сургалт”-д ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 8-10 дугаар ангийн 118 сурагч, Сүхбаатар Дэвшил ОНӨААТҮГ-ын 72 ажилтан, албан хаагчдыг хамрууллаа.</p> <p>-Улаанбаатар дээд сургуулийн “Гэр бүл судлалын танхим”-ын багш, доктор профессор Т.Намжил, “Эрэгтэйчүүд ба гэр бүл” сэдвээр ҮБТДС-ийн 100 эрэгтэй оюутанд сургалт зохион байгуулсан.</p> <p>-Бичиг баримтгүй иргэдийн судалгааг үндэслэн, 13 иргэнийг бичиг баримтжуулахаар харьяа хорооны иргэний бүртгэл мэдээллийн ажилтанд мэдээлэл өгч, холбон зуучилсан.</p> <p>-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн алба, хамгааллын алба, Залуучуудын хөгжлийн төв хамтран Эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар анги дээр тус ангид хүмүүжиж буй 100 эмэгтэйд сэтгэл хөдлөл болон хорт зуршлил нь хүний зан үйл, бие махбод сэтгэлзүйд ямар нөлөө үзүүлдэг болох, найз нөхөд, гэр бүл, ойр дотны хүмүүст хэрхэн нөлөөлдөг талаар сургалт зохион байгуулсан.</p> <p>-2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр “Эрдэнэ тав баг” ТББ, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар, Хувь хүний хөгжлийн франклин клубтэй хамтран Улаанбаатар чуулгын их танхимд Хорт зуршлын үр нөлөө сургалтад МУБИС-ийн 630 оюутан хамруулан зохион байгуулсан.</p>				
24	2.2.2	НЗДҮАХ-ийн 4.5.8. дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.2.4. Гэр бүлийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	Зорилтот бүлгийн болон залуу гэр бүлүүдэд гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулна.	Нийт 500 гэр бүлийг хамруулна.	Гэр бүл төлөвлөлт, гэр бүлд бий болох эрсдэл, салалтаас урьдчилан сэргийлж, гэр бүлийн харилцаа хандлага, зан үйл, боловсролыг дээшлүүлсэн байна.	-	НХХ, ГБХЗХХ	100%
<p>-Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтран “Гэр бүлийн эрүүл харилцаа” сэдэвт сургалт зохион байгуулж, 17, 18-р хорооны нийт 25 гэр бүлийн 50 иргэнд “Хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн харилцаа”, “Хувь хүний зан төлөв, сэтгэлзүйн оношилгоо”, “Хосын харилцаа”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн хүрээнд сургалт мэдээлэл өгч, нээлттэй ярилцлага өрнүүлэн ажилласан.</p> <p>- “Гэр бүл-Угийн бичиг хөтлөх арга зүйг түгээн дэлгэрүүлэх нь” сэдэвт сургалтад 14, 15, 16, 17-р хорооны нийт 40 иргэн хамруулж, Монголын угийн бичгийн тэргүүн, Удам зүй судлаач, доктор Н.Түмэн-Өлзий “Угийн</p>								

			<p>бичиг гэж юу бэ? ” Угийн бичиг хөтөлсний ач тус”, “Цус ойртолт гэж юу бэ?” сэдвүүдийн хүрээнд мэдээлэл, угийн бичиг хэрхэн хөтлөх зааварчилгаа өгсөн.</p> <p>-ДЗМОУБ-тай хамтран “Хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх нь” сэдэвт сургалтыг дүүргийн төрийн болон төрийн өмчийн бус цэцэрлэгийн нийт 62 арга зүйч, багш нарыг хамруулан зохион байгуулсан.</p> <p>–“Дэлхийн Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Хас банкны 7 буудал дахь салбартай хамтран өдөрлөг зохион байгуулж, Дэлхийн “Гэр бүлийн өдөр”-ийн тухай, Иргэний үнэмлэхийн түүх, үүрэг, хариуцлагын тухай танилцуулга хийж, шинээр гэр бүл болсон 8 хосод гэрлэлтийн баталгаа, 16 настай 50 хүүхдэд иргэний үнэмлэх, шинэ төрсөн 5 хүүхдэд төрсний гэрчилгээ гардуулсан.</p> <p>-Ногоон хөгжил, Цэвэр агаар-Нэг мод хөдөлгөөн ТББ-тай хамтран “Ногоон дэлхий-бидний гэр бүл” сэдвийн дор айл бүр хашаандаа мод тарьж, арчилж ургуулахад чиглэсэн аргад суралцах, өрхийн аж ахуй эрхлэх боломжтой 6 хорооны нийт 30 хүнийг сургалтад хамрууллаа.</p> <p>- Монголчуудын угийн бичгийн академитай хамтран залуу гэр бүлүүдэд чиглэсэн “Угийн бичиг хөтлөх арга зүй” сургалтыг 1-20 дугаар хорооны 20 гэр бүл буюу 40 иргэнийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>- Аавуудын баярыг тохиолдуулан “Гэр бүлийн нандин харьцаа” сэдэвт сургалтыг 1-20 дугаар хорооны 50 аав хамруулан зохион байгуулж, гэр бүл дэх аавуудын оролцоо, үүрэг хариуцлагын талаарх нээлттэй яриг өрнүүлэн ажилласан.</p> <p>-Дүүргийн Цагдаагийн 2-р хэлтэстэй хамтран 2018 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр цагдаагийн албан хаагчийн ажил, амьдралын түшиг, тулгуур болсон гэр бүлд нь Гэр бүлийн нандин харилцаа сэдэвт сургалт, Миний хань цагдаагийн албан хаагч эсээ бичлэгийн уралдаан зохион байгуулан, нийт 90 албан хаагч гэр бүлийн хамт хамрагдсан.</p> <p>-2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр “Угийн бичиг хөтөлж, ургийн баяраа хийдэг гэр бүлийг шалгаруулах арга хэмжээ”-г Монголын Угийн бичгийн холбоотой хамтран зохион байгууллаа .</p>					
25	2.2.3	<p>ДЗДҮАХ-ийн 2.2.5 дахь заалт; Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг эрчимжүүлнэ.</p>	<p>Хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Сургуулийн нийгмийн ажилтан, хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарыг хамруулна.</p>	<p>Хүчирхийлэлд өртөлт багасаж, мэдээллийн сантай болсон байна.</p>	-	НХХ	100%
			<p>-Дүүргийн 1-20 хорооны Хөгжлийн бэрхшээлтэй 414 хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг нэгтгэв.</p> <p>-Хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийн судалгааг хороо бүрээр гаргаж, 215 хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлэв.</p> <p>-Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн ХурлынТэргүүлэгчдийн 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй дүүргийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-г шинэчлэн байгуулав.</p>					

		<p>-2018 оны “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хуулийн талаарх мэдээллийг 1-20 дугаар хороодын мэдээллийн самбар, 78 СӨХ-ны мэдээллийн самбар, 15 томоохон зах, худалдааны төвүүдэд байршуулан сургалт нөлөөллийн ажлыг 502 иргэдийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>-Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, сурталчилгаа нөлөөллийн 10 сургалтад хуулийг брошур, гарын авлага хэлбэрээр гарган 150 гэр бүлд хүргэн ажилласан.</p> <p>-ТВ9 телевизийн “Ардын парламент” 45 минутын хэлэлцүүлэг нэвтрүүлгээр Монголын Эрэгтэйчүүдийн холбооны тэргүүн н.Бадамцэцэг, Хуульч, өмгөөлөгч Ц.Энхтүвшин, СБЭМТөвийн өсвөр үеийн эмч Н.Мөнхжаргал, Гэр бүлийн радио 104.5 сэтгүүлч, продюсер н.Отгонбаатар, Гэр бүл судлаач А.Чинбат, ГБХЗХХ-ийн сэтгэлзүйч Б.Батчимэг нар “Өрх гэртээ аавуудын оролцоо ямар байх вэ? “Аавуудын тэжээн тэтгэх, чиглүүлэн удирдах, хамгаалах үүргүүдийн талаар” ярилцан олон нийтэд хүргэсэн.</p> <p>- Цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” сэдвээр 9, 16, 18 дугаар хорооны 72 иргэдэд сургалт, 10, 20 дугаар хорооны 150 иргэдэд нөлөөллийн ажил зохион байгуулсан.</p> <p>- Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг түгээх ажлыг 1-20 дугаар хороодын 78 СӨХ болон 15 томоохон худалдаа үйлчилгээний төвүүдээр мэдээллийн самбарт мэдээлэл нөлөөллийн ажлыг хийж иргэдэд мэдээлэл хүргэн ажиллалаа.</p>						
26	2.2.4	<table border="1" data-bbox="734 783 2089 1066"> <tr> <td data-bbox="734 783 1070 1066">Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.</td> <td data-bbox="1070 783 1301 1066">1-20 хорооны гэр бүлүүд, хэсгийн ахлагч, СӨХ-ийн жижүүрүүдэд сургалт зохион байгуулах төлөвлөгөө гаргана.</td> <td data-bbox="1301 783 1637 1066">Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдал дээшилсэн байна.</td> <td data-bbox="1637 783 1812 1066">-</td> <td data-bbox="1812 783 1977 1066">НХХ</td> <td data-bbox="1977 783 2089 1066">100%</td> </tr> </table> <p>-Нийслэлийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар, Дэлхийн зөн Монгол ОУБ, Сэргээн засах согог судлалын үндэсний төвтэй хамтран Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтнүүд, 20 хорооны нийгмийн ажилтнуудыг “Дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт”-д хамрууллаа.</p> <p>-Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн эрүүл харилцаа” сэдэвт сургалтад 17,18 дугаар хорооны 25 гэр бүл буюу 50 иргэнийг хамруулж, “Хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн харилцаа”, “Хувь хүний зан төлөв, сэтгэлзүйн оношилгоо”, “Хосын харилцаа”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн хүрээнд мэдээлэл өгч, нээлттэй ярилцлага өрнүүлэн ажилласан.</p> <p>-Дүүргийн 1-20 дугаар хорооны өрх толгойлсон 3099 эцэг, эх, 15-35 насны 44776 залуучуудын дэлгэрэнгүй судалгааг шинэчиллээ.</p>	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.	1-20 хорооны гэр бүлүүд, хэсгийн ахлагч, СӨХ-ийн жижүүрүүдэд сургалт зохион байгуулах төлөвлөгөө гаргана.	Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдал дээшилсэн байна.	-	НХХ	100%
Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.	1-20 хорооны гэр бүлүүд, хэсгийн ахлагч, СӨХ-ийн жижүүрүүдэд сургалт зохион байгуулах төлөвлөгөө гаргана.	Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдал дээшилсэн байна.	-	НХХ	100%			

			<p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/26, 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/51 дугаар захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/24 тоот тушаалын дагуу дүүргийн Алдарт эхийн I, II зэргийн одонтой 7175 эхчүүдэд хүндэтгэл үзүүлж, Түмэн эх чуулга, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын тоглолт сонирхуулан, гарын бэлэг гардуулав.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/54 тоот захирамжаар залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг дүүргийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий “Залуучуудын салбар зөвлөл”-ийг шинэчлэн байгуулав.</p> <p>-Нийслэлийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар, Сэтгэлийн өнгө сэтгэл зүйн төвтэй хамтран “Эерэг хандлага, ач холбогдол” сэдэвт сургалт зохион байгуулж, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн, 20 хорооны нийгмийн ажилтан хамрагдав.</p> <p>-Нийгмийн ажил үйлчилгээг үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан оновчтой, зөв хүргэх онол, арга зүйн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтанд Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургуультай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний дагуу хорооны 13 нийгмийн ажилтан хамрагдаж, сертификаттай боллоо.</p> <p>-Дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэн, ДЗМОУБ-тай хамтран “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга замууд, хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийг танилцуулах, Хүүхдийн эрх ба аюулгүйн дүрэм, тэдний гэр бүл, орчны оролцоо, Харилцааны сэтгэл зүй сэдвүүдээр чадавхжуулах сургалтыг дүүргийн 1-20 дугаар хороодын 176 хэсгийн ахлагч нарт зохион байгууллаа.</p> <p>-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан дүүргийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/171 дүгээр захирамжаар “Хүүхдийн ертөнц” өдөрлөг зохион байгуулж, 1-20 хорооны хүүхдүүдэд “Хүүхдийн ертөнц” урлагийн тоглолт, циркийн үзүүлбэр, хэн сайн жолоодох вэ уран жолоодлогын тэмцээн, номын үзэсгэлэн, худалдаа зэрэг үйлчилгээ үзүүллээ. Өдөрлөгийн үеэр хөгжлийн бэрхшээлтэй 414 хүүхэд, бүтэн өнчин 10 хүүхэд, ихэр 40 хүүхдэд бэлэг гардуулав.</p> <p>-Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Туркийн Улаан хавирган сар нийгэмлэг, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн хамтын ажиллагааны хүрээнд зорилтот бүлгийн 100 өрхийн бүтэн өнчин хүүхдэд хүнсний багцын дэмжлэг үзүүлж, МУЗН-ийн үйл ажиллагаа, Төр-Улаан Загалмайн хамтын ажиллагаа, дүүргийн Улаан загалмайн хорооны үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах өдөрлөг зохион байгууллаа.</p> <p>-Дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэстэй хамтран Цагдаагийн албан хаагчийн ажил, амьдралын түшиг, тулгуур болсон гэр бүлд нь нандин харилцааг эрхэмлэхийн ач тусыг ойлгуулах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, ажил үүргийн онцлогийг таниулах зорилготой “Гэр бүлийн нандин харилцаа” сэдэвт сургалт, өдөрлөг зохион байгуулан алба хаагчдын аав ээж, хань ижил, үр хүүхэд нийт 180 гаруй зочид оролцож, гэр бүлийн боловсролын талаарх мэдлэг боловсролоо нэмэгдүүллээ.</p>				
27	2.2.5	Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргийн гаралт буурсан байна.	1 380 000	ЦХ-1, 2	100%
<u>Цагдаагийн 1 дүгээр хэлтэс:</u>							

		<p>2018 онд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд :</p> <p>- Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2018 оны 1 дүгээр улиралд “Хуулиа мөрдье-21” үндэсний аян, “Сэрэмжилье-нэгдье”, “Хуулийн хэрэгжилт” 1, 2, 3, 2 дугаар улиралд “Хүүхэд хамгаалал”, “Эрдмийн баяр”, “Бяцхан зорчигч”, “Хүчирхийлэлгүй гэр бүл”, “Хяналт-1”, “Хараа хяналтгүй хүүхэд 1, 2, 3”, “Сургалт-мэдээлэл”, “Захидал”, “Цахим тоглоомын газар-1, 2, 3” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг нийт 21 удаа хариуцсан нутаг дэвсгэртээ зохион байгуулж дээрх арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор ерөнхий боловсролын сургуулийн сурагч 25260, Оюутан-13700, эцэг, эх, асран хамгаалагч 11600, багш, нийгмийн ажилтан 465, иргэн 87650, нийт 919 төрийн болон, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг татан оролцуулж цахим мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бусад хэлбэрээр иргэд олон нийтэд нөлөөллийн үйл ажиллагааг үзүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцууллаа.</p> <p>“Эмзэг цэг- хяналт шалгалт” арга хэмжээний хүрээнд 2018 оны турш дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуй нэгж, байгууллагуудад дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтарч 4 удаа хяналт шалгалтыг зохион байгуулан хамтран ажиллах, согтуугаар үйлдэгддэг гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор 2 удаа хэлтсийн хурлын зааланд мэдээлэл, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд архи согтууруулах ундаа худалдан борлуулж түүгээр үйлчилдэг давхардсан тоогоор 253 байгууллага аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон.</p> <p>2018 онд гэр бүлийн хүчирхийллийн 954 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс 277 дуудлагыг алба хаагч нарт цохолтыг хийж шалгуулсан, давхардсан дуудлага 294, татгалзсан-134, шүүхээр баривчлуулсан-36, зөрчлийн хэрэг нээн шалгасан-147 байна.</p> <p>- Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийллийн мэдээ мэдээллийг хэрхэн өгөх талаар хэсгийн ахлагч 46, урамшилт эргүүлийн ажилтан 50 иргэнд, хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр 1-8 дугаар хорооны нийгмийн ажилтнуудад, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй архины хамааралтай-12 иргэнд шинээр батлагдсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн талаар, байгууллагын аюулгүй байдлыг хангах, шинээр батлагдсан хууль тогтоомжийг тайлбарлан таниулах зорилгоор 18 байгууллагын 648 ажилтан нийт 2 хэлэлцүүлэг, 154 албан тушаалтан, 26222 иргэнд сургалт яриа таниулгыг зохион байгуулсан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг 2017 онд 18 гарсан бол 2018 онд 19 гарч 5,5 хувиар буюу 1 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Хүүхэд оролцсон хэрэг 2017 онд 36 бүртгэгдсэн бол 2018 онд 24 болж 12 нэгжээр буурсан байна. Хүчирхийлэлийн улмаас үйлдэгдсэн зөрчил 2018 эхний 10 сард 74, зөрчилд хүүхэд оролцсон 4 тохиолдол бүртгэгдсэн байна.</p> <p>2017, 2018 онд хөрөнгө зарцуулагдаагүй.</p> <p><u>Цагдаагийн 2 дугаар хэлтэс:</u></p> <p>2018 онд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд :</p> <p>-Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлье”, “Гэр бүлийн эрүүл харилцаа” “Хараа хяналт”, “Албадан эмчилгээ”, “Хамтарсан баг” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг нийт 15 удаа зохион байгуулж, 2500 иргэд, багш, ажилчдыг хамруулсан.</p>
--	--	---

			<p>-Дүүргийн прокурорын газар, мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн захирал, эрхлэгч, худалдагч, зохион байгуулагч зэрэг 150 иргэнд Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг сурталчилж, “Архины хор хөнөөл”, “Гэр бүлийн хүчирхийллийн ойлголт” зэрэг сэдвээр яриа таниулга 1 удаа хийсэн.</p> <p>-Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран “Гэр бүлийн эрүүл харилцаа” сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд дүүргийн 9-20 дугаар хорооны эрсдэл бүхий 33 гэр бүл буюу 50 иргэнд “Гэр бүлийн хүчирхийллийн ойлголт, хамаарах этгээд” болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн талаар тайлбарлан таниулга хийж, хорооны хэсгийн байцаагч, хамтарсан багийн хяналтанд өгч, зөрчлийн хэрэг нээсэн 56 иргэнийг баривчлах шийтгэл оногдуулсан.</p> <p>-Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг төрийн 25 байгууллага, хувийн хэвшлийн 150 аж ахуйн нэгжийн 2500 ажилтан алба хаагч нарт гэр бүлийн хүчирхийлэлийн хор уршгийг тайлбарлан таниулах, гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн холбогдох зүйл заалтуудаар хууль эрх зүйн яриа таниулга хийн, нийслэлийн цагдаагийн газраас бэлтгэсэн 350 ширхэг санамж сэрэмжлүүлэг тараан ажилласан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр үйлдэгдсэн энэ онд 29 гэмт хэрэг бүртгэгдсэн урьд оны мөн үетэй харьцуулахад 12.1 хувиар буурсан байна.</p>					
28	2.2.6	<p>НЗДҮАХ-ийн 4.5.5 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.2.6</p> <p>Хорооны хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулж, хараа хяналтгүй болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг шуурхай хамгаалах үйлчилгээг сайжруулна.</p>	Хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийг илрүүлэх нэгдсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх арга хэмжээг улирал бүр зохион байгуулж, хамтарсан багийн үйлчилгээ үзүүлж ажилласан байна.	-	НХХ, ГБХЗХХ	100%
			<p>-2018 оны 01 дүгээр сарын 16,17,18-ний өдрүүдэд Дохионы хэлний сургалт"-д 1-20 дугаар хорооны нийгмийн ажилтнууд хамрагдсан.</p> <p>- 2018 оны 02 дугаар сарын 08, 09-ны өдрүүдэд хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх арга хэмжээ зохион байгуулж, нийт 12 хүүхдийг илрүүлэн, гэр бүлд нь хүлээлгэн өгч, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>- 2018 оны 04 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд хорооны болон сургуулийн нийгмийн ажилтан нийт 70 хүнийг хамруулан “Сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө өгөх чадавх бэхжүүлэх хүүхдийн хүмүүжлийн эерэг аргыг түгээх нь” сэдэвт сургалт зохион байгуулан чадавхжуулсан.</p> <p>- 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх арга хэмжээний үеэр нийт 5 хүүхдийг илрүүлэн асран хамгаалагч болон түр хамгаалах байранд хүлээлгэн өгсөн.</p> <p>- 2018 оны 05 сарын 03-ны өдөр 1-20 дугаар хорооны нийт 180 хэсгийн ахлагчдыг бодит кейс мэдээлэлд тулгуурлан ажиллуулж, практик туршлагыг нэмэгдүүлэн, Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга замууд,</p>					

			<p>хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийг танилцуулан кейс ажиллуулах, хүүхдийн эрх ба аюулгүйн дүрэм, тэдний гэр бүл, орчны оролцоо, харилцааны сэтгэл зүй сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулав.</p> <p>- 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдөр дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх, илрүүлэлтийн ажлыг 08:00-22:00 цагийн хооронд 15 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, нийт 8 хүүхдийг илрүүлэн, холбогдох байгууллага, ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажилласан.</p> <p>-ГБХЗХХ, дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс хамтран хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх арга хэмжээг 3 удаа зохион байгуулж, 25 хүүхдийг илрүүлэн, гэр бүлд нь зөвлөгөө өгч, ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажилласан.</p> <p>- Асуудал ба шийдэл хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих жилийн аяныг хэрэгжүүлэн дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <p>- 2018 оны 05 дугаар сарын 24-ны өдөр хүүхдийн тусламжийн утас 108, хүүхэд хамгааллын байрны үйл ажиллагаатай 1-20 дугаар хорооны хамтарсан багийн гишүүд танилцан, харилцан мэдээлэл солилцох туршлага хуваалцан ажилласан.</p> <p>- 2018 оны 09-10 сард Асуудал шийдэл аяны хүрээнд илтгэлийн уралдаан зохион байгуулан хэлэлцсэн. Мөн ур чадварын тэмцээнд 5 дугаар хорооны хамтарсан баг амжилттай оролцсон.</p> <p>- 2018 оны 10 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд 1-20 хороодын хамтарсан багийн гишүүдийг чадахжуулах сургалтыг зохион байгуулан, хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчилсан кино нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэж ажилласан.</p> <p>- Дүүргийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 2018 оны 11 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд нутаг дэвсгэрийн хэмжээнд Хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийг илрүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа.</p>					
2.3 Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг сайжруулна								
29	2.3.1	НЗДҮАХ-ийн 4.1.9 дахь заалт, ДЗДҮАХ-ийн 2.3.4 дэх заалт: Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн орчныг сайжруулна.	“Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж, сургалт зохион байгуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	“Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд туршлага солилцох уулзалт, ажлын байран дах сургалтыг 2 удаа зохион байгуулна.	Хөтөлбөр хэрэгжүүлэгч 10 аж ахуйн нэгж хоол үйлдвэрлэлийн стандарт, шаардлагыг хангаж ажилладаг болсон байна.	-	ХХҮХ	100%
			Нийслэлийн нийгмийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаагийн 2018 оны 02 дугаар сарын 28-ний өдөр баталсан удирдамжийн дагуу нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн цайны газрын үйл ажиллагаанд					

			<p>хяналт, үнэлгээ хийх ажлыг 2018 оны 03 сарын 05-ны өдрөөс 16-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дүүргийн ЗДТГ-ын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Боловсролын хэлтэс, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Хоол шим тэжээлийн үндэсний нийгэмлэгийн гишүүд орж, нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Шалгалтад үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж буй дүүргийн Ерөнхий боловсролын нийт 35 сургууль хамрагдахаас 34 сургуулийн цайны газрыг хамрууллаа. Шалгалтын дүнг танилцуулах, мөн Үдийн цай хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй сургуулиудын туршлагыг таниулах, сурталчлах зорилгоор дүүргийн Боловсролын болон Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудад дүүргийн 131, 58, Орос Монголын хамтарсан 3 дугаар сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах “Ерөнхий боловсролын сургуулиудын үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, цайны газрын үйл ажиллагаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” сэдэвт үзүүлэх сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Сургалтад дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 25 сургуулийн дотоод хяналтын ажилтан, нийгмийн ажилтан, цайны газрын захирлууд, тогооч нар хамрагдаж, харилцан туршлага солилцож, цайны газрын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, “Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмж”-ийн талаарх мэдээллүүдийг олж авлаа.</p> <p>Сургалтын дараа “Үдийн цай” хөтөлбөрт хяналт шалгалт хийсэн ажлын хэсэг шалгалтын тайлан мэдээг танилцуулж, цаашид анхаарах зүйл, авах арга хэмжээний талаар танилцууллаа.</p> <p>Сүхбаатар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын баталсан “Ерөнхий боловсролын сургуулиудын хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 2018.10.08-15-ны өдрүүдэд тус хэлтсийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ц.Отгонбор, Хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч Б.Өлзийбаяр нартай хамтран хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтад 24 сургууль, сургуулийн ойр орчимд хүнсний худалдаа эрхэлж буй 2 ААН, 1 иргэн хамрагдсан.</p> <p>Шалгалтад хамрагдсан сургуулиудын 86 хувь нь бага ангийн сурагчдын хоолны хэрэгсэл /аяга, халбага/ цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийг шаардлагын хэмжээнд хийдэг, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан ашиглалт хэвийн, 14 хувь нь сурагчид хоолны хэрэгслийг гэрээсээ зөөвөрлөн авчирч хэрэглэдэг байна. Шалгалтын явцад агуулахын зай талбай бага, засвар үйлчилгээ хийх, агааржуулах хоолойг засан сайжруулах зэрэг нийтлэг зөрчил илэрч байна. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.</p>					
30	2.3.2	ДЗДҮАХ-ийн 2.3.7 Залуу багш, удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, дотоодын болон гадаад улс орнуудын туршлагаас судлуулж хөгжүүлэхэд анхаарч ажиллана.	БНСУ, БНХАУ, Япон улс, ХБНГУ-тай харилцан туршлага солилцох сургалт, аялалд хамруулна.	Нийт багшийн 3%-ийг хамруулна.	Дотоодын болон гадаад улс орнуудтай хамтын ажиллагаа нэмэгдсэн байна.	-	НХХ, БХ	100%
			Орос хэлийг дэмжих жил болгон зарласантай уялдуулан ОХУ-ын Эрхүү хотын Шелехов дүүрэгтэй хамтын ажиллагаа эхлүүлсэн. Боловсролын хамтын ажиллагааны хүрээнд 3 мэргэжилтэн, 135, 166-р цэцэрлэгийн 2 эрхлэгч, 35 болон Спортын дунд сургуулийн 2 захиралын бүрэлдэхүүнтэй баг, мөн 135,166-р цэцэрлэг, 35-р сургуулийн нийт 20 багш, удирдах ажилтны бүрэлдэхүүнтэй баг тус тус Шелехов дүүргийн сургууль,					

			цэцэрлэгтэй танилцаж туршлага судлах аялалд хамрагдав. Япон улсын Саппоро хотын боловсролын газар, сургууль, цэцэрлэгийн менежмент, насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцох Нийслэлийн багийн бүрэлдэхүүнд Боловсролын хэлтсийн дарга оролцсон. Дүүргийн төрийн өмчийн 25 сургуулийн 100 удирдах ажилтаны мэргэжил боловсролыг дээшлүүлэх туршлага солилцох ажлын хүрээн “Удирдах ажилтныг чадавхжуулах нь” сургалт МОХС дээр тус сургуулийн захирал, Доктор Ж.Соронзонтой хамтарч зохион байгуулав. Энэ нь удирдлагын арга барилыг сургуулийн дотоод хяналт хийх менежментэд чухал аргачлал болов. Өмнөх онтой харьцуулахад гадаад хамтын ажиллагаанд хамрагдсан багш, ажилтны тоо 50%аар нэмэгдсэн байна.					
2.4 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.								
31	2.4.1	НЗДҮАХ-ийн 4.4.6 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.4.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжинэ.	Өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр хичээллүүлж, тэмцээн уралдаанд оролцох нөхцөлөөр хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Өсвөрийн шигшээ баг тамирчдыг дэмжин, улс, нийслэлийн тэмцээн уралдаанд оролцуулж, амжилт гаргасан байна.	-	НХХ, БТСХ	100%
			<p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/29 дүгээр захирамжаар Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийг шинэчлэн байгуулж, спортын 10 төрөл /шатар, зуун буудалт даам, ширээний теннис, дугуй, хөлбөмбөг, сагсан бөмбөг, чөлөөт бөх, жүдо бөх, тэшүүр, гандбол/-өөр хичээллүүлж байна.</p> <p>-Дүүргийн нэрэмжит Зуун буудалт даамны өсвөрийн шигшээ багуудын 2018 оны аварга шалгаруулах тэмцээнд 6 дүүргийн 72 тамирчин оролцсон. Дүүргийн өсвөр үеийн Шатрын аварга шалгаруулах 2018 оны тэмцээнд нийт 15 сургуулийн 270 тамирчин 6 насны ангиллаар оролцлоо.</p> <p>-Дүүргийн өсвөр үеийн Ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээнд нийт 17 сургуулийн 68 тамирчин 4 насны ангиллаар оролцов.</p> <p>-Зуун буудалт даамны аварга шалгаруулах тэмцээнд нийт 12 багийн 48 тамирчин 6 насны ангиллаар оролцлоо.</p> <p>-ЕБС-ын сурагчдын дунд 3х3 Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 11 багийн 110 тамирчид өрсөлдөж, шилдгүүдээ шалгарууллаа.</p> <p>-Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжих зорилгоор дүүргийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/287 захирамжийн дагуу Монголын сагсан бөмбөгийн холбоотой хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Аварга анги 3х3” сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, нийт 11 багийн 110 тамирчид өрсөлдөж, шилдгүүдээ шалгарууллаа.</p> <p>-Дүүргийн өсвөр үе, залуучуудын аварга шалгаруулах Уулын дугуйн тэмцээнд 6 байгууллагын 70 гаруй дугуйчид 4 насны ангилалд хурд хүч, авьяас чадвараа сорин өрсөлдлөө.</p> <p>-Дүүргийн "Ихэр бээлий" боксын клубын нэрэмжит олон хотын аварга шалгаруулах боксын нээлттэй тэмцээнд Монгол, Орос, Казахстаны 27 багийн 170 гаруй өсвөрийн тамирчид авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. Тус тэмцээн зохион байгуулагдахтай холбогдуулан "Олимпиус" спорт барааны төрөлжсөн дэлгүүрээс боксын хэрэглэл материал бэлэглэлээ.</p>					

32	2.4.2		"Сүхбаатар залуус" хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн хэмжээнд ахлах ангийн 3400 гаруй сурагчдыг хамруулсан байна.	-	ТГХШХ НХХ	70%
-Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжих зорилгоор дүүргийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/287 захирамжийн дагуу Монголын сагсан бөмбөгийн холбоотой хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Аварга анги 3x3" сагсан бөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, нийт 11 багийн 110 тамирчид өрсөлдөж, шилдгүүдээ шалгарууллаа.								
33	2.4.3	<p>"Хүн амын хоол тэжээл" үндэсний хөтөлбөрийн 4.1.6 дахь заалт; Зохистой хооллолтын талаарх зөвлөмжид нийцсэн тэжээллэг, аюулгүй хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ. ДЗДҮАХ-ийн 2.4.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг бүрэн хангахад чиглэгдсэн арга хэмжээ, туршлагыг нэвтрүүлж, аюулгүй орчин бий болгоно.</p>	Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний "Загвар" төслийг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлнэ.	ЕБС-ийн хоол үйлдвэрлэлийн газруудыг жишиг стандарттай 58-р сургуулийн цайны газартай туршлага солилцох сургалтад хамруулж, жишиг стандарттай сургуулийн цайны газрын тоог нэмэгдүүлнэ.	Ерөнхий боловсролын сургуулийн 3-5 хоол үйлдвэрлэлийн газрыг жишиг стандартын хэмжээнд хүргэсэн байна.	-	ХХҮХ	100%
<p>Ерөнхий боловсролын 2, Монгол 3, 6 дугаар сургуулийн "Үдийн цай" хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийг жишиг стандарттай болгох ажлыг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд эхний ээлжинд дээрх аж ахуйн нэгжүүдийг 58 дугаар сургуулийн цайны газрын үйл ажиллагаатай танилцуулж туршлага солилцох сургалтад хамрууллаа.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Сургалт зохион байгуулах тухай А/324 дугаар захирамж, А/96 дугаар тушаалаар 400.000 төгрөгийг шийдүүлэн дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Хоолзүй, шим тэжээлийн үндэсний нийгэмлэгтэй хамтран 2018 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд цэцэрлэгийн 82, сургуулийн 68 тогооч нийт 150 гаруй тогооч нарт "Бага насны хүүхдийн хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал" сэдэвт сургалт зохион байгуулж, тогооч нарт хоолны илчлэг тооцох аргыг заан дасгал ажиллуулж ур чадвар олголоо.</p> <p>"Хоол зүй шим тэжээлийн үндэсний нийгэмлэг"-ийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн сургалтад 2, 3, 6 дугаар сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газруудын 6 тогоочийг хамруулан хүүхдийн</p>								

			шим тэжээллэг хоол хийх, илчлэг нормыг тооцох аргачлал бүхий “сертификат” олгох сургалтанд хамруулан мэргэшүүллээ. Сургалтад хамрагдаж мэргэшсэнээр сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар дээшилж, хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон хоолор үйлчилж хүүхдэд олгож буй хоолны шим тэжээллэг чанар нэмэгдэх боломж бүрдэх юм.					
34	2.4.4	ДЗДҮАХ-ийн 2.4.6 Хүүхдийн аюулгүй орчны зураглал гаргаж сургууль, цэцэрлэг бүрд хэрэгжүүлнэ.	Цэцэрлэг бүр аюулгүй орчны зураглал гаргах ажлыг эхлүүлнэ.	Хүүхдийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.	Цэцэрлэг бүр аюулгүй орчны зураглалтай болсон байна.	-	НХХ, БХ	100%
			Төрийн өмчийн 33 цэцэрлэгээс 26 цэцэрлэг аюулгүй орчны зураглал гаргаж, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх тэмдэглэгээ хийж, ирэлт-таралтын үеэр эргүүл гарган ажиллуулж байна. Энэ ажил төрийн өмчийн цэцэрлэгийн 65%-ийг эзэлж байна. “Ананда” Олон улсын байгууллагын санхүүжилтээр “Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид орчинг дэмжих нь” 3 жилийн хугацаатай хэрэгжиж байгаа төслийн сургалтад мэргэжилтэн, 2 арга зүйч хамрагдан, сургагч багшаар бэлтгэв. Төслийн хүрээнд 171, 175, 205, 226-р цэцэрлэгийн 26 багш, 45 эцэг, эх, 56 хүүхдийг 2 удаагийн сургалтад хамруулж, бага насны хүүхэд өөрийгөө хэрхэн хамгаалах аргад суралцсан. Монголын эцэг эхчүүдийн үндэсний зөвлөл төрийн бус байгууллагатай хамтран Эрдмийн хөтөч 58 цогцолбор сургуулийн орчны судалгаа шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх, төлөвлөлтийн болон санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр санал зөвлөмж боловсруулах ажлыг эхлүүлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын эрсдэлийн 5 багц үнэлгээ хийгдсэн. Өмнөх онтой харьцуулахад боловсролын салбарт орчны аюулгүй байдалд үзлэг шинжилгээ хийх, эрсдлийг бууруулах арга хэмжээ авах ажлын явц, үр дүн сайжирсан. 2.5 Хүүхэд, эцэг эх багшийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.					
35	2.5.1	ДЗДҮАХ-ийн 2.5.1 Цэцэрлэгт “Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв” байгуулж, эцэг эхчүүдийг хүүхэдтэй ажиллах арга зүйд сургах ажлыг эхлүүлнэ.	1 дүгээр цэцэрлэгийн “Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв”-д шаардлагатай, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, ном гарын авлагаар хангана.	Дүүргийн хэмжээнд “Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төвтэй болно.	Цэцэрлэг бүр “Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв”-тэй болсон байна.	-	НХХ, БХ	100%
			Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв байгуулсан 1, 14, 25, 68, 130, 135, 159, 171, 186, 225-р цэцэрлэгүүд /10/, өөр өөрөөнд хамтатгасан хэлбэрээр 2, 16, 17,24, 36,40, 42 , 51, 54 , 6975, 109, 130 143, 149, 150, 160,166, 175, 205, 216, 217, 234-р цэцэрлэг /22/ ажиллаж байна. Төвөөр дамжуулан хүүхдийн хүмүүжлийн талаарх зөвлөгөө зөвлөмжийг өгөх, хүүхдийн насны онцлогийн талаарх ном, сэтгүүл, гарын авлага бүхий номын сангаар үйлчилж байна. “Эцэг, эхэд зөвлөгөө өгөх төв”-ийг ажиллуулснаар залуу гэр бүлд хүүхдийн хүмүүжлийн талаар тулгамдсан асуудыг шийдвэрлэх, хүмүүжлийн эерэг аргыг дэлгэрүүлэх, залуу гэр бүлд туслах сургалтуудыг зохион байгуулж байна.					
36	2.5.2	ДЗДҮАХ-ийн 2.5.2	Суурь боловсролын шатанд “Суралцах	Эцэг эх, суралцагчид	100 багш энэ чиглэлээр сургалтад хамрагдаж	-	НХХ, БХ	100%

		Сургуульд “Мэргэжил сонголтын зөвлөх үйлчилгээний төв” байгуулж, сурагчдыг ажил, мэргэжлээ зөв сонгоход зөвлөн туслах үйлчилгээг нэвтрүүлнэ.	чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” талаар зөвлөн туслах үйлчилгээг хэрэгжүүлж, суралцагчдын мөрөөдлийг бүтээх аргачлал модуль сургалт зохион байгуулна.	ажил мэргэжлийн чиг баримжааны аргачлалд суралцана.	суралцагч, эцэг эхэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх чадвартай болсон байна.				
			<p>-“Ирээдүйн Эзэд” мэргэжил сонголтын аяны хүрээнд 2018 оны 03 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд 23 сургуулийн 10-12 дугаар ангийн 5500 сурагчдад мэргэжил сонголтын талаар зөвлөн туслах уулзалтыг төгсөх ангийн сурагчдын эцэг, эхэд зохион байгуулж, ЭЕШ-ны бүртгүүлсэн байдалд хяналт тавьж чиглэл өгч ажиллалаа.</p> <p>-2017-2018 оны хичээлийн жилд дүүргийн төрийн, төрийн бус өмчийн сургуулийн 8 дугаар ангийн 2768, 9 дүгээр ангийн 2741 сурагчдад суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гарын авлага танилцуулж судлуулах, төлөвлөгөөний хуудас бөглүүлэх замаар мэргэжил сонголтын зөвлөх үйлчилгээний нэг хувилбарыг хэрэгжүүлэв.</p> <p>-Ахлах ангийн сурагчдын дунд “Мэргэжил бүхэн сайхан” аян зохион байгуулж, аяны хүрээнд сургууль бүрт захирлын тушаалаар мэргэжил сонголтын зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх Ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн ажлын үр дүнг захирлуудын шуурхай хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>-“Сурагчдын хүсэл мөрөөдөлд тулгуурлан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга зүй”-н модуль боловсруулж, 16, 35 дугаар сургуулийн нийт 113 сурагчид сургалт зохион байгуулсан. “Монгол хүүхдийн Мөрөөдлийн газрын зураг бүтээх” туршлага нийслэлийн түвшинд шалгарч, нийслэлийн 2018 оны бүтээлч ажлаар батламжлагдсан. Сургууль бүр сургалтын шинэчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлж, мэргэжил сонголтын зөвлөн туслах үйлчилгээний төв байгуулахад чиглэсэн сургалтыг Монголын оюутны холбоотой хамтран зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.</p>						
37	2.5.3	НЗДҮАХ-ийн 4.5.4 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.5.4 Өсвөр насны хүүхдүүдийн Эрүүл мэндийн боловсролд анхаарч халдварт өвчин, хорт зуршлаас урьдчилан сэргийлж ажиллана.	Өсвөр насны хүүхдүүдэд “Хорт зуршлын эсрэг” аяныг зохион байгуулна.	Өсвөр үеийнхэнд архи, тамхи, мансууруулах бодис, цахим орчны сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийг үе шаттай зохион байгуулна.	Нийт 300 хүүхдийг хамруулсан байна.	-	НХХ, ГБХЗХХ	100%	

		<p>-Дүүргийн ГБХЗХХ, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран цахим тоглоомын 29 газарт хяналт шалгалт хийж, хүүхдэд үйлчлэх журмыг танилцуулсан.</p> <p>-“Хуулиа мөрдье-21” аяны хүрээнд ерөнхий боловсролын 71 дүгээр сургуулийн 50 сурагч, 58 дугаар сургуулийн 100 сурагч, МУИС-ийн 70 оюутныг хамруулан “Архи согтууруулах ундаанаас татгалзах, хор хөнөөлийг нь ойлгуулж, архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулиа дагаж мөрдөх, дүрэм журмын талаарх мэдээллийг түгээх зорилгоор "Архи, тамхины хор уршиг" сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургууль, цэцэрлэг, хороо, дэлгүүр үйлчилгээний газруудад сэрэмжлүүлэг хуудас нааж байршуулан ажилласан.</p> <p>-Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран 31, 45 сургуулийн нийт 140 сурагчид “Цахим тоглоом ба донтолт” сэдвээр сургалт зохион байгууллаа.</p> <p>-Дүүргийн Эрүүл мэндийн төв, ӨЭМТ хамтран архи, тамхи, мансууруулах бодис, цахим орчны сөрөг нөлөөллийн талаар 2 удаа сургалт зохион байгуулж, 56 хүүхэд хамруулсан. ЕБС-ийн 956 эрэгтэй хүүхдээс “Тамхины хэрэглээг илрүүлэх” судалгаа авч, дүнг нэгтгэв.</p> <p>-Цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран Хорт зуршлаас татгалзъя сургалтыг 16 дугаар сургуулийн 280 хүүхэд, 70 эцэг эхэд зохион байгуулав.</p> <p>-Шингэрүүлсэн шатдаг хий /газ/ тусгай арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран ажиллаж, эрсдэлт нөхцөл бүхий хүүхдүүдийн судалгаа мэдээллийг нэгтгэн, хүүхэд хамгааллын чиглэлээр хамтарсан багийн хяналтад авч, үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.</p> <p>-“Дэлхийн тамхигүй өдөр”, “Мансууралтай тэмцэх олон улсын өдөр”-ийг хүрээнд өсвөр үе, залуучуудын дунд архи, тамхины хор уршиг, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хор уршгийг таниулах, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ЗДТГ, ЭМТ, 15-18 дугаар хорооны ӨЭМТ-үүд хамтран “Тамхи зүрхэнд хортой- тамхи биш эрүүл мэндийг сонгоё” өдөрлөг зохион байгуулж, 250 хүний артерийн даралтыг, 50 хүний биеийн жингийн индексийг тодорхойлж, “Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэг”-ийн үйлчилгээний мэдээллийг 52 хүнд, эрүүл зан үйл төлөвшүүлэх 38 төрлийн 600 гаруй сурталчилгааны материал тараан давхардсан тоогоор 678 хүн хамрагдсан.</p> <p>-ҮУПК, Чингис хаан дээд сургууль, ШУТИС-ийн оюутны 1-р дотуур байр, МУИС-ийн оюутны 1, 2, 3, 5-р дотуур байр, Хэл иргэншил, Сити, Биеийн тамирын дээд сургууль, МУБИС-ийн 528 оюутанд БЗДХ, Архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, “Эрүүл оюутан хөгжлийн түүчээ” аяны хүрээнд сургалт зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлсэн.</p> <p>“Хорт зуршлын эсрэг аян”-ы үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан өсвөр үе, залуусын дунд архи, тамхи, хар тамхи, мансууруулах бодисын хор уршгаас сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилготойгоор 4-р сарын 11-5 дугаар сарын 31-ны өдрүүдэд “Хорт зуршлын эсрэг хамтдаа” өсвөрийн залуу зохион бүтээгчидийн лаборатори ахлах сургууль, ЕБ-ын 45, 2, 31-р сургуулиудын 486 сурагчид сургалт зохион байгуулсан.</p> <p>- Эпкак Монгол ТББ, ЭМТ-тэй хамтран -ын 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх “Үгүй би хүсэхгүй”, “Эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт буруу зуршлаас урьдчилан сэргийлэх нь “Зөв сонголт-Миний ирээдүй” сургалтыг дүүргийн 16-р сургуулийн 125 сурагчдад зохион байгуулав.</p>
--	--	---

			-2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр ЭМТ-тэй хамтарсан Өсвөр үе, залуучуудад тулгамдаж буй асуудлууд, БЗХӨ, ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх болон бусадтай харилцах харилцааны эерэг аргын талаарх сургалтанд ерөнхий боловсролын Үй-Цай сургуулийн 9-12 дугаар ангийн 120 сурагчдыг хамруулан зохион байгууллаа.					
38	2.5.4		ЕБС-ийн эмч нарыг чадваржуулах сургалт, уулзалт зөвлөгөөн зохион байгуулна.	50%-д хүргэнэ.	Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирсан байна.	-	НХХ, ЭМТ	100%
			Дүүргийн Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв хамтран дүүргийн сургууль, цэцэрлэгийн эмч нарын уулзалтыг 4 удаа зохион байгуулж 205 эмч, мэргэжилтэн хамруулж, мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажилласан.					
39	2.5.5	НЗДҮАХ-ийн 4.3.1 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.5.6 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд, залуучууд, иргэдийн авьяасыг нээн хөгжүүлж, урлаг соёлын үйл ажиллагааг дэмжинэ.	Төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн сурагч, хүүхэд, багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, иргэдэд соёлын боловсрол олгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хүүхэд, багачуудын авьяасыг нээн хөгжүүлж, улс, нийслэлийн уралдаан тэмцээнд оролцуулсан байна.	-	НХХ	100%
			<p>-“Улаанбаатарын өвлийн наадам-2018” арга хэмжээг дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороо, иргэдийн нийт 400 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, үндэсний дээл, хувцсаар гоён уралдаан, тэмцээнүүдэд амжилттай оролцлоо. Зохион байгуулалт сайтай оролцсон 11 дүгээр хороо 2 дугаар байр, үндэсний хувцастай хосын уралдаанд 10 дугаар хорооноос оролцсон хос 1-р байр, 9 дүгээр хорооноос оролцсон хос 2-р байранд тус тус шалгарч, өргөмжлөл, наадмын нэрэмжит шагналын эзэд боллоо.</p> <p>-“Хүрэл тулга-2018” уралдааны дүүргийн шатны шалгаруулалтаас шалгарсан 16 хүүхэд нийслэлийн II шатны шалгаруулалтад оролцож, 3 насны ангилалд эхний 3 байрт 3 хүүхэд шалгарч, улсын III шатны тэмцээнд амжилттай оролцлоо.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/227 дугаар захирамжийн дагуу “Дээлтэй Монгол Наадам”-д дүүргийн удирдлагууд, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, 1-20 дугаар хорооны 200 иргэн үндэсний дээл, хувцсаар ижилсэн жагсаж, “Эрийн гурван наадам”-ын хотхон байгуулж оролцлоо. Дүүргийн хэмжээнд зохион байгуулалт сайтай оролцсон хэлтэс, хороодыг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшуулсан ба нийслэлийн хэмжээнд Сүхбаатар дүүрэг дэд байр эзэлж, Өргөмжлөл мөнгөн шагнал, эрхийн бичгээр шагнууллаа.</p> <p>-Хүй долоон худагт 2018 оны 08 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ардын урлагийн их наадам”-д тус дүүргийн 15 ардын авьяастан оролцож, отог байгуулан соёлын биет бус өвийн 5 ай савын хүрээнд үзэсгэлэн гаргаж амжилттай оролцлоо.</p>					

			<p>-Соёлын биет бус өвийг өвлөн тээгчдийн судалгаа, Угийн бичиг хөтөлдөг иргэдийн судалгаа, Соёл урлагийн чиглэлээр цэнгээнт үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, Уран дархчуудын судалгааг тус тус шинэчлэн гаргаж, нийслэлийн Соёл, урлагийн газарт хүргүүлээ.</p> <p>- 11 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд дүүргийн тусгай сургалттай 29, 116 дугаар сургууль, 86 дугаар цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй 59 хүүхдийн дунд урлагийн наадам зохион байгууллаа.</p> <p>- Соёл урлагийн чиглэлээр зохион байгуулсан ажилд дүүргийн төсвөөс нийт 13,070,000 төгрөг зарцуулсан болно.</p>					
40	2.5.6	НЗДҮАХ-ийн 1.4.5 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 2.5.7 Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө, дурсгалт газруудын соёлын аялал жуулчлалын ажлыг дэмжинэ.	Нутаг дэвсгэрт байрлах хөшөө дурсгалт газруудын арчлалт хамгаалалтыг сайжруулах хяналт, шалгалт хийж, холбогдох газартай хамтран угаалга, цэвэрлэгээний ажил зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Түүх соёлын үл хөдлөх хөшөө дурсгалын арчлалт, хамгаалалтыг сайжруулж, угааж, арчин нөхөн сэргээсэн байна.	-	НХХ, ТНААХ	100%
			<p>-Дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр Ханддоржийн өргөөний дэргэд байрлах “Ариун ёс” боржин гантг чулуун самбар, Ю.Цэдэнбалын хөшөөний чулуун самбарын гэмтэж, хагарсан байсныг засварлуулж, хэвийн байдалд орууллаа.</p> <p>-Музейн нээлттэй өдрүүдээр хороодын иргэд, хүүхэд, залуучууд музей үнэ төлбөргүй үзэж сонирхох боломж бүрдсэн.</p> <p>-Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2018.02.28-ны өдрийн Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, соёлын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх тухай 02-01/70 дугаартай удирдамжийн дагуу 1,2,4,5,6,7,8,15-19 дүгээр хороонд байрлах нийт 52 хөшөө дурсгалт газруудад үзлэг шалгалт явууллаа. Дүүрэгт албан ёсоор бүртгүүлээгүй, барьсан газар тодорхойгүй 5 хөшөө, баримал байна.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/178 дугаар захирамжаар 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Дондогдулам хатны гэрэлт хөшөөний газар эзэмших гэрчилгээг хүчингүй болгож, 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлэн, Дондогдулам хатны гэрэлт хөшөө бүхий дурсгалт газрыг хамгаалалтад авч, 2019 онд орчин тойронд нь тохижилтын ажил хийхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн захирамжаар “Сүхбаатар Дэвшил” ОНӨААТҮГ-тай хамтран 31 хөшөө, дурсгалыг угааж, цэвэрлүүлээ. Тус ажилд нийт 3 сая төгрөг зарцуулсан.</p>					
3. Амьдрахад таатай Сүхбаатар дүүрэг								
3.1 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ								
41	3.1.1	ДЗДҮАХ-ийн 3.1.1	7 дугаар хорооны хороо, өрхийн эмнэлэг,	Ажлын явц, хувиар	50	-	ТГХШХ	40%

		Төрийн үйлчилгээг иргэдэд нэг цэгээр үзүүлэх хороо, ӨЭМТ, цагдаагийн хэсгийн цогцолбор байрыг шинээр барина.	цогцолбор барилгын ажлыг эхлүүлнэ.						
			<p>7 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/1051 дүгээр захирамжаар дүүргийн Засаг даргын Тамгын газарт олгосон 07 дугаар хорооны цогцолбор барилга барих газарт Өсөх таван эрдэнэ ХХК нь барилгын суурийн байгууламж цутгасан бөгөөд суурийг Монгол Улсын Шинжлэх ухаан, Технологийн Их Сургуулийн Барилга, архитектурын сургууль, Оношлогоо, зураг төсөл, судалгааны “Реконстракшн” төвийн 2015 оны 11 дүгээр сарын экспертизийн дүгнэлтээр ашиглах боломжгүй нь тогтоогдсон, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 001/ХТ2017/00704 дүгээр тогтоолоор барилгын ажил үргэлжлүүлэхийг тус дүүргийн Засаг даргын Тамгын газарт даалгах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тул Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааны 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр мэдэгдэл, дүүргийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 1/1866 дугаар мэдэгдэл, дүүргийн Газрын албаны 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 170905/001 дугаар шаардах хуудас /мэдэгдэл/ зэргээр газар чөлөөлөх тухай мэдэгдсэн боловч Өсөх таван-Эрдэнэ ХХК нь газар чөлөөлөхгүй байгаа учир дүүргийн Засаг даргын 2017 оны Газар албадан чөлөөлөх тухай А/354 дүгээр захирамжаар албадан буулгаж газар чөлөөлөхөөр болсон.</p> <p>Гэтэл Өсөх таван эрдэнэ ХХК-аас Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2017 оны А/354 дүгээр захирамж, НЗДТГ-ын 2018 оны 07/208 дугаар албан бичгийг тус тус хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг хүлээн авч 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 128/ШЗ2018/2439 дүгээр шүүгчийн захирамжаар Захиргааны хэрэг үүсгэсэн.</p> <p>Хэрэг үүсгэсэн шүүгчээс 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 128/ШЗ2018/3442 дугаар захирамжаар дүүргийн Засаг даргын 2017 оны А/354 дүгээр захирамжийн биелэлтийг хэрэг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаагаар түдгэлзүүлж шийдвэрлэсэн.</p> <p>Уг шүүгчийн захирамжид хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч давж заалдах гомдол гаргасны дүнд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 221/ШТ2018/0424 дүгээр тогтоолоор Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр 128/ШЗ2018/3442 дугаар захирамжийг хүчингүй болгож, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлыг хангаж шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэрээс шалтгаалан хөрөнгө оруулалтын хэрэгжилт хүлээгдэж байна.</p>						
42	3.1.2	НЗДҮАХ-ийн 5.4.4 дахь заалт, ДЗДҮАХ-ийн 3.1.3 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, хяналтын камерыг нэмэгдүүлнэ.	Шинээр камержуулалт хийх, өмнөх онуудад хийгдсэн камерын ашиглалт хариуцсан байгууллагын гүйцэтгэлд хяналт тавина.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	-	ТНААХ	100%	
			Дүүргийн нутаг дэвсгэр дээрх 124 байршлын 276 камерын ашиглалтыг “UNNO Салюшн” ХХК хариуцан ажиллаж байна. Мөн 2017 оны дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 1-10 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийтийн хогийн цэгийн 25 байршилд байршуулсан 25 ширхэг 1 чигийн камер, 360 градус эргэдэг						

			камер 23 ширхэг камерын арчлалт хамгаалалт, хяналтыг хариуцан ажиллаж байна. 2018 онд 200,000,000 төгрөгийн санхүүжилтийг олголоо. Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хороодод нийт 615,000.0 мянган төгрөгийн төсөвтэй гэмт хэргийн гаралт өндөртэй ач холбогдол бүхий 39 цэгт 78 ширхэг камержуулалтын хийх 6 төсөл арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлсэн.					
43	3.1.3		Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан байгууллагын гүйцэтгэлд хяналт тавина.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	-	ТНААХ	100%
			Дүүргийн орон сууц, гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийн гүйцэтгэл асалт ашиглалтад сар бүрийн 15-25-ны хооронд хяналт шалгалт хийж холбогдох инженер, хариуцсан мэргэжилтэн нар явж шалган гэрэлтүүлгийн нэг дүгээр бүс 1-8 дугаар хороог “Гэрэлтүүлэг чимэглэл” ХХК хариуцан ажилладаг, гэрэлтүүлгийн асалтын дундаж 98.8%, 2 дугаар бүс “Би Эм Жи Эл” ХХК хариуцан ажилладаг гэрэлтүүлгийн асалт 98,5%-тай, 3 дугаар бүсэд “ДМТМ” ХХК хариуцан ажилладаг гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийн асалтын 98.9%-тай байна. 2018 онд 650 000 000 төгрөгийн санхүүжилтийг олгож 2017 оноос 3%-иар өссөн.					
44	3.1.4		Гэрэлтүүлгийн шонг кодолж мэдээллийн санд бүртгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ТНААХ	100%
			Дүүргийн 1-20 дугаар хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууц, гэр хорооллын гудамж талбайн 5919 гэрэл, 380 камерын 190 шонгийн тоо ширхэг төрөл, байршлын мэдээллийг хороогоор нь ангилан мэдээллийн бааз үүсгэлээ.					
45	3.1.5		Гэр хорооллын гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.	Ажлын явц, хувиар	100	-	ТГХШХ	100%
			Дүүргийн 1, 7, 16, 18 дугаар хороодод орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 282,250.7 мянган төгрөгийн төсөвтэй 144 ширхэг гэрэлтүүлгийн 6 төсөл арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Улсын төсвийн хөрөнгөөр 5 дугаар хороонд 40,475.7 мянган төгрөгийн төсөвтэй гэрэлтүүлгийн ажлын зураг, төсөв холбогдох материалыг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж, шийдвэрлүүлсэн.					
46	3.1.6	ДЗДҮАХ-ийн 3.1.4 Орон сууцны хороолол доторх авто зам, гэр хорооллын гудамж хорооллын гудамж	Орон сууцны хороолол доторх авто зам, гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	-	ТНААХ	100%

		талбайд сайжруулсан шороон замыг шинээр хийх болон шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	шороон зам хийх ажлын гүйцэтгэлд хяналт тавина.					
			Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 9, 12, 13, 20 дугаар хороодод нийт 726,804.6 мянган төгрөгийн төсөвтэй 7.285 км сайжруулсан шороон замын 11 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлсэн.					
47	3.1.7		Гэр хорооллын гудамжинд сайжруулсан шороон зам, хучилт хийх байршлыг төлөвлөнө.	Ажлын явц, хувиар	100	-	ТГХШХ	100%
			Дүүргийн 12 дугаар хорооны Хангайн 1, 2, 3, 5, 7, 12, 21, 24-р гудамжинд хайрган хучилттай зам, явган хүний зам, 13 дугаар хорооны Рашааны 1, 2, 8, Ногоон талбайн 5, Хангайн 24 дүгээр гудамж, 14 дүгээр хорооны Хандгайт 18, 19, 32-р гудамж, Ногоон талбай орчим хайрган хучилттай зам, 15 дугаар хорооны Дамбадаржаа 9-12-р гудамжинд хайрган хучилттай зам, Дамбадаржаа 81-84-р гудамжинд хайрган хучилттай замын ажлын зураг, төслийг Ар си Эс си ХХК хийж гүйцэтгэв.					
48	3.1.8	НЗДҮАХ-ийн 3.3.3 дахь заалт, ДЗДҮАХ-ийн 3.1.5 Иргэдийн саналын дагуу нийтийн эзэмшлийн талбай дахь авто зогсоол, ногоон байгууламж, сул шороон хучилт, явган хүний зам, гүүр, шат, худаг усан сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.	Нийтийн эзэмшлийн талбайд авто зогсоол, ногоон байгууламж, сул шороон хучилт, явган хүний замын ажлыг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Авто зогсоолын тоо нэмэгдсэн байна.	-	ТГХШХ ТНААХ	100%
			Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2 дугаар хороо 26 дугаар байрны зүүн хойд талд авто зогсоол "Арвинсантех" ХХК Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 дугаар хороо 45 дугаар байрны баруун талд авто зогсоол ажлыг "Материал трейд" ХХК хийж гүйцэтгэлээ.					
			Дүүргийн 1, 3, 4, 15, 20 орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1 байршилд явган хүний зам, 1 байршилд авто зогсоол, 2 байршилд хучилт, 2 байршилд явган хүний гүүрний нийт 6 байршилд 85,247.1 мянган төгрөгийн төсөвтэй 3 төсөл арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.					
			Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2, 3 дугаар хорооны 4 байршилд 16,000.0 мянган төгрөгийн орон сууцны барилгын хаяавч засвар, 2 дугаар хорооны 1 байршилд 32,300.0 мянган төгрөгийн авто зогсоолын ажлын худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж, зөвлөмжийг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.					
			Улсын төвийн хөрөнгөөр 5 дугаар хороонд 1 байршилд 86,200.0 мянган төгрөгийн авто зогсоолын ажлын зураг, төсөв холбогдох материалыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлсэн.					
49	3.1.9		Шинээр худаг барих ажлын гүйцэтгэлд хяналт тавина.	Үйл ажиллагааны	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах	-	ТНААХ	100%

				хэрэгжилт, хувиар	нөхцөлийг бүрдүүлсэн байна.				
			Дүүргийн 20 дугаар хорооны Цээний 1 дүгээр гудамжинд Тайваны сангийн тусламжтайгаар гүний худаг барих ажлын гүйцэтгэлд хяналт тавилаа.						
50	3.1.10		Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлаар мэдээллийн сан үүсгэж баяжуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Мэдээллийн бааз үүсгэсэн байна.	-	ТНААХ	100%	
			Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 143 байршлын 153 ширхэг сүүдрэвч, 4500 м2 хүүхдийн тоглоомын талбай, 397 чийрэгжүүлэлтийг төхөөрөмж , 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбай, 141км хатуу хучилттай авто зам, 36 км явган замын мэдээллийг ARCGIS программд оруулан мэдээллийн сан болон судалгааг үүсгэсэн.						
51	3.1.11	ДЗДҮАХ-ийн 3.1.6. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллана.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	-	ТНААХ	100%	
			Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 143 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4500 м2 хүүхдийн тоглоомын талбай, 397 чийрэгжүүлэлтийг төхөөрөмж , 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбай, 141км хатуу хучилттай авто зам, 36 км явган замын цэвэрлэгээ засвар үйлчилгээг хийлгэхээр 10 бүс болгон Цац толгойн төгөл ХХК, Их дуурсах өртөө ХХК, Жито ХХК, Сарнайн мөнхжин групп ХХК, Ти Жи Жи сервис ХХК, Ан со со ХХК, Могод Жи Би ХХК, Эрхэт гүн Бюлдинг ХХК, Асах дөл ХХК, БЧХЦ ХХК эдгээр аж ахуйн нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавин 2018 онд 700,000,000 орчим төгрөгийн санхүүжилтийг олгож 2017 оноос 43%-иар өссөн.						
52	3.1.12		Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн усан оргилуурын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	-	ТНААХ	100%	
			Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн засвар үйлчилгээ хийх шаардлагатай 1-р хорооны зүүн талын цэцэрлэгт хүрээлэн, 2-р хороо 24 байрны урд талд, 2-р хороо 32 байрны хойд талд, 10-р хороо хилчин						

			СӨХ-н усан оргилуур, 7-р хороо 4,6 байрны дундах 5 усан оргилуурын засвар үйлчилгээг тус хэсгийг хариуцан ажиллаж байгаа Цац толгойн төгөл, Их дуурсах өртөө, Могод жи би, Ти жи жи ХХК -р засварлуулж дүүргийн нутаг дэвсгэрт 16 усан оргилуур хэвийн ажиллаж байна.					
53	3.1.13	ДЗДҮАХ-ийн 3.1.7 Нийтийн эзэмшлийн орон сууцны байрнуудын дээврийн болон фасад засварлах, сэргээх ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлнэ.	Нийтийн эзэмшлийн орон сууцны байрнуудын дээвэр фасад засварын ажлыг хэрэгжүүлнэ.	Ажлын явц, хувиар	100	-	ТГХШХ ТНААХ	100%
			Дүүргийн орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, 2, 4, 6, 7, 11 дугаар хороонд нийт 383,997.5 мянган төгрөгийн төсөвтэй нийтийн эзэмшлийн орон сууцны 4863,89м2 дээврийн засварын ажлын 7 төсөл арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 108,400.0 мянган төгрөгийн 10 дугаар хорооны 17, 23 дугаар байрнуудын фасад засварын ажлын зураг, төсөв, холбогдох материалыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 589,012.7 мянган төгрөгийн төсөвтэй 2-6 дугаар хорооны 4 орон сууцны фасад засвар, 6 орон сууцны дээвэр засварын ажлын зураг, төсөв, холбогдох материалыг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Дүүргийн хөрөнгө оруулалтаар 1-р хороо 50-р байрны дээвэр засвар- Нэгдэл трейд ХХК, 1-хорооны 27-р дугаар байрны дээвэр засвар- АЯА ХХК 4-р хороо 50-р байрны дээвэр засварлах ажлыг Монцаст ХХК, 4 дүгээ, дугаар хороо 25 байрны дээвэр засвар- Баян зүйл ХХК, 6-р хороо 46-р байрны дээвэр засвар- Арвинсантех ХХК, 6-р хороо 34-р байрны дээвэр засвар- Проксител ХХК, 73/9, 73/11-р байрны дээвэр засвар- Тэнгэрийн бэрээ ХХК, 7-р хороо 7/1-р байрны дээвэр засвар-Эвцэг Хайрхан ХХК, 11-р хороо 64-р байрны дээвэр засвар- Сэлэнгэ хур ундрам ХХК хийж гүйцэтгэлээ. Фасад засвар- 10 дугаар хороо 17 дугаар байрны фасад засвар- Төгс тохижилт ХХК, , 10 дугаар хороо 23 дугаар байрны фасад засвар-Төгс тохижилт ХХК, Хаяавч засвар:2 дугаар хороо 3 дугаар байрны хаяавч засвар-Соёолонгийн тоос ХХК, 2 дугаар хороо 28 дугаар байрны хаяавч- Соёолонгийн тоос, 3 дугаар хороо 40-р байрны хаяавч-Соёолонгийн тоос ХХК, , 3 дугаар 44-р байрны хаяавч зөсвар- Соёолонгийн тоос ХХК, 4 дүгээр хороо 45, 46, 47-р байрны хаяавч засвар-Материал трейд ХХК хийж гүйцэтгэлээ.					
54	3.1.14	ДЗДҮАХ-ийн 3.1.8 Сууц өмчлөгчдийн холбоодын хариуцлагыг өндөржүүлж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	Сууц өмчлөгчдийн холбоод болон шилдэг тохижилттой иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулж урамшуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ТНААХ	100%
			Манай хороо-Миний гудамж аянд дүүргийн 188 сууц өмчлөгчдийн холбоо шалгуур үзүүлэлтийн дагуу оролцож, 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Шилдэг Орон сууцны аж ахуй нэгж байгууллага шалгаруулах шалгуур үзүүлэлтээр 2 дугаар байранд Сити их сургууль, шилдэг хог тээвэрлэгч аж ахуй нэгж байгууллагад 3 дугаар байранд Улаанбаатар Шинэчлэл ХХК, 2 дугаар байранд Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Шилдэг гэр хорооллын аж ахуй нэгж байгууллагад нэр дэвшсэн Номун амралт тусгай байранд					

			орлоо. Аянд амжилттай оролцсон 10 сууц өмчлөгчдийн холбоог цагаан хуас, монос, үрэл зэрэг гоёл чимэглэлийн 100 ширхэг модоор урамшууллаа. Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/133 дугаар тушаалын дагуу дүүргийн 1-11 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулдаг 77 СӨХ-дын үйл ажиллагаанд 2018 оны 06 дугаар сарын 20-ноос 10 дугаар сарын 1-ний өдрийн хооронд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж сууц өмчлөгчдийн үйл ажиллагааг сайжруулах талаар заавар зөвлөгөө өглөө.					
55	3.1.15	ДЗДҮАХ-ийн 3.1.9 Гэр хорооллын гудамж, замыг тохижуулах ажлыг тухайн хорооны иргэдийн саналыг авч хэрэгжүүлнэ.	Иргэдийн саналд үндэслэн хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсвийг боловсруулна.	Зураг төсвийг боловсруулах ажлын явц, хувиар	100	-	ТГХШХ	100%
			Дүүргийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын ажил хэрэгжүүлэхэд шаардлагатай зураг төсөв боловсруулах ажлын хүрээнд иргэдийн саналыг үндэслэн 11-18 дугаар хороодод 214 цэгт камержуулалт, орон сууцны хороолол болон гэр хорооллын 57 байршилд тохижилт, явган зам, гүүр, шат, авто зосгоол, хайрган хучилт, орон сууц, сургууль, цэцэрлэгийн 62 барилгын холболт, дээвэр, фасад, сантехник, цахилгааны засварын зураг, төсөв боловсруулах болон шинэчлэх ажлуудыг нийт 251,420.1 мянган төгрөгийн зөвлөх үйлчилгээний 9 төсөл, арга хэмжээг төлөвлөж, бүрэн хэрэгжүүлсэн.					
3.2 Иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулна								
56	3.2.1	НЗДҮАХ-ийн 5.4.7, 5.4.10 дахь заалт ДЗДҮАХ-ийн 3.2.1	Газартай холбоотой хөрөнгө оруулалтын ажлуудыг дараа оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ГА	100%
			Дүүргийн Засаг Даргын Тамгын газар, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хороодын засаг дарга нарт 10 сарын 01-нд албан тоот явуулж 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах санал боловсруулан Дүүргийн ИТХ-д хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна.					
57	3.2.2	Гэнэтийн гамшиг осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлнэ.	Онцгой байдлын хэлтэстэй хамтран онцгой байдлын шуурхай албаны авто машин саадгүй хүрэлцэн очих нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн үер усны аманд байгаа айлуудад шаардах мэдэгдлийг хүргүүлж, шаардлагатай	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ГА	100%

		тохиолдолд газар чөлөөлөх арга хэмжээг авна.					
		Сүхбаатар дүүргийн газрын алба, Дүүргийн Онцгой комисс, Дүүргийн Мэргэжлийн хяналтын газар, Дүүргийн онцгой байдлын газартай хамтарч үер усны болзошгүй аюул, эрсдэл аюул осол гарч буй шалтгаан нөхцөлийг тогтоож урьдчилан сэргийлэх чиглэлээр 131 айлд мэдэгдэх хуудсыг хороодын засаг дарга нартай хамтран тарааж, Дүүргийн нутаг дэвсгэрт үерийн эрсдэлтэй бүсэд суурьшсан зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй өрх хуулийн этгээдийн судалгааг гаргаж зөвшөөрөлгүй айл өрхүүдэд мэдэгдэх хуудас өгч ажилласан байна. Гэр хороолол, Зуслангийн бүсэд нийт 47 нэгж талбарт газар чөлөөлөлтийн ажил хийж 110 айлд орц гарц гаргаж өгсөн байна.					
58	3.2.3	Дүүргийн эрсдэлийн гэмшгийн үнэлгээг хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Гамшгийн эрсдэлийн түвшнийг тогтоож, гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөж, гамшгийн эрсдэлийг бууруулсан байна.	35 000 000	ОБХ	100%
		Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 07 дугаар тогтоолоор дүүргийн нутаг дэвсгэрт гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх 35.000.000 төгрөг батлуулан ЗДТГ-ын Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний хэлтэстэй хамтран ажлын даалгавар бэлтгэн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Тендерт "Гамшиг, гал түймрээс хамгаалах Монголын нийгэмлэг ТББ" шалгарч гамшгийн эрсдэлийн үнэлгээг 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрүүдэд нийт 76 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.					
59	3.2.4	Дүүргийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй гамшгийн хор уршгийг арилгах, аврах ажлын зориулалттай тусгай багаж тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулна.	Багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн хангалт 70%-д хүрсэн байна.	Бие бүрэлдэхүүний тусгай хувцас, багаж, техник хэрэгслийн хангалтын хувь, чанар, алба хаагчдын хөдөлмөр хамгааллын хэрэгсэл сайжирсан байна.	33 000 000	ОБХ	100%
		Дүүргийн Засаг даргын А/398 тоот захирамжийн хүрээнд Онцгой байдлын албаны гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангахад шаардагдах 9 нэр төрлийн 39.460.000 төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг Файр энерги ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн №337 дугаар, Давшилт хангай ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн № 338 дугаар, Зэсэн арвай ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн № 339 дүгээр, Аажан буян ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн №336 дугаар худалдан авах гэрээ байгуулан, худалдан авч бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлээд байна.					

			Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тус хэлтэст шуурхай албаны автомашин авах 33.000.000 төгрөг. Батлуулан худалдан авалтыг хийж бэлтгэл бэлэн байдлыг сайжруулсан. Ингэснээр Гал түймэр унтраах, аврах 34 дүгээр ангийн багаж, тоног төхөөрөмжийн хангалт 70 хувьд хүрсэн.					
60	3.2.5	ДЗДҮАХ-ийн 3.2.2 Хороодод үүсэн байгуулагдсан Хөршийн холбоог нэмэгдүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.	Байгуулагдсан хөршийн холбоог чадавхжуулах, зарим хороодын холбоог шинээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хөршийн холбооны тоог нэмэгдүүлсэн байна.	-	ТЗУХ, ЦХ-1, 2	100%
			<p>Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс дараах үйл ажиллагааг зохион байгуулав. Үүнд: “Хөршийн хяналт” хөтөлбөрийн хүрээнд: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 126 дугаар тогтоолоор баталсан “Хөршийн хяналт хөтөлбөр”, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/86 захирамжийн “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил”-ийн ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Хариуцсан хороодын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хөршийн хяналтын бүлгүүдийг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь идэвхижүүлэх чиглэлээр Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, ахлах байцаагч, хэсгийн байцаагч нарт үүрэг чиглэл өгсөн. Дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт хөршийн хяналтын 19 бүлгийн 73 гишүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрсдийн хариуцсан гудамж, талбай, амьдарч буй орчин, айл хөршийн өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, сэжигтэй хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйлийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад өгч хамтран ажилласан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, тэднээс гарсан санал, санаачлагыг дэмжин хамтран ажиллах, хариуцсан нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг 355 аж ахуйн нэгж, байгууллагад хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн санамж тарааж ажилласан. “Камержуулалт 2” болзолт уралдааны батлагдсан удирдамжийг 1-8 дугаар хорооны хөршийн хяналтын 19 бүлгийн 73 гишүүд, 23 сууц өмчлөгчдийн холбоод, 104 аж ахуй нэгж, иргэд, байгууллагуудад хүргүүлж, яриа таниулга хийсэн. “Камержуулалт 2” болзолт уралдаанд оролцох хүсэлтэй 3 СӨХ материалаа бүрдүүлж өгсөн. 2017 онд 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 17 бүлэг 73 гишүүнт байсан бол 2 Төлөвлөсөн ажлын хүрээнд 1-8 дугаарын хорооны хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Нэг хөрш-нэг айл”, “Айл хүний амь нэг-Саахалт хүний санаа нэг” уулзалтыг 350 ирэдийг оролцуулан зохион байгуулж 2 төрлийн 2500 ширхэг гарын авлага тараасан. Мөн 8, 7 дугаар хороонд шинээр хөршийн хяналтын 10 гишүүнтэй 2 бүлэг байгуулсан. Цаашид “Хөршийн хяналтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд оршин суугч ирэдийн оролцоотой 6 удаа өдөрлөг, уулзалт, тэмцээн зохион байгуулсан. Тус цагдаагийн хэлтсээс “Хулгайлах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүчээ нэгтгэж-хамтдаа тэмцье” нэг сарын аяны хүрээнд 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт харуул хамгаалалтгүй байр орон сууцны орчинд автомашин байршуулж буй 35 газруудын судалгааг гаргаж, 24 Сууц өмчлөгчдын холбооны удирдлагад хэлтсийн даргын 20189064 дугаартай албан шаардлагыг хүргүүлж</p>					

		<p>ажилласнаар хөршийн хяналтын 12 бүлгийн 15 гишүүн, оршин суугч иргэдийн санаачилгаар Сүхбаатар дүүргийн 3, 4, 5, 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт 7 байр, орон сууцны орчинд хашаа бариулж харуул хамгаалалт ажлуулж эхэлсэн. Тухайн орчинд автомашины бүтээлэг, машины эд аниуд алдагдах тохиолдол бүртгэгдээгүй байна.</p> <p>Хөршийн хяналтын 19 бүлэг 95 гишүүнтэй 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдөр уулзалт зохион байгуулж гудамж, талбай, амьдарч буй орчин, айл хөршийн өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, сэжигтэй хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйлийн талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллагад тухай бүр өгч хамтран ажиллах талаар яриа таниулга хийж, тодорхой хуваарийн дагуу эргүүл ажиллуулж байна. Хөршийн хяналтын бүлгийн гишүүдээс сэжиг бүхий этгээдийн 17 мэдээллийг цагдаагийн байгууллагад бүртгүүлж шалгуулсан.</p> <p>Хөршийн хяналт хөтөлбөр, сайн хөрш, хөршийн хяналтыг лого бүхий тэмдэглэгээтэй сурталчилгааны материалыг 1200 ширхэгийг хэвлүүлж хорооны Засаг даргы ажлын алба, 17 хөршийг холбооны орчинд байршуулсан. Хулгайлах гэмт хэрэгээс урьдчилан сэргийлсэн 2 төрлийн шторк, 3 төрлийн бошур, сэрэмжлүүлгийг 3500 ширхэгийг 1-8 дугаар хороодын хэсгийн байцаагч, хорооны цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан, урамшуулалт эргүүл, хөршийн хяналтын бүлгийн гишүүд хамтран 112 аж ахуйн эгж байгууллага, 1500 иргэд, олон нийтэд тараан байршуулж ажилласан.</p> <p>Хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, идэвхжүүлэх, хөршийн хяналтын бүлэг, цагдаагийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын уялдаа холбоог сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр нэгдэх, иргэдийн нэгдлүүдийн дунд иргэд өөр хоорондоо илүү дотно танилцах, итгэлцлийг бий болгох зорилгоор явган аялал, хөгжөөнт тоглоом, шатар, даам гэх мэт уралдаан тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <p>“Хүүхдийг зодож шийтгэхгүй байх дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан Сүхбаатар дүүргийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Биеийн тамир спорт хороо, Гандийн нэрэмжит үйлдвэр урлалын коллеж, Дашчойлин хийд, Хүүхдийн тоглоомын БУММ-ХХК-тай хамтран “Хүүхдийг зодож шийтгэхгүй байхын эсрэг хамтдаа” өдөрлөгийн арга хэмжээг 2018 оны 4 дүгээр сарын 30 өдөр зохион байгууллаа.</p> <p>Цагдаагийн 2 дугаар хэлтэс дараах үйл ажиллагааг зохионб айгуулав. Үүнд: Тус хэлтсээс хариуцсан нутаг дэвсгэр, гудамж талбай, байр ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхи, санаачлагад суурилсан амгалан тайван байдлыг бүрдүүлэх “Хөршийн хяналт” хөтөлбөрийг эрчимжүүлэх, цагдаагийн алба хаагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлыг зохион байгуулж ажиллаа. Үүнд: “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хороодын оршин суугчдад сурталчлах ажлыг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн 9-20 дугаар хороодын нутаг дэвсгэрт хэсгийн байцаагч, хороон цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан, урамшилт эргүүлийн ажилтан нарын 110 хүний хүчээр 15 цэгт 2018 оны 8 дугаар сарын 10-20-ний өдрүүдэд иргэдтэй уулзалт, яриа, зөвлөгөөн зохион байгуулж ажилласан.</p> <p>Хөршийн хяналтын бүлэг, цагдаагийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын уялдаа холбоог сайжруулах зорилгоор 253 иргэнд яриа таниулга хийж, шинээр 6 хөршийн хяналтын бүлгэмийг зохион байгуулж, цаашид цагдаагийн байгууллага, хөршийн холбоо иргэд хоорондоо мэдээ мэдээлэл солилцох,</p>
--	--	--

			хамтран ажиллах ажлыг сайжруулах талаар санал солилцон иргэдийг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулсан. Дүүгийн ГХУССЗ салбар зөвлөлтэй хамтран хөршийн хяналтын 2 төрлийн зурагт хуудас болон шторкийг гарган олон нийтэд хүргэж ажилласан.					
61	3.2.6	НЗДҮАХ-ийн 5.4.3 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.3 "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлнэ.	Оюутан цагдаагийн ажиллах нөхцөл бололцоог сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ЦХ-1, 2	100%
			"Аз жаргалтай хот", "Эргүүл дэд" хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн цагдаагийн газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын газар, Монголын Оюутны холбоотой хамтран "Оюутан цагдаа-2018" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөр нь оюутан залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, аялал жуулчлалаар яваа гадаадын иргэдийн аюулгүй байдлыг хангах, жуулчдад аялал жуулчлал, соёлын үйлчилгээний мэдээлэл түгээх зорилготой. Арга хэмжээнд 40 оюутан цагдаа хамрагдсан бөгөөд тус хэлтсийн хариуцсан 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Сүхбаатарын талбай", "Үндэсний соёл амралтын хүрээлэн", "Шөнийн гэрэлт гудамж" зэрэг жуулчид ихээр явдаг газруудад 2018.06.01-ний өдрөөс 2018.08.13-ны хооронд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж эргүүлийн үүрэг гүйтгэж ажилласан.					
62	3.2.7	НЗДҮАХ-ийн 5.4.5 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.4 Дүүрэгт хэрэгжүүлж байгаа хэв журмын урамшуулалт эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	Хэв журмын урамшуулалт эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ТЗУХ, ЦХ-1, 2	100%
			1-20 дугаар хорооны Хэв журмын урамшилтай эргүүлүүдийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ажлын тайлан сар, улирал, хагас жилээр тайлагнан ажиллаж байна. Нийт 80 хэв журмын урамшилтай эргүүл ажиллах байснаас жилийн эцсийн байдлаар 66 иргэн хэв журмын урамшилтай эргүүл ажиллаж, тайлан мэдээг өгч ажиллаж байна. Цагдаагийн 1 дүгээр хэлтэс: Сүхбаатар дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт, гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 200.000 төгрөгийн урамшилтай 29, 35.000 төгрөгийн урамшилтай 30, нийт 59 иргэн оршин сууж байгаа байр, гудамж талбайд хэв журмын урамшилт эргүүлийн үүрэг гүйцэтгэж цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан. Хэв журмын урамшилт эргүүлийг дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт нь "Даваа", "Лхагва", "Баасан" гарагт ажлын цагаар гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй, хүн ихээр цуглардаг эмзэг цэгүүдэд эргүүл хяналтаар ажлуулж байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 7500 иргэн, 933 өрх, 374 аж ахуйн нэгж байгууллагад яриа хийж, иргэдийг мэдээллээр хангаж, гэмт хэрэг, зөрчлийн талаар өгсөн 42 мэдээлэлд холбогдох шалгалтын ажиллагааг явуулснаар иргэдийн өмчийг хулгайлах 7 гэмт хэргийг илрүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 23 этгээдийн талаар мэдээлэл өгч, цагдаагийн байгууллагын судалгаа хяналтад авахуулж, хуулийн дагуу хариуцлага тооцуулсан. Цагдаагийн 2 дугаар хэлтэс:					

			<p>Тус хэлтсийн урамшилт эргүүлийн ажилтан нараас 2018 оны 01 дүгээр сард Монгол Улсын зөрчлийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийслэл, ИТХ-ийн тогтоолыг шийдвэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, өөрийн оршин сууж байгаа байр орон сууц гудамжинд нийтийн хэв журам сахиулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 43 иргэн цагдаагийн байгууллагатай гэрээ байгуулан, харилцан мэдээ мэдээлэл солилцож хамтран ажиллаа.</p> <p>Хэв журмын урамшуулалт эргүүлүүд нь 7 хоног бүрийн даваа гариг бүр цагдаагийн байгууллагад гэмт хэргийн шинжтэй 57, захиргааны зөрчлийн 370 нийт 427 мэдээ, мэдээлэл өгч, цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдсэн 54 этгээдийг хүлээлгэн өгч, Хууль тогтоомжийг тайлбарлан таниулж ухуулга сурталчилгааг 256 байгууллага, 530 иргэнд хийж, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон 116 хүнийг ар гэр, асран хамгаалагч, саатуулах байр, яаралтай түргэн тусламж 103-д хүлээлгэн өгч осгож хөлдөх, эрүүл мэндээрээ хохирох, эд эрхтэнээсээ хагацах, амь насаа алдах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласнаар гудамж талбайд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2018 оны эхний 10-н сартай урьд оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>					
63	3.2.8	ДЗДҮАХ-ийн 3.2.5 Гэмт хэрэг, зөрчлийг бууруулж, иргэдийн аюулгүй байдлыг хангана.	Согтууруулах ундааны хэрэглээнд хяналт тавьж, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн оюутнуудад чиглэсэн уралдаан, тэмцээн, аян зохион байгуулна.	ЕБС-ийн сурагчид болон их, дээд сургуулийн оюутнуудын дунд согтууруулах ундааны хор уршгийг сурталчлах, хэрэглээг бууруулах зорилгоор тэмцээн, уралдаан зохион байгуулна.	Оюунтан, сурагчид мэдээллээр хангагдсан байна.	-	ХХҮХ	100%
			<p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, орон сууцны ойролцоо үйл ажиллагаа явуулж буй баар, рестораны газруудын судалгааг гаргаж УБ хотын Захирагчийн ажлын албанд 2018.01.18-ны өдрийн 8/137 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Дүүргийн МХХ-тэй хамтран 2018 оны 01 сарын 19-ний өдөр сургуулийн ойр орчим буюу 200м-ийн дотор үйл ажиллагаа явуулж баар, караокены нийт 28 газарт хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS4946:2005 стандартын шаардлагыг 43.7% буюу 14 аж ахуйн нэгж хангаагүй ажиллаж байсан. Батлагдсан жор технологийн дагуу халуун хоолоор үйлчилдэггүй, хоолны дээж авдаггүй, дээж хөтлөлт хийдэггүй, ажилчдын эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдалт хангалтгүй, дүрэмт хувцасгүй зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байсан бөгөөд зөрчил дутагдлыг арилгуулах талаар ажлын байранд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.</p>					

		<p>Согтууруулах ундааны хэрэглээнд хяналт тавьж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд уралдаан, тэмцээн зохион байгуулах тухай ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/353 дугаар захирамж гарч ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн сурагчдийн дунд “Хорт зуршил ба эрүүл мэнд” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулан ажиллалаа. Уралдааны удирдамжийг дүүргийн Боловсролын хэлтсийн цахим хуудсанд байршуулан зарыг сургуулиудад түгээсэн бөгөөд нийт ирсэн бүтээлүүдээс 1-р нэг, 2-р байр 2, 3-р байр 2 нийт 5 бүтээлийг тус тус шалгаруулахаар төлөвлөн ажиллаж байна. Уралдааны тэргүүн байранд орсон бүтээлийг 2019 онд хорт зуршлын эсрэг зохион байгуулагдах мэдээлэл, сурталчилгааны ажилд “Cover” зургаар ашиглан, нийтэд сурталчилна. Уралдааны шалгаруулалтын дараа дүүргийн Эрүүл мэндийн төвийн сэтгэлзүйч “Хорт зуршил ба эрүүл мэнд” сэдвээр илтгэл тавьж сурагчдад мэдлэг, мэдээлэл олгох ажлыг зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>					
64	3.2.9	<p>Сургуулийн болон цэцэрлэгийн хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг нэмэгдэж, зам тээврийн осол буурсан байна.</p>	-	СБДЗЦХ	100%
		<p>Дүүргийн сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын 53 цэцэрлэг, сургуулиудад “Явган зорчигчийн үүрэг”, “Замын хөдөлгөөний дүрэм”, “Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт 152 удаагийн сургалтуудад 7100 орчим хүүхэд багачууд, эцэг эх, асран хамгаалагч нарыг хамруулан зохион байгуулж ажилласан. Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга Э.Ганбаттай хамтран дүүргийн 58 дугаар сургуулийн 500 хүүхдэд гэрэл ойлгогч ханцуйвч тараах ажлыг хамтран зохион байгуулсан.</p> <p>Мөн Хүүхэд гэр бүл хөгжлийн төвтэй хамтран “Анхаар аюулгүй эрсдэлгүй орчин ” арга хэмжээний хүрээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарт зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг аюулгүй тээвэрлэлтийн талаар 2646 ширхэг гарын авлаг тарааж ажилласан. 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Хүүхдийн ордонд дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, “Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв”-тэй хамтран дүүргийн ерөнхий боловсролын ахлах ангиудын дунд “Гэмт хэрэг, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт дэвжээ тэмцээнийг анх удаа зохион байгуулж, цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>2018 оны эхний 10 сард зам тээврийн ослын улмаас бага насны хүүхэд амь насаа алдсан 2 осол хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн, 4 хүүхэд гэмтэж бэртсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2 хүүхэд амь насаа алдсан осол хэргийн 1 хар цэгт 2 ширхэг хурд сааруулагч шинээр байршуулж, дахин энэ төрлийн осол хэрэг бүртгэгдэхээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.</p>					
65	3.2.10	<p>“Ногоон гэрэл цагаан шугам-2018” ерөнхий</p>	<p>Хүүхдийг багаас нь</p>	<p>Замын хөдөлгөөнд соёлтой оролцох, зам</p>	-	СБДЗЦХ	100%

			боловсролын сургуулийн дунд зохион байгуулна.	замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгтэй болгоно.	тээврийн осол тодорхой хувиар буурна.			
			Сургуулийн насны хүүхэд багачуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Ногоон гэрэл цагаан шугам 2018” тэмцээнийг 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион Улаанбаатар чуулгад зохион байгуулж ажиллалаа. Уг тэмцээн уралдаанд ерөнхий боловсролын 9 сургуулийн 108 хүүхэд багачууд өрсөлдсөнөөс 3 дугаар байранд 4 дүгээр сургууль, 2 дугаар байранд 3 дугаар сургууль, 1 дүгээр байранд 1 дүгээр сургууль тус тус амжилттай оролцсон. Тэмцээнд оролцсон нийт 108 хүүхэд багачуудад гарын бэлгийг гардуулсан.					
66	3.2.11		“Замын хөдөлгөөний цагаан толгой-2018” сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд зохион байгуулна.	Хүүхдийг багаас нь замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгтэй болгоно.	Зам тээврийн осол тодорхой хувиар буурсан байна.	-	СБДЗЦХ	100%
			Бага насны хүүхэд, багачуудад Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, тэднийг зам тээврийн осол хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг Даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Боловсролын хэлтэс, Улаан загалмайн хороотой хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Замын хөдөлгөөний цагаан толгой-2018” тэмцээнийг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр мэдүүлэг өгсөн 26 цэцэрлэгийн 312 хүүхэд багачуудыг хамруулан уг тэмцээн уралдааныг Улаанбаатар чуулгын байранд зохион байгуулсан. Тэмцээнд оролцсон 312 хүүхэд багачуудад Засаг даргын бэлгийг гардуулан 1, 2, 3 дугаар байр, тусгай байр, уран зохицуулагч, шилдэг багш, шилдэг эцэг эхийг тодруулан өргөмжлөл, медалиар шагнаж урамшуулан тэмцээн уралдааныг амжилттай зохион байгуулсан. Тэргүүн байр эзэлсэн 166 дугаар цэцэрлэгийн хүүхэд багачуудыг Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээн уралдаанд амжилттай бэлтгэн оролцуулсан.					
67	3.2.12		Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдийн гэрэлтүүлгийг сайжруулж, телекамерын хяналтад авах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ЦХ-1, 2	100%
			<u>Цагдаагийн 1 дүгээр хэлтэс:</u> Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газраас дүүргийн орон нутгийн сангийн хөрөнгөөр 2015-2017 оны хариуцсан нутаг дэвсгэрт гэрэлтүүлэг камержуулалтын ажлыг Сектех ХХК-аар гүйцэтгүүлэн 2018					

		<p>оны 01 дүгээр улиралд үргэлжлүүлэн 1-8 дугаар хороодын нутаг дэвсгэр байрны орчимд байрлах хогийн цэг, эмзэг цэгүүдэд стандартын шаардлага хангасан 19 телекамерыг 76.000.000 сая төгрөгөөр шинээр суурилуулсан.</p> <p>Дүүргийн 1-8 дугаар хороодын 25 автобусны буудал, камерын хяналтгүй 95, стандартын шаардлага хангаагүй камер байршуулсан 54 аж ахуй нэгж, байгууллага болон автобусны буудлын орчимд үйлдэгдсэн гэмт хэргийн судалгааг сүүлийн 3 жилээр тус тус гарган Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.</p> <p>Арга хэмжээний хүрээнд дүүргийн 1 дүгээр хороо, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эргэлтийн болон төв хаалганы орчим шинээр 2 ширхэг камер, 7 дугаар хороо 21 байрны гадна талд 4 ширхэг камер, Номин супермаркетын гадна талд нэмж 2 ширхэг камерыг аж ахуй нэгж, байгууллагуудын санхүүжилтээр байршуулсан болно.</p> <p>Мөн байрны гарц, орох хэсэг, цэцэрлэг сургууль хүрэх гэх мэт нийтийн эзэмшлийн 7 байршилд 18 гэрэлтүүлгийг Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газар, СБД, ЧД, БЗД-ийн иргэний хэргийн шүүх, СӨХ-үүдээс тус тус байршуулсан.</p> <p>“Камержуулалт-2” болзолт уралдааны хүрээнд Хөршийн хяналтын 19 бүлгийн 95 гишүүд, 24 сууц өмчлөгчдийн холбоод, 250 аж ахуйн нэгж, иргэд, байгууллагуудад хүргүүлж идэвхи санаачлагатай оролцуулах талаар 5 удаа яриа таниулга хийж, зөвлөмж хүргүүлж, дүүргийн 1-8 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, СӨХ-той хамтран нийт 38 ширхэг хяналтын камерийг гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг эмзэг цэгүүдэд байршуулан идэвхитэй оролцсон.</p> <p><u>Цагдаагийн 2 дугаар хэлтэс:</u></p> <p>Дүүргийн Засаг даргын тамгын газраас 9-20 дугаар хороодын нутаг дэвсгэр гудамж талбайд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 116 телекамерын систем байршуулах саналыг өгч техникийн ажил явагдаж байна.</p> <p>“Камержуулалт 2” болзолт уралдааны удирдамжийг 9-20 хорооны Засаг дарга нарт 30п/1609 дугаартай, сууц өмчлөгчдийн холбооны 25 газарт 30п/1680 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлж, хариуцсан хороодын нутаг дэвсгэрт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын дунд сурталчлах ажлыг бодит үр дүнтэй зохион байгуулан, уралдаанд идэвхи, санаачлагатай оролцохыг уриалж ажиллаа. -Болзолт уралдааны хүрээнд дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Мөнгөн тавилга” ХХК-нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 11 камерыг 12 сая төгрөгний өртөгөөр, дүүргийн 15-р хороо ЯЦЦ-Н 29 тоот үйл ажиллагаа явуулах “Дэвжих оргил” хүнсний дэлгүүр нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 4 ширхэг камерыг 800.000 төгрөгний өртөгөөр, дүүргийн 15-р хороо дамба даржаагийн 5 гудамжинд үйл ажиллагаа явуулах “Уянга” хүнсний дэлгүүр нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 2 ширхэг камерыг 350.000 төгрөгний өртөгөөр, дүүргийн 17-р хороо дамба даржаа 52-291 тоотод үйл ажиллагаа явуулах “Амгалан” хүнсний дэлгүүр нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх</p>
--	--	--

			<p>чиглэлээр гадна дотор талд нийт 2 ширхэг камерыг 200.000 төгрөгний өртөгөөр, дүүргийн 17-р хороо дамба даржаа 67-897 тоотод үйл ажиллагаа явуулах “Дүүрэн дуут” хүнсний дэлгүүр нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 2 ширхэг камерыг 250.000 төгрөгний өртөгөөр, дүүргийн 20-р хороо цолмонгийн 3-15 тоотод үйл ажиллагаа явуулах “Цолмон” хүнсний дэлгүүр нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 5 ширхэг камерыг 1.200.000 төгрөгний өртөгөөр, дүүргийн 20-р хороо сэлхий зусланд үйл ажиллагаа явуулах “Цэлмэг” хүнсний дэлгүүр нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 4 ширхэг камерыг 1.100.000 төгрөгний өртөгөөр, байршуулж ажилласан.</p> <p>-Дүүргийн 18-р бэлхийн 45-03 тоотод оршин суух иргэн Б.Оюунцэцэг иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 4 ширхэг камерыг 1.500.000 төгрөгний өртөгөөр, Сүхбаатар дүүргийн 12-р хангайн 7-232 в тоотод оршин суух иргэн Н.Тамирбаатар нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 9 ширхэг камерыг 3.000.000 төгрөгний өртөгөөр байршуулж ажилласан.</p> <p>- Дүүргийн 11 дүгээр хороо Хангай хотхоны СӨХ-нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадна дотор талд нийт 280 камерыг 91,315,000 төгрөгний өртөгөөр, Сүхбаатар дүүргийн 9-р хороо “хамтдаа 120” Сууц өмчлөгчдийн холбоо нь гадна дотор талд нийт 7 ширхэг камерыг 1.500.000 төгрөгний өртөгөөр, Сүхбаатар дүүргийн 10-р хороо “Манай хөрш сууц өмчлөгчдийн холбоо нь 7 ширхэг теле камерийг 2.000.000 сая төгрөгний өртөгөөр байршуулж хяналтын камерын нэгдсэн санд холбосон.</p> <p>2017 онд камержуулалт болзолт уралдаанд иргэд байгууллага аж ахуй нэгж, сууц өмчлөгчдийн холбооноос нийт 209 телехяналтын камерыг 9.600.000 төгрөгний өртөгөөр байршуулж байсан бол 2018 онд “Камержуулалт болзолт уралдаан 2” арга хэмжээний хүрээнд иргэд байгууллага аж ахуй нэгж, сууц өмчлөгчдийн холбооноос нийт 326 телехяналтын камерыг 115.215.000 төгрөгний өртөгөөр байршуулсан үр дүнтэй байна.</p>					
68	3.2.13		Гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ЦХ-1, 2	100%
			<p><u>Цагдаагийн 1 дүгээр хэлтэс:</u> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Эрчимжүүлэлт шийдвэрлэлт”, “Эрсдэл ба хамгаалал”, “Хуулийн хэрэгжилт”, “Унадаг дугуй”, “Хяналт”, “Оюутан эргүүл”, “Эргүүл”, “Орц хонгил”, “Захиргааны хяналт”, “Эрсдэл ба хамгаалал”, “Зочид болон дэн буудал”, “Сургууль аюулгүй орчин”, “Тамхины хяналт”, “Түц”, “Цахим тоглоомын газар”, “Автобусны буудал эргүүл”, “Хяналт-1”, “Хараа хяналтгүй хүүхэд 1, 2, 3”, “Сургалт-мэдээлэл”, “Цахим тоглоомын газар-1, 2, 3, “Газ”, “Хяналт шалгалт”,</p>					

		<p>“Тоглоомын талбай”, “Сургууь аюулгүй орчин”, “Тэнэмэл”, “Орц”, “Траншей”, “Хулгайчаас сэргийлье” “Илрүүлэлт, оргодол, шийдвэрлэлт”, “Цахим бүртгэл”, “Эмзэг цэг”, “Эргүүл хяналт”, “Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлье” зэрэг 27 хэсэгчилсэн арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулсан.</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор ерөнхий боловсролын сургуулийн сурагч 26260, Оюутан-15700, эцэг, эх, асран хамгаалагч 17600, багш, нийгмийн ажилтан 467, иргэн 97650, нийгмийн ажилтан-19, төрийн бус байгууллагын ажилтан -39, урлаг соёл спортын алдартнууд-12, төрийн байгууллагын ажилтан алба хаагч -347, олон нийтийн цагдаагийн ажилтан-8, урамшилт эргүүл-50, оюутан эргүүл-55, нийт 139,151 иргэн, төрийн бус байгууллага 8, төрийн байгууллага-64, байгууллага аж ахуйн нэгж-721, их дээд сургууль-20, Ерөнхий боловсролын сургууль-23, цэцэрлэг-19, оюутны байр-17, СӨХ-119, хороо-8 нийт 1019 төрийн болон, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг татан оролцуулж цахим мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бусад хэлбэрээр иргэд олон нийтэд нөлөөллийн үйл ажиллагааг үзүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцууллаа.</p> <p>Сүхбаатар дүүргийн ИТХ, Цагдаагийн 1, 2, Замын цагдаагийн хэлтэс, Хүүхэд гэр, бүл хөгжлийн төв дүүргийн харъяа ерөнхий боловсролын сургуулийн орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, сурагчдын эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх, сургуулийн эргүүл болон өсвөрийн сэргийлэх бүлгэмийн ажиллагааг эрчимжүүлэх, сурагчид, тэдний эцэг, эх, багш, нийгмийн ажилтны хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор "Дэвжээ-2018" тэмцээнийг зохион байгуулсан. Үр дүнд нь сурагчдын эрх зүйн мэдлэг дээшилж, нийслэлийн хэмжээнд 3 дугаар байр эзэлсэн. Сүхбаатар дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд боловсролын байгууллагын орчинд аюулгүй орчин бүрдүүлэх ажилд сургуулийн захиргаа, багш ажилтан, оюутан сурагчдыг зохион байгуулалттай бүрэн оролцуулах гурвалсан гэрээг байгуулан гэрээгээр хүлээсэн үүргээ 2018-2019 оны хичээлийн шинэ жилд амжилттай, сайн биелүүлсэн байгууллагыг шагнаж урамшуулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх хөшүүргийн арга хэмжээг хэрэглэх саналыг хүргүүлэн дэмжлэг авч 20.000.000 төгрөгний урамшуулалттай болзол бүхий гурвалсан гэрээг 3 их дээд сургууль, 16 ерөнхий боловсролын сургуулийн захиргаатай байгуулан гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.</p> <p><u>Цагдаагийн 2 дугаар хэлтэс:</u></p> <p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хичээлийн шинэ жил”, “Дэн буудал”, “Хяналт шалгалт”, “Цахим тоглоом”, “Илрүүлэлт-оргодол”, “Нэг хороо-Нэг гудамж”, “Камержуулалт”, “Наадам”, “Хуулийн хэрэгжилт” “Эмзэг цэг” зэрэг нэгдсэн болон тусгай арга хэмжээг 41 удаа зохион байгуулан ажилласан.</p> <p>Арга хэмжээний хүрээнд нийт давхардсан тоогоор 2845 байгууллага аж ахуй нэгжийн харуул хамгаалалтыг шалгаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 425 аж ахуй нэгжид шаардлага өгч биелэлт үр дүнг нэгтгэж зөрчил гаргасан аж ахуй 31.200.000 нэгжийг 2923 хүнийг 72.639.0000 төгрөгөөр торгож ар гэртээ агсан согтуу тавьж танхайрсан болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 70 иргэнийг шүүхээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, архинд донтох өвчтэй 36 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас 1450 сэрэмжлүүлэг 2840 тараан ажилласан.</p>
--	--	--

			<p>Хороодын эрүү, хэв журмын нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч гэмт хэрэг, зөрчил байнга давтамжтай үйлдэгддэг эмзэг цэгүүд, гэрэлтүүлэггүй гудамж, цэцэрлэг, хүн олноор цуглардаг худалдааны төв, хүнсний зах, автобусны буудал орчим газруудад эргүүлийн чиглэл, байршлыг гарган 09:00-14:00, 14:00-20:00, 16:00-22:00 цагуудад /давхардсан тоогоор/ 450 удаа эргүүл шалгалтыг зохион байгуулан ажилласан байна.</p> <p>Сүхбаатар дүүргийн ИТХ, Цагдаагийн 1, 2, Замын цагдаагийн хэлтэс, Хүүхэд гэр, бүл хөгжлийн төв дүүргийн харъяа ерөнхий боловсролын сургуулийн орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, сурагчдын эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх, сургуулийн эргүүл болон өсвөрийн сэргийлэх бүлгэмийн ажиллагааг эрчимжүүлэх, сурагчид, тэдний эцэг, эх, багш, нийгмийн ажилтны хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор "Дэвжээ-2018" тэмцээнийг зохион байгуулсан. Үр дүнд нь сурагчдын эрх зүйн мэдлэг дээшилж, нийслэлийн хэмжээнд 3 дугаар байр эзэлсэн.</p> <p>Сүхбаатар дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд боловсролын байгууллагын орчинд аюулгүй орчин бүрдүүлэх ажилд сургуулийн захиргаа, багш ажилтан, оюутан сурагчдыг зохион байгуулалттай бүрэн оролцуулах гурвалсан гэрээг байгуулан гэрээгээр хүлээсэн үүргээ 2018-2019 оны хичээлийн шинэ жилд амжилттай, сайн биелүүлсэн байгууллагыг шагнаж урамшуулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх хөшүүргийн арга хэмжээг хэрэглэх саналыг хүргүүлэн дэмжлэг авч 20.000.000 төгрөгний урамшуулалтай болзол бүхий гурвалсан гэрээг 3 их дээд сургууль, 16 ерөнхий боловсролын сургуулийн захиргаатай байгуулан гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.</p>					
69	3.2.14		Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ТЗУХ, ЦХ-1, 2	100%
			<p>Эрүүгийн цагдаагийн алба, Хар тамхитай тэмцэх газар, Сэтгэцийн эрүүл мэндийн төв дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэстэй хамтран 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр "Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр", "Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд дүүргийн 1-20 дугаар хорооны 130 иргэн, хороодын нийгмийн ажилтан нарт сургалт зохион байгууллаа.</p> <p>Дүүргийн Прокурорын газартай хамтран ерөнхий боловсролын 6, 4, 31, 34, 58, 71 дүгээр дунд сургуулийн ахлах бүлгийн 600 гаруй сурагчидад Хар тамхи мансууруулах бодис, түүни йхор уршгийн тухай 1 цагийн сургалт зохион байгуулсан. Засаг даргын дэргэдэх хэлтэс Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө болосруулан хагас бүтэн жилээр биелэлт хангаж ажиллаж байна.</p>					
70	3.2.15	НЗДҮАХ-ийн 3.2.2 ДЗДҮАХ-ийн 3.2.6 Агаарын бохирдол, хог хаягдлыг бууруулна.	Усан болон уурын халаалтын зуух, нам даралтын зуух эзэмшигч аж ахуйн нэгж,	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	МХХ	70%

		байгууллагад хяналт шалгалт хийнэ.					
		<p>Агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийх 02-01/18 тоот удирдамжийн дагуу халаалтын зуух эзэмшин үйл ажиллагаа явуулж буй 10 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулан ажиллалаа. 2.3 дугаартай “Дулааны цахилгаан станц, хэсгийн халаалттай уурын зуух, нам даралтын зуухны байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас” хяналтын хуудсаар үнэлэхэд шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 5 буюу 55.8% нь их, 4 буюу 43.7% нь дунд, 1 буюу 0.5% нь бага, дунджаар 48.1%-ийн дунд эрсдэлтэй байна.</p> <p>Шалгалтаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллаагүй, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор арга хэмжээ авч ажилладаггүй, үйлдвэрлэлийн явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, хог хаягдлын хэмжээг бүртгэдэггүй, үйлдвэрлэлээс гарсан үнс, хог хаягдлыг төрөлжүүлдэггүй, үнсийг ил задгай хаяж байгаа зөрчил илэрлээ. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 72 заалттай 9 албан шаардлага, хэмжилтийн дүнд үндэслэсэн 3 дүгнэлт гаргаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан 4 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 2.0 сая төгрөг, шалгалтын явцад агаар бохирдуулагч эх үүсвэртэй холбоотой иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу 2 аж ахуйн нэгжид 2.0 сая төгрөг нийт 4.0 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулан бүх аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж гарган хүргүүлээ.</p> <p>АНУ сервис ХХК 2017 онд дунд эрсдэлтэй үнэлэгдэж байсан бол эрсдэл 15.6%-иар буурч бага эрсдэлтэй, Макс хүнс ХХК, Алтан жолоо трейд ХХК-иуд нь 2017 онд их эрсдэлтэй үнэлэгдэж байсан бол 2018 оны хяналт шалгалтаар эрсдэл 11.6%-иар буурч дунд эрсдэлрүү орсон байна.</p>					
71	3.2.16	Нийслэлийн хогийн цэгүүд болон суурьшлын бүсэд хөрс бохирдуулагч эх үүсвэрийн судалгааг гаргана. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд сурталчилна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	МХХ	100%
		<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн тогтоогдсон 10 хөрсний цэгээс шинжилгээ авч, НМХГ-ын Төв лабораторид хүргүүлэн, шинжилгээний дүнд өмнөх жилийн дүнтэй харьцуулан боловсруулалт хийгдэж байна.</p> <p>Шар усны үер гарсантай холбогдуулан Сүхбаатар дүүргийн Засаг даргын А/73 тоот захирамж гарч, үерийн улмаас бохирдсон хөрсийг халдваргүйжүүлэхэд зориулан улсын ахлах байцаагчийн 2 зөвлөмж гарган биелэлтийг тооцон ажиллалаа.</p> <p>Нийслэлийн Онцгой комиссын даргын 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн “Үерийн усны аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” 06 дугаар албан даалгаврын хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргад зөвлөмжийг албан бичигт хавсарган хүргүүлэн, тус ажлын хүрээнд 9 дүгээр хорооны үерийн усанд автсан айл өрхийн орчмоос хөрсний 3 дээж авч, шинжлүүлэн, улсын ахлах байцаагчийн</p>					

			дүгнэлт гаргасан. Дүүргийн нутаг дэвсгэрийн эдэлбэр газрын хөрсний бохирдлын түвшин тогтоогдож, энэ асуудлаар холбогдох арга хэмжээ авч, ажиллах нөхцөл бүрдэнэ. 2017 оны хавар, намрын шинжилгээний дүнтэй харьцуулахад их бохирдолтой гарч байгаа нь Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008 стандартын шаардлага хангахгүй гарсан байна. Энэ нь шар усны үер, хур бороо их орж үер болж нийтийн эзэмшлийн зам талбай бохирдсонтой холбоотой байна.					
72	3.2.17		Нийтийн эзэмшлийн гудамж талбайд эрүүл ахуйн шаардлага хангасан хогийг ангилан ялгах болон бусад зориулалтын хогны сав 20 байршилд байрлуулах ажилд хяналт тавина.	Ил задгай хог хаягдлын хэмжээ багасна.	Ил задгай хог хаягдал багасаж, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлсэн байна.	-	ТНААХ	70%
			2018 онд дүүргийн 1, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 15, 18, 20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд гэмт хэрэг зөрчил ихээр гардаг, гарч болзошгүй, хулгайгаар ил задгай хог хаяж үүсмэл хогийн цэг бий болдог 25 байршлууд дээр иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гэрэлтүүлэг, хяналтын камер бүхий хогийн савыг байршуулахаар судалгааг гарган холбогдох хэлтэст хүргүүлээ.					
73	3.2.18	НЗДҮАХ-ийн 3.2.8 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.7 Агаарын бохирдлыг бууруулах талаар хувийн хэвшлийн байгууллагуудын шинэ санаачилга, дэвшилтэт технологийг дэмжиж ажиллана.	Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, ажлын байрны дотоод орчны агаарын бохирдлыг хэмжих хяналт, шинжилгээний ажилд ашиглагдах 5 үйлдэлт багаж төхөөрөмжөөр хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	МХХ	100%
			Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн анги танхим, эмнэлэгт олгосон агаар цэвэршүүлэгчийн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийлээ. НАББГ-аас өгсөн тоон мэдээгээр 789 агаар цэвэршүүлэгч тараасан гэсэн тоо байгаа ба газар дээр нь очиж үзэхэд 2017 онд тараагдсан тоо 126ш /Өргөө амаржих-65, Хүрээ амаржих-16, Шүд эрүү нүүрний төв-5, 29 дүгээр сургууль-17, 116 дугаар сургууль-23/ нэмэгдээд нийт 915ш-ийг хяналт шалгалтад хамруулсан. Шалгалтаар дээрх газрууд нь агаар цэвэршүүлэгч хүлээн авснаас хойш ямар нэгэн эвдрэл гэмтэл гараагүй, хэвийн ажиллагаатай, 2017 онд тавигдсан агаар цэвэршүүлэгч бага зэргийн бохирдолтой байна. Сүхбаатар дүүрэгт Саммит компьютер технологи ХХК, Айонтөч ХХК-иуд гүйцэтгэгчээр ажиллан Airpro AP400F, Airpro 240F, GL8138E маркийн агаар цэвэршүүлэгчийг тараасан байна.					

		<p>Зөрчил: Шүд эрүү нүүрний төв 1ш, Өргөө амаржих газар 2ш агаар цэвэршүүлэгчийг захиргаа, санхүүгийн өрөөнд байршуулсан байсныг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, хангамж үйлчилгээний албаны дарга нарт үүрэг болгож гаргуулан иргэд хүлээн авах хэсэг болон эмчигээний өрөөнд байршуулав.</p> <p>1, 58 дугаар сургуулиудын зарим ангийн багш нар ажиллуулж мэдэхгүй мөн зарим анги танхимын тогны залгуур ажиллахгүй гэсэн шалтгаанаар ажиллуулж эхлээгүй, 2 ширхэг агаар шүүгчийг багш нарын өрөөнд байрлуулсан, 45 дугаар сургууль ашиглалтанд оруулаагүй байсныг сургуулийн захирал менежер нарт танилцуулан сурагчдын анги танхимд байрлуулж, зөрчлийг арилгуулан ажиллалаа.</p> <p>Шалгалтын явцад гүйцэтгэгч байгууллагууд ашиглалтын талаар заавар, зөвлөмж өгөөгүй, анги бүлгийн багш нар цэвэршүүлэгчийн талаар мэдлэггүй, хичнээн хэмжээний талбайг цэвэршүүлэх хүчин чадлыг мэдэхгүй, шүүгчийг хэдий хугацаанд солих талаар мэдээлэлгүй байсныг гүйцэтгэгч байгууллагатай холбогдон заавар зөвлөмжийг авч дээрх байгууллагуудад хүргүүлж ажиллалаа.</p>					
74	3.2.19	Агаарын бохирдлыг бууруулах талаар хувийн хэвшлийн байгууллагуудын шинэ санаачилга, дэвшилтэт технологийг дэмжиж хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Яндангийн тоог бууруулж түүхийн нүүрсний хэрэглээ багассан байна.	-	ТНААХ	100%
		<p>Нийслэлийн Засаг даргын А/805 захирамж, ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчийн баталсан удирдамжийн дагуу 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 100 кВт-аас дээш хүчин чадалтай зуух ашигладаг төрийн өмчийн 10, хувийн хэвшлийн 6 аж ахуйн нэгж байгууллагын 29 зууханд хяналт шалгалтыг явууллаа. 2018 оны 06 дугаар сард 15-100кВт-ийн зуухны тооллого бүртгэлийн ажлыг зохион байгуулж 9, 11-20 дугаар хорооны 280 зуухыг тоолж бүртгэлжүүллээ.</p> <p>2018 оны 7 дугаар сард дүүргийн нутаг дэвсгэрт усан халаалтын зуух ашиглан үйл ажиллагаа үйл явуулдаг аж ахуйн нэгж байгууллагад 10 ААНБ уурын зуух, 3 зуухны яндангийн утаанд хийн хэмжилт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 72 заалттай 9 албан шаардлага, хэмжилтийн дүнд үндэслэн 3 дүгнэлт гаргаж Ньюслетер ХХК, Есөн од ХХК, ШАБ ХХК, Бестбекери ХХК-иудад байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 2.0 сая, шалгалтын явцад агаар бохирдуулагч эх үүсвэртэй холбоотой иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу 2 аж ахуйн нэгжид 2.0 сая Нийт 4.0 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулан бүх аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж гарган хүргүүллээ. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж ажиллалаа. Гэр, байшингаа дулаалцаага гарын авлагыг дүүргийн 9, 11-20 дугаар хороонд 10 000 ширхэгийг тараалаа.</p>					
75	3.2.20	Гэр хорооллын айл өрх, нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй	Үйл ажиллагааны	Хөрсний бохирдол, халдварт өвчнөөс	-	ТНААХ	100%

			гудамж талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавина	хэрэгжилт, хувиар	урьдчилан сэргийлсэн байна.				
			<p>Дүүргийн гэр хорооллын айл өрхийн жорлон, бохирын цооног, 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн зам талбайд ариутгал халдваргүйжилтийн ажлыг дүүргийн хэмжээнд 3 удаа зохион байгуулж гүйцэтгэлийг үндэслэн 337,950,050 төгрөгийн санхүүжилтийг олголоо.</p> <ol style="list-style-type: none"> 1. Дүүргийн 9, 11, 12, 13, 14, 15 дугаар хороодын 11646 өрхийн жорлон, бохирын цооног ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг “Хан-судар” ХХК 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 04 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ. 2. Дүүргийн 15-20 дугаар хороодын 8111 айл өрхийн жорлон, бохирын цооног, 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж, талбай 38240 мкв ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг “Агь нарын овоо” ХХК 2018 оны 05 дугаар сарын 07-ноос 5 дугаар сарын 21-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ. 3. Дүүргийн 9, 11-20 дугаар хороодын 19757 өрхийн жорлон бохирын цооног, 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн 49565 мкв талбайд ариутгал халдваргүйтгэлийг ажлыг “Хан-судар” ХХК 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ. 						
76	3.2.21	НЗДҮАХ-ийн 3.3.7 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.2.8 Хог хаягдлын менежментийг одоогийн түвшингээс сайжруулна.	Гаднах орчноо цэвэрлэдэггүй, хууль бусаар хог хаягдлаа хаядаг явдлыг таслан зогсоож, бүх нийтийн болон өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, хог тээвэрлэлтийн ажлыг сайжруулан тогтмолжуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	МХХ	100%	
			<p>Нийслэлийн ерөнхий менежерийн өгсөн үүрэг даалгавар, НМХГ-ын даргын баталсан 02-03/671 тоот удирдамжийн дагуу 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас мөсний цэвэрлэгээний байдалд хяналт шалгалт хийж байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 8 аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг хангуулан ажиллалаа. Зөрчилтэй байсан 3 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 300.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын А/301 дүгээр захирамж “Их цэвэрлэгээ-90 минут”, НМХГ-ын дэд даргын баталсан 02-03/172 тоот удирдамжийн дагуу дүүргийн 1-20 дугаар хорооны хог хаягдлын байдалд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар хог хаягдлыг зориулалтын бус газарт хаясан 13 иргэнд 1950.0 мянган төгрөг, 4 ААН-д 1200.0 мянган төгрөг, хог хаягдлыг ил задгай шатаасан 1 иргэнд 50.0 мянган төгрөг, төрийн албан хаагчийн</p>						

			тавьсан шаардлага биелүүлээгүй 3 иргэнд 150.0 мянган төгрөг нийт 3770.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж барагдуулан, 152 ААН, иргэнд мэдэгдэл тарааж ажиллалаа. 2017 онтой харьцуулахад зөрчлийн илрүүлэлт нэмэгдэн, зөрчил арилгуулах арга хэмжээг авч ажилласан байна.					
77	3.2.22		Хог хаягдлын үйлчилгээг сайжруулж, хог тээврийн нарийвчилсан хуваарь гаргаж мөрдүүлнэ, хог хаягдлын үйлчилгээний орлогыг нэмэгдүүлж алдагдлыг багасгана. Хог тээврийн зөрүү нэмэлт санхүүжилт олгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хог хаягдлын үйлчилгээ сайжирсан байна.	-	ТНААХ	100%
			2018 оны 01 дүгээр сард дүүргийн 1-20 дугаар хороодын айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог тээврийн нарийвчилсан хуваарийг Засаг даргын орлогчоор батлуулан Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Улаанбаатар шинэчлэлт ХХК, Цүзүкү-Юмэ ХХК-нуудаар хог тээврийн хуваарийг мөрдүүлж, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний ажилд байнгын хяналт тавьж ажиллалаа. Хог тээвэрлэгч байгууллагуудад 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 1,966,000,000 төгрөгийн орлого, 835,400,000 төгрөгийн нэмэлт санхүүжилтийг олголоо. 2018 онд 6 удаагийн захирамжаар Засаг даргын 02 дугаар сарын 10, 11, 04 дүгээр сарын 21-ний өдөр, 05 дугаар сарын 24-ний өдөр, 6 дугаар сарын 29, 30-ний өдөр, 8 дугаар сарын 11-ний өдөр, 9 дүгээр сарын 15-ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан ажиллаа. Засаг даргын захирамжийн хүрээнд Засаг даргын орлогчийн 02/01, 02/04, 02/06, 01/07, 02/08, дугаар Албан даалгавар гарган Аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ, иргэдэд хороодоор дамжуулан мэдээлэл хүргүүлэн 7431 аж ахуйн нэгж байгууллага, 13953 иргэнийг хамруулан 110 хог тээврийн машин, 6 ковш ажиллаж 383 рейс буюу 1300 тонн хог хаягдлыг тээвэрлэж 44,333,562 төгрөгийн санхүүжилтийг олголоо. Цэвэрлэгээний явцад мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар нийт 620000 төгрөгийн торгуулийг ногдууллаа.					
78	3.2.23	НЗДҮАХ-ийн 4.4.8 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.3.3 Иргэд болон зорилтод бүлгүүдийн дунд /Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ нийтийн биеийн тамирын үйлчилгээг өргөжүүлж,	Спортын наадам, өдөрлөг, уралдаан тэмцээнд иргэдийг өргөнөөр хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэдийн дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулж, иргэдийг өргөнөөр хамруулсан байна.	-	НХХ, БТСХ	100%
			Дүүргийн аварга шалгаруулах спортын уралдаан тэмцээнийг спортын 21 төрлөөр насанд хүрэгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, өсвөр үе гэсэн ангилалаар нийт 31 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 302 байгууллагын 1890 тамирчид оролцлоо.					

		<p>Бүх ард түмний, Хүүхдийн, Үндэсний, Оюутны спортын наадмуудыг зохион байгуулж, Их наадмуудад дүүргийн баг тамирчдыг оролцуулна.</p>	<p>-Нийтийн биеийн тамирын чиглэлээр 30 нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 425 байгууллагын 52411 иргэд оролцсон.</p> <p>-Нийслэлийн 9 дүүрэг, 33 агентлаг, харьяа байгууллагуудын албан хаагчид оролцсон “Мөнгөн Улаанбаатар” өвлийн спорт наадамд дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын ажлын алба, дэргэдэх хэлтэс албадын нийт 600 гаруй албан хаагчид оролцлоо. “Цасны баяр”-ын үеэр зохион байгуулсан бүжгийн тэмцээнд дүүргийн хос 4 дүгээр байр эзэлж, цасан хотхон байгуулах уралдаанд 5 дугаар байрт, 69 дүгээр цэцэрлэгийн хамт олон “Нийслэлийн биеийн тамир, спортын шилдэг хамтлаг”-аар шалгарлаа. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албадын дунд спортын 3 төрлийн тэмцээн явуулж, 2017 оны спортын шилдэг хамтлагаар шалгарсан 20 дугаар хороо, 143 цэцэрлэгийн хамт олон биеийн тамир, спортын чиглэлээр хийсэн ажлаараа үзэсгэлэн гаргаж, сурталчиллаа.</p> <p>-Дүүргийн ахмадын хаврын спорт наадмын хийн дасгалын аварга шалгаруулах тэмцээнд дүүргийн 13 хорооны 13 баг тамирчин, шатрын аварга шалгаруулах тэмцээнд 20 хорооноос шалгарсан 40 тамирчин, дартсын тэмцээнд 20 хорооноос шалгарсан баг тамирчид тус тус өрсөлдөж, шилдгүүдээ шалгарууллаа. Ахмадын намрын спорт өдөрлөгт 20 хорооны 240 тамирчид /граунд гольф, ширээний теннис, зуун буудалт даам, софт волейбол/ спортын 4 төрлөөр өрсөлдсөн.</p> <p>-Монголын Мастеруудын спортын IV наадам Булган аймгийн Булган хотноо зохион байгуулагдаж, Сүхбаатар дүүргийн баг тамирчид Граунд гольф, Шатар, Софт волейболын төрлүүдэд амжилттай оролцсон.</p> <p>-Дүүргийн ЗДТГ-ын ажилтан, албан хаагчид, дэргэдэх хэлтэс албадын ажилтан албан хаагчид, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын дунд спортын 5 төрөлт 3 удаагийн тэмцээнийг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 600 гаруй тамирчин оролцож, тэмцээний төрлүүдэд шалгарсан баг, тамирчдыг шагнаж урамшууллаа.</p> <p>-“Хайрхан уулаа дээдлье-2018” спорт явган аялалыг Манзуширийн хийд-Цэцээ гүн чиглэлд зохион байгуулж, дүүргийн ЗТДГ, БТСХ, ЭМТ, ОБХ, ЦХ-II, Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, ЖДҮТ-ийн 7 баг оролцсон.</p> <p>-Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Ази тивийн аварга шалгаруулах “Граунд гольфийн” нээлттэй тэмцээнд 12 улсын болон нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг оролцсоос Сүхбаатар дүүргийн 28 тамирчин хурд хүч авъяас чадвараа өрсөлдүүлсэн. Нийт 42 байгуулгын 448 тамирчин оролцсон.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны А/30 дугаар захирамжаар Үндэсний спортын VI наадмыг 2018 оны 2 дугаар сарын 10-наас 08 дугаар сарын 11-ны өдрүүдэд спортын 9 төрөл /мөсний шагай, мөсөн сурын харваа, үндэсний бөх, ширээний шагай, шагайн харваа, үндэсний сур, буриад сур, урианхай сур, уламжлалт харваа/-өөр зохион байгуулж, нийт 108 байгууллагын 520 тамирчин хамрагдсан. Үндэсний спортын VI их наадмын дүүргийн шалгаруулалтад байгууллагын нэгдсэн дүнгээр: I байрт 19-р хороо, II байрт "Алтан дуулга" ХХК-ны баг, III байрт 6-р хороо, IV байрт ММБТСХ-ны СБД-ийн салбар хороо, V байрт 18-р хороо тус тус шалгарсан.</p> <p>-Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагдсан Пара хөнгөн атлетикийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон 2 иргэний тэмцээний зардалд дүүргийн Засаг даргын 2018.06.08-ны өдрийн А/194 дүгээр захирамжаар тус бүрт 300,000 төгрөг, 7 дугаар хорооны</p>
--	--	--	---

			иргэнд Испани улсад зохион байгуулагдсан Хүндийн өргөлтийн тэмцээнд оролцоход 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. -Дүүргийн Засаг даргын 2018 оны А/207 дугаар захирамжаар Иргэдийн спортын VII наадмыг 2018 оны 06 дугаар сарын 10-наас 11 дүгээр сарын 11-ний өдрүүдэд спортын 8 төрөл /спорт явган аялал, олс таталт, шагаан наадгай, волейбол, сагсан бөмбөг, софт волейбол, хийн дасгал, аэробик/-өөр зохион байгуулж, явган аялал, олс таталтын тэмцээнүүдийг зохион байгуулаад байна. Дүүргийн төсвөөс дээрх ажлуудад нийт 75,674,000 төгрөг зарцуулсан байна.					
79	3.2.24	НЗДҮАХ-ийн 4.4.2, 2.6.6 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 3.3.4 Иргэдэд амьдралын зөв дадал хэвшил олгох, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, зохистой хооллолт-идэвхтэй хөдөлгөөн аян, Бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил хөтөлбөрийг жил бүр өрнүүлж, хүн амын бие бялдрын боловсролын түвшнийг дээшлүүлнэ.	НЭМГ, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран “Амьдралын буруу хэв маягаас урьдчилан сэргийлэх” төсөл хэрэгжүүлнэ.	Япон улсад 6 эмнэлгийн мэргэжилтэн сургана.	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сувилагч нарын зөвлөгөө өгөх үр чадвар сайжирсан байна.	-	НХХ, ЭМТ	100%
			-Жайка ОУБ-ын “Өвсний Үндэс” дэд төслийн хүрээнд 1 их эмч, 3 сувилагчийг Япон улсад 14 хоногийн богино хугацааны сургалтад хамруулсан. Төслийн баг “Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлэхэд сувилагчийн оролцоо” 8 удаагийн багийн сургалтад ЭМТ, ӨЭМТ-ийн 105 сувилагч хамруулж, сувилахуйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 40 ширхэг артерийн даралт хэмжих бугуйн электрон аппарат, алхам хэмжигч, 10 ширхэг захын цусан дахь хүчилтөрөгч хэмжигч нийлүүлсэн. -Төслийн хүрээнд “Өөрийн хяналтын өврийн дэвтэр” боловсруулан, артерийн даралт ихсэх өвчтэй 16 үйлчлүүлэгчид 1 сарын хугацаанд туршилтаар хөтлүүлж, үр дүнг тооцсон.					
80	3.2.25	“Идэвхтэй хөдөлгөөн-Зохистой хооллолт” хөтөлбөрийн хүрээнд сургалт сурталчилгааны ажлыг өрнүүлэх, бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулж, түвшнийг дээшлүүлнэ.	“Идэвхтэй хөдөлгөөн-Зохистой хооллолт” хөтөлбөрийн хүрээнд сургалт сурталчилгааны ажлыг өрнүүлэх, бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулж, түвшнийг дээшлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.	-	НХХ, БТСХ	100%
			-"Тэнгэрийн увидас" ТББ-аас зохион байгуулсан "Зохистой хооллолт-Идэвхтэй хөдөлгөөн" сэдэвт тайлант өдөрлөгт дүүргийн Засаг дарга, Биеийн тамир, спортын хороо, Нэгдсэн эмнэлэг, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, хороодын төлөөлөл оролцлоо. -Дүүргийн Засаг даргын А/147 тоот захирамжийн дагуу “Улаанбаатар Марафонд Нэгдэцгээе” цомын аянд нэгдэн, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ-ийн нийт 150 эмч, мэргэжилтнүүд явган аялал зохион байгуулж, 15,17-р хороонд байрлах 2 спортын талбай, 58-р сургуулийн тоглоомын талбайг сэргээн засварласан. -"Зохистой хооллолт", "Ажлын байрны стресс менежмент", "Хөдөлгөөн эрүүл мэнд","Халдварт өвчнөөс хамтдаа сэргийлье", "Анхны тусламж үзүүлж сурцгаая" зэрэг 5 төрлийн сэдвээр "Эрүүл ажлын байр"					

			<p>сургалтын модуль боловсруулан ТСБТДС, Кингс-Кидс, Байгаль эх лицей, “Сити” их сургууль, Онцгой байдлын хэлтэс, 2,3,35,16,31,45,25,17-р сургууль, МУИС-ийн 1,2-р дотуур байр, МУБИС, ШУТИС-ийн дотуур байр, Албан бус боловсролын төв, Үйлдвэр урлалын политехник коллеж, "Namaste" сүлжээ ресторан, "Хүүгийн" гутлын үйлдвэр, Замын хөдөлгөөний удирдлагын төв, "Бага баян" амралт, "Янмал" оёдлын үйлдвэр зэрэг 36 байгууллагын 925 хүн хамруулсан.</p> <p>- БТСХ-той хамтран 11579 хүнээс бие бялдар, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил авч, хангалтгүй үнэлгээтэй 1210 хүнд дасгал хөдөлгөөн хийх аргачлал зааж, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>- ЭМС-ын 2017 оны А/472 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажилласнаар 2018 онд Нийслэлийн Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 2, эрүүл мэндээ дээдлэгч өрх 1, эрүүл мэндээ дээдлэгч 3 иргэн тус тус шалгарсан.</p> <p>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 2018 оны “Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын улсын нэгдсэн санд тус дүүргийн нийт 64 байгууллагын 23705 хүн хамрагдсан. Бие бялдрын хөгжил, чийрэглэлтийн түвшин тогтоох сорилд оролцсон иргэд А-5409, В-7878, С-5132, D-4972, F-494 дараах үнэлгээтэй байна.</p> <p>-“Улаанбаатар марафон-2018” Олон Улсын бүх нийтийн гүйлтэнд дүүргийн хэмжээнд 40 байгууллагын 1400 иргэн бүртгүүлж оролцсон.</p> <p>-“Эвийн Өргөө Энхийн гүйлтийн-2018” галт бамбар буухиалах ёслолын үйл ажиллагаанд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороо, БТСДС-ын багш, сурагчид хамтран оролцож, Энхийн галт бамбарыг нийслэлийн Баянзүрх дүүргээс хүлээн авч, Чингэлтэй дүүрэгт хүлээлгэн өглөө.</p>				
81	3.2.26	<p>Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хүн амын нас, хүйсийн онцлогт тохирсон хоол тэжээлийн талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, сургалт сурталчилгаа хийнэ.</p>	<p>ЕБС-ийн цайны газар болон хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд бүр эрүүл ахуйн норм стандартуудын талаарх сургалтуудыг зохион байгуулна.</p>	<p>Нийт 200 гаруй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид мэдээ мэдээлэл өгч, сургалтад хамруулсан байна.</p>	-	ХХҮХ	100%
<p>- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төв, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, дүүргүүдийн Засаг даргын тамгын газар, Хүнсчдийн холбоо хамтран “Давс багатай бүтээгдэхүүн</p>							

			<p>үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээг 2018 оны 01 сарын 11-ний өдөр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны хурлын зааланд зохион байгуулагдсан ба уг арга хэмжээнд дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 20 иргэн, аж ахуйн нэгжийн хамт оролцлоо. Сургалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд хүүхдийн хоолны орцон дахь давсны хэмжээг үе шаттайгаар багасгаж, давс багатай хоол үйлдвэрлэлийг үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.</p> <p>- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018.03.01-ний өдрийн “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал /СМР, СНР/ нэвтрүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулах тухай А/58 дугаар тушаалын дагуу дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Монголын хоол зүй, шим тэжээлийн үндэсний нийгэмлэгтэй хамтран нийт 3 удаагийн сургалт зохион байгууллаа. Сургалтанд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын үйлчилгээ эрхлэгч нийт 180 гаруй иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан бөгөөд тэдний үйл ажиллагааг дэмжих, үйлчилгээний чанар стандарт, салбарын ажилтнуудын ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Монголын хоол зүй, шим тэжээлийн үндэсний нийгэмлэгээс гаргасан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмж” аудио хичээл болон хоол үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, эрүүл ахуй, хяналтын тухай болон холбогдох хууль тогтоомжийн талаар холбогдох мэргэжилтнүүд мэдээ, мэдээлэл өгч гарын авлага, тараах материалаар хангалаа.</p> <p>- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хамтран зохион байгуулсан “Худалдааны хуулийн хүлээлт ба салбарын өнөөгийн байдал-2018” нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бизнес чуулганд дүүргийн худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгч нийт 50 аж ахуйн нэгжийг хамрууллаа. Хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын төлөөллүүд “Худалдаа, үйлдвэрлэл-2020” хөтөлбөрт оруулах саналаа тусгаж сэтгэгдлээ хэлж, санал солилцлоо.</p>					
3.3 Иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ								
82	3.3.1	ДЗДҮАХ-ийн 3.3.2 Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулна.	Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ.	Ажлын явц, хувиар	100	-	ТГХШХ	100%
			Дүүргийн орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, 5, 6, 19 дүгээр хороонд нийт 405,060.8 мянган төгрөгийн хүүхэд, ахмад настнуудад чөлөөт цагаа өнгөрөөх, амрах тохижилтын ажлын 4 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс 175,060.8 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. 230,000.0 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл он дамжин хэрэгжихээр төлөвлөгдсөн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3-р хороонд 35,000.0 мянган төгрөгийн тохижилтын ажлын худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж, зөвлөмжийг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.					
3.4 Газар өмчлөх ажлыг үргэлжлүүлнэ.								
83	3.4.1	НЗДҮАХ-ийн 2.2.7 ДЗДҮАХ-ийн 3.4.1	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012	Үйл ажиллагааны	100	-	ГА	100%

		"Зуслан" ерөнхий төлөвлөгөөний дагуу дүүргийн 15, 19, 20 дугаар хороодын зуслангийн газар өмчлөх ажлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан үргэлжлүүлнэ.	оны "Зуслангийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 25 дугаар тогтоолоор батлагдсан тус дүүргийн 15, 19, 20 дугаар хороодын 26 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газар өмчлөлийн ажлыг үргэлжлүүлэх ажлыг зохион байгуулна.	хэрэгжилт, хувиар				
		"Зуслангийн" ерөнхий төлөвлөгөөний дагуу газар өмчлөлийн ажлыг зохион байгуулж 4-р улирлын байдлаар 15-р хороонд 79 нэгж талбарт 4.803 га талбайд, 19-хороонд 382 нэгж талбарт 23.325 га талбайд, 20-р хороонд 453 нэгж талбарт 29 га талбайд тус тус газар өмчлөлийн ажил хийгдэж нийт 914 нэгж талбарт 57 га талбайд иргэд газраа үнэгүй өмчилж авсан байна. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх ажлын эрчимжүүлж 2018 онд зуслан болон, суурьшлын бүсэд Нийслэлийн Засаг даргын 14 удаагийн захирамжаар 1598 иргэнд 96,06 га газрыг өмчлүүлсэн байна.						
84	3.4.2	Дүүргийн зуслангийн газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ГА	100%	
		Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн харилцаа. 2018 оны 4-р улиралын байдлаар дүүргийн Дүүргийн Засаг даргын 27 удаагийн захирамжаар 1476 иргэнд зуслангийн газар баталгаажуулж 1751 иргэний 105.8 га газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхээр, 1671 иргэний 128.4 га газрын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж, талбайг өөрчлөн, 3 иргэний газар эзэмших эрхэд хамтран эзэмшигч нэмж, 1 иргэний 0.02 га газрын зориулалтыг өөрчилж, иргэний ахуйн зориулалтаар 251 иргэнд 8.7 га газрыг эзэмшүүлж, 2 аж ахуйн нэгжид 0.11 га газрыг эзэмшүүлж шийдвэрлэсэн байна. Зуслангийн орц гарц хаасан, хашаа сунгаж барьсан 46 иргэн, хуулийн этгээдийн зөрчил арилгаж эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Газар чөлөөлөлтийн хувьд Цэцэрлэг 4, сургууль 1, Сургууль цэцэрлэгийн цогцолборын 1 нийт 6 байршилд газар чөлөөлөлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.						
4. Иргэндээ үйлчлэх Сүхбаатар дүүрэг								
4.1 Төрийн үйлчилгээг иргэдэд цогц, хүртээмжтэй хүргэнэ.								
85	4.1.1	ДЗДҮАХ-ийн 4.1.1	Хороодын ажлын албыг камержуулсан нэгдсэн	Үйл ажиллагааны	100	-	ТЗУХ	100%

		Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэгдсэн программ хөгжүүлнэ.	системийг нэвтрүүлж, ажлын үр дүнг сайжруулна.	хэрэгжилт, хувиар					
			Дүүргийн төсвийн хөрөнгөөр 50,000 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хороодын ажлын албаны байрыг камержуулах ажлыг төлөвлөж, бүрэн хэрэгжүүлсэн.						
86	4.1.2		Онлайнд холбогдоогүй 12, 16, 18, 19, 20 дугаар бүхий 5 хороог онлайнд холбосноор хороонд бүртгэгдсэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийг төв сүлжээнд шууд дамжуулж, мэдээллийн санг бүрдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Мэдээллийн санг шуурхай, үнэн зөв мэдээллээр баяжуулсан байна.	-	БүрХ	70%	
			Швецарын хөгжлийн агентлагийн санхүүжүүлэлтээр Азийн сан, НЗДТГ хамтран хэрэгжүүлж буй "Хотын засаглалыг сайжруулах төсөл"-ийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор 2018 оны 7 дугаар сард 20 дугаар хороог онлайн програмд холбосноор, иргэний гэр бүлийн бүртгэлийн 8 төрлийн бүртгэл, цахим үнэмлэхний бүртгэлийг хороон дээрээ хийж байна. Бусад 4 хороо шилэн кабелийн сүлжээнд холбогдоод байна.						
			Иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай, цогц, хүртээмжтэй хүргэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэдэд төрийн үйлчилгээ, түргэн шуурхай хүрдэг болсон байна.	-	БүрХ	100%	
87	4.1.3		<p>2018 онд тус хэлтсээс иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах үйлчилгээг үзүүлээд байна. Үүнд:</p> <p>Иргэний улсын бүртгэл хөтлөлт: Гадаадад зорчих эрхийн бүртгэл-19420 Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл /шинээр иргэний цахим үнэмлэх авах/-1620 Иргэний үнэмлэх хугацаа сунгалт –2510 Иргэний үнэмлэх дахин олголт – 3251 Төрөлт – 3840 Үрчлэлт –65 Гэрлэлт –958</p>						

			<p>Гэрлэлт цуцлалт – 285 Нас баралтын бүртгэл –87 бүртгэлийг хийсэн байна. 2018 онд иргэний гэр бүлийн 8 төрлийн бүртгэлийн 8 100 000 төгрөг, шилжилт хөдөлгөөний хураамж-17 285 300, иргэний үнэмлэхийн хураамж-103 905 000, дүүргийн татварын албаны дансанд тэмдэгтйн хураамжийн орлого-28 667 100 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: Хүлээн авсан мэдүүлэг – 28193 Анхны бүртгэл – 2974 Өмчлөх эрх шилжих гэрээ – 3627 Барьцааны гэрээ – 12672 Барьцааны гэрээ – 431 Лавлагаа, хуулбар-2373</p> <p>зэрэг бүртгэлүүдийг хийсэн байна. Мөн дүүргийн татварын албаны тэмдэгтийн хураамжинд 25 897 076 төгрөг, Эд хөрөнгө худалдан борлуулснаас оруулсан татварын орлого-3 246 866 391 төгрөгийг төвлөрүүлсэн байна. МУ-ын Зөрчлийн тухай хуулийн дагуу иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн, бүртгүүлэх хугацаа хэтэрсэн зэрэг зөрчилтэй нийт 15971 иргэнд 34 455 000 төгрөгийн торгууль оногдуулсан байна. Энэ хугацаанд эд хөрөнгийн 764, иргэний-22242 материалыг шалгаж, дүгнэлт гаргасан байна.</p> <p>Эдгээр бүртгэлийн тоог өмнөх оныхтой харьцуулахад УИХ-аас баталсан Улсын бүртгэлийн ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ 2018 оны 11-р сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн бөгөөд энэ хууль хэрэгжсэнээр төрийн үйлчилгээ нээлттэй, ил тод байх, иргэдэд бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай, хөнгөн хүртээмжтэй хүргэх, бүртгэлийн цахим шинэ үйлчилгээг иргэдэд таниулах ойлгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх боломж бүрдэж байна.</p> <p>Шинэ хуулийн онцлог, давуу тал</p> <ul style="list-style-type: none"> - Иргэд 10 төрлийн бүртгэлийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй үйлчлүүлэх боломжтой болж байна. - Иргэдээс шаарддаг баримт бичгүүдийн тоо цөөрснөөр иргэдэд үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, цаг хэмнэх ашигтай болж байна. - Шинэчилсэн энгийн гадаад паспортыг 16-аас дээш насны иргэн 10 жил, 16-аас доош насны хүүхэд 5 жилийн хугацаатайгаар олгодог болсон. - Иргэд www.burtgel.mn цахим хаягаас 10 төрлийн лавлагааг авах боломжтой болсон. Үүнд: <ul style="list-style-type: none"> -иргэн төрсний, - гэрлэсний, гэрлэсэн эсэх, -гэрлэлт цуцлуулсныг бүртгүүлсэн тухай, - оршин суугаа газрын хаягийн, -цахим үнэмлэхийн, -хуулийн этгээд бүртгэлтэй - хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, - үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх, -үл хөдлөх эд хөрөнгийн дэлгэрэнгүй лавлагааг
--	--	--	--

			Хуулийн эдгээр онцлог, давуу талыг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор “Сүхбаатар дүүргийн иргэдэд Улсын бүртгэлийн багц хуулийг сурталчлах ажлын төлөвлөгөө” гарган Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу иргэдэд бүсчилсэн байдлаар хуулийг сурталчлан таниулах, ерөнхий боловсролын сурагчдад сургалт зохион байгуулах, гарын авлага, тараах материалыг шинэчлэн өөрчлөх зэрэг ажлуудыг хийсэн. Эдгээр арга хэмжээнд нийт 160 гаруй иргэн, 500 орчим сурагч оролцож, 600 гаруй тараах материалыг тараасан болно.				
88	4.1.4	Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд хороодыг бүрэн холбосноор алслагдсан хороодын иргэдэд үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний нэр төрөл, тоог нэмэгдүүлж, иргэдэд хүрч үйлчилнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Улсын бүртгэлийн үйлчилгээ онлайн горимд бүрэн шилжсэн байна.	-	БүрХ	100%
		Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Засгийн газраас баталсан “Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийн дагуу 2018 онд тус дүүргийн 16 хороонд мэдээллийн лавлагааны сан програмыг суулгаснаар иргэд иргэний гэр бүлийн бүртгэлийн бүх төрлийн лавлагааг харьяа хорооноос авах боломжтой болсон. Төслийн хүрээнд 2018 оны 7 дугаар сард 20 дугаар хороог онлайн програмд холбосноор иргэний гэр бүлийн бүртгэлийн 8 төрлийн бүртгэл, цахим үнэмлэхний бүртгэлийг хороон дээрээ хийж, бүртгэлийн төлбөр тооцоонд бэлэн мөнгөний ПОС машиныг ашигласнаар тус хорооны иргэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлүүлж байна. Энэ хугацаанд тус хороо төрсний бүртгэл-81, гэрлэлтийн бүртгэл-15, нас баралтын бүртгэл-3, иргэний үнэмлэхний бүртгэл-136 бүртгэлийг хийсэн байна.					
89	4.1.5	“Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийн хүрээнд улсын бүртгэлийн үйл ажиллагаа онлайн горимд шилжсэнээр үндэсний цахим баримт бичгийн хэрэглээ, үйлчилгээний нэр төрөл, тоо нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Төрийн үйлчилгээг иргэдэд цогц, хүртээмжтэй хүргэсэн байна.	-	БүрХ	100%
		“Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийн дагуу 2018 онд тус дүүргийн 16 хороонд мэдээллийн лавлагааны сан програмыг суулгаснаар иргэд иргэний гэр бүлийн бүртгэлийн бүх төрлийн лавлагааг харьяа хорооноос авах боломжтой болсон. Энэ хугацаанд нийт 10 төрлийн 1945 лавлагаа олгосон байна.					

			<p>Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох” ТА-9372 МОН (51135-001) төслийг 2017-2020 онд хэрэгжүүлж байна.</p> <p>Энэхүү төсөл нь улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, шинэчлэн батлагдсан хууль эрх зүйн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн үйлчилгээг хялбарчлах, алслагдсан сумд, хороодыг бүртгэлийн нэгдсэн системд холбох, иргэний бүртгэлийн цахим үйлчилгээг олон нийтэд түгээх, бүртгэлийн нэгдсэн санг хөгжүүлэх, сайжруулах, чадавхыг бэхжүүлэх зорилготой.</p> <p>Төслийн хүрээнд 2018 оны 7 дугаар сард 20 дугаар хороог онлайн програмд холбосноор иргэний гэр бүлийн бүртгэлийн 8 төрлийн бүртгэл, цахим үнэмлэхний бүртгэлийг хороон дээрээ хийж, бүртгэлийн төлбөр тооцоонд бэлэн мөнгөний ПОС машиныг ашигласнаар тус хорооны иргэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлүүлж байна. Энэ хугацаанд тус хороо төрсний бүртгэл-81, гэрлэлтийн бүртгэл-15, нас баралтын бүртгэл-3, иргэний үнэмлэхний бүртгэл-136 бүртгэлийг хийсэн байна.</p>					
90	4.1.6		Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хогийн цэгүүдийг нэгдсэн камерын системд оруулж, хяналтыг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ТЗУХ	70%
			<p>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2017 оны тохижилт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хог хаягдлын менежмент, хяналтыг сайжруулах зорилгоор ил задгай хог хаягдал үүсдэг, гэмт хэрэг зөрчил ихээр гардаг 25 байршилд 25 нэг чигийн камер, 23 ширхэг 360 градус эрэгдэг хяналтын камер байршуулан байнгын хяналт тавин ажиллаж байна. Тус камеруудын болон өмнөх онуудад хийгдсэн камерийн засвар болон цэвэрлэгээ үйлчилгээг Инно Солюшн ХХК хариуцан хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. 2018 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11-18 дугаар хороодод тус бүр 8 ширхэг хяналтын камер шинээр байршуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>					
91	4.1.7	НЗДҮАХ-ийн 5.3.7 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.1.3 Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана.	Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан, түргэн шуурхай шийдвэрлэн ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ТЗУХ	70%
			<p>Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана</p> <p>Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар 2018.01.01-ний өдрөөс 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл нийт 666 өргөдөл хүсэлт хүлээн авсан байна. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 645, шийдвэрлэх шатандаа байгаа 19, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 2 өргөдөл хүсэлт байна.</p> <p>Өргөдөл хүсэлтийг хандалтаар нь авч үзвэл Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн тухай 49</p>					

		<p>Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай 45 Явган хүний зам, талбайн тохижилтын тухай 37 Дүүргийн Засаг даргын бодлого үйл ажиллагааны тухай 37 Бусад 535 Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 10 цаг 24 минут байна.</p>					
92	4.1.8	<p>Цахим бүртгэлд өргөдөл гомдол бүртгэж оруулах, шийдвэрлэх, Мэргэжлийн байгууллагуудтай хамтран иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж, иргэнд холбогдох хариуг цаг тухайд нь хүргүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	-	МХХ	100%
<p>Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 785 хүсэлт, өргөдөл, гомдол хүлээн авснаас 85 хувь шийдвэрлэн хариуг хүргүүлсэн, 15 хувь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Хүсэлт, өргөдөл, гомдлыг цахим бүртгэлд тухай бүр оруулж ажиллалаа. Ирсэн өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийн хугацаа 1-9 хоног байна. Албан бичиг, өргөдөл гомдлын мэдээг НХМГ-ын төв бичиг хэрэгт 7 хоногийн лхагва гариг бүр хүргүүлж ажилласан.</p>							
93	4.1.9	<p>Иргэдийн өргөдөл гомдлыг цахим бүртгэлд оруулж, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг багасгах арга хэмжээг авч, иргэнд холбогдох хариуг цаг тухайд нь хүргүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>Иргэдийн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж байна.</p>	-	Бүх	100%
<p>Иргэдээс тус хэлтсийн үйл ажиллагаа, албан хаагчдад хандсан нийт 26 өргөдөл гомдлыг бүртгэн авч, хуулийн хугацаанд нь шуурхай шийдвэрлэж, иргэнд хариуг утсаар болон албан бичгээр өгч байна. Албан хаагчдад хандсан өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн хариуг тухайн ажилтнаас бичгээр хүлээн авч, хэлтсийн даргад тухай бүр танилцуулан ажиллаж байна. Тус хэлтсийн ажилтан албан хаагчид иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлын хариуг шуурхай шийдвэрлэх, ажлын хариуцлагаа дээшлүүлж, зан харьцаанд байнга анхаарч, гомдол санал гаргахгүй байх талаар анхаарч ажиллаж байна.</p>							

			Хугацаа хэтэрсэн, шийдвэрлээгүй өргөдөл гомдол байхгүй байна.					
94	4.1.10		Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэж, иргэнд холбогдох хариуг цаг тухайд нь хүргүүлнэ.	Хугацаа хэтэрсэн болон, буруу шийдвэрлэсэн өргөдөл гомдолгүй байна.	Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг 100 хувь барагдуулсан байна.	-	ХХҮХ	100%
			Иргэд болон аж ахуй нэгж байгууллагаас smartcity.mn программаар ирүүлсэн 82 хүсэлт, санал, гомдлыг дүүргийн Газрын алба, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Цагдаагийн хэлтэс, Хороодын Засаг дарга нартай хамтран газар дээр нь очиж зохих журмын дагуу шийдвэрлэн, гомдол гаргасан иргэн болон мэдээллийн эх сурвалжуудад холбогдох хариуг утсаар, биеэр уулзаж болон албан бичгээр хүргүүлж шуурхай барагдуулсан.					
95	4.1.11		Байгууллагын хүсэлт, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийн дагуу санхүүгийн хяналт шалгалт хийж хариуг өгч ажиллана.	Монгол Улсын “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хэрэгжилт хангана.	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	-	ДАА	100%
			2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн дүүргийн ЗДТГ-аас 1/181 тоот албан бичгийн дагуу дүүргийн Ахмадын хорооны 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд иргэн С.Сэнгээгийн гомдлын дагуу хэсэгчилсэн аудит хийж дүнг 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 09 тоот албан бичгээр, Дүүргийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 1/2292 тоот албан бичгийн дагуу дүүргийн Ахмадын хорооны 2013-2017 он, 2018 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийж дүнг 2018 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 38 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн болно.					
96	4.1.12	НЗДҮАХ-ийн 1.6.1, 5.3.11, 1.4.7, 3.2.4, 3.2.9, 4.8.3, 5.4.9 дахь заалт,	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 35-40	2018 онд дотоод аудит, санхүүгийн	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	-	ДАА	100%

		<p>ДЗДҮАХ-ийн 4.1.4</p> <p>“Хяналт, шалгалтыг сайжруулж, төрийн үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлнэ”</p>	<p>байгууллагын санхүү аж ахуйн болон үйл ажиллагаанд санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны засгийн газар, байгууллага иргэдээс олгосон зээл, өгсөн хандив тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт зарцуулалтад хяналт тавьж, зөвлөн тусалж ажиллана.</p>	<p>хяналт шалгалтад хамрагдах байгууллагуудын хуваарь гарган төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулна.</p>	<p>болон бусад холбогдох хууль тогтоомж заавар журам, стандартын хэрэгжилт хангагдсан байна.</p>			
<p>2018 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний төрийн бус өмчийн 35 цэцэрлэг, төрийн өмчийн 33 цэцэрлэгийн хувьсах зардал, гүйцэтгэлийн аудит хийж 64,041.2 мянган төгрөгийн зөрчил /68 нэгж/ төрийн өмчийн МОХ 3-р сургууль, 1, 2, 3, 4, 6, 16, 31, 35, 45, 58, 71, 131, АЗЭС, БТСДС зэрэг 15 сургууль, БТСХороо, ХГБХТ, 1, 2, 36, 40, 42, 130, 135, 150, 159, 171, 175 зэрэг 11 цэцэрлэгийн зэрэг 28 байгууллагын 2017 он, 2018 оны 2 улирлын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит хийж нийт 6,313,089.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах дахин давтахгүй байх зөвлөмж өгч ажилласан. Тусгай шилжүүлгийн төрийн өмчийн ШУТИС КООСЭН, ШУТАС, БЭЛС, МУБИС ЕБС, АШУИС ЕБСургуулиудын “Бага дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”-ын 2017 он, 2018 оны 3-р улирлын санхүүжилтийн гүйцэтгэлд гүйцэтгэлийн аудит хийж тайланг 2018 оны 11 дүгээр сарын 30 нд хүргүүлнэ.</p> <p>2017 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 41 байгууллагад дотоод аудит Сангийн яамны нэгдсэн удирдамжаар 2 байгууллагад СХШ хийж 2,792,140.1 мянган төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж зөвлөмж өгч ажилласан ба 2018 онд нийт 32 байгууллага, 68 нэгжид дотоод аудит хийж, 1 байгууллагад Сангийн яамны нэгдсэн удирдамжаар СХШ хийж, нийт 6,325,240.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж зөвлөмж өгч ажилласан байна. Нийт зөрчлийн 90,9 хувь буюу 5,754,754.9 мянган төгрөгийн зөрчил нь МОХС, 45-р сургууль, 135-р цэцэрлэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад</p>								

		<p>хүлээлгэж өгсөн сургууль, цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, хандив тусламжаар хийж өгсөн “Тохижилтийн ажил”-г орлогод авч данс бүртгэлд тусгаагүй зөрчил эзэлж байна.</p> <p>Тус алба нь Эрсдэлд суурилсан аудит хийхээр төлөвлөж, хэрэгжүүлдэг ба аудитад хамрагдсан байгууллагуудын санхүү аж ахуйн үйл ажиллагаанд эрсдэл бууруулах ба эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.</p> <p>Дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудад хөрөнгө оруулалт олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, хандив, тусламж, орон нутгийн хөгжлийн сан, тэдгээртэй адилтгах байгууллагаас өгсөн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавихаар төлөвлөгөө, хөтөлбөрт батлуулан аудит хийхэд:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан МОХ 3-р сургуулийн 320 хүүхдийн хүчин чадалтай 4,268,574.6 мянган төгрөгийн өртөг бүхий хичээлийн байрны өргөтгөлийн барилга”-г 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Улсын комиссын 2017/464 дугаартай актаар ашиглалтад оруулахаар улсын комисс хүлээж авсан. - 45-р сургууль “Эцэг эх хүүхэд хөгжлийн ирээдүй” НҮТББ нь 2016-2017 оны хичээлийн жилд эцэг эхчүүдийн хандиваар хийж хүлээлгэн өгсөн 48,053.5 мянган төгрөгийн “Тохижилтын ажил”. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,438,126.8 мянган төгрөгийн өртөг бүхий 135-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг 2016 оны 10 дугаар сарын 05-нд Улсын комиссын 2016/394 дугаартай актаар ашиглалтад хүлээж авсан нийт 5,754,754.9 мянган төгрөгийн өртөг бүхий барилгуудыг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй байгаа зөрчил байна. <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 66 тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-н 3.7-д “Нийслэлийн өмчит хуулийн этгээдэд улсын төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр бүртгэх шийдвэрийг энэ журмын 3.2-т заасны дагуу гаргаж, данс бүртгэлд тусгана” гэж заасныг үндэслэн холбогдох баримт материалыг үндэслэн Нийслэлийн өмчийн харилцааны газраас зөвшөөрөл авсны үндсэн дээр 2018 оны жилийн эцсийн тайлангаар орлогод авч данс бүртгэлд тусгахаар зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - МОХ 3-р сургууль нь 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 223 тоот албан бичгээр холбогдох баримтыг бүрдүүлж 2018 оны жилийн эцсийн тайлангаар орлогод авахаар бэлэн болгосон тухай, хариу ирүүлсэн. - 45-р сургууль 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 181 тоот албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг хагаж ажилласан тухай хариу ирүүлж, захирлын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/41 тоот тушаалаар “эцэг эхчүүдийн хандиваар:хийж хүлээлгэн өгсөн 48,053.5 мянган төгрөгийн “Тохижилтын ажил”-ын гүйцэтгэлийг холбогдох баримтыг бүрдүүлж орлогод авсан байна. - 135-р цэцэрлэгээс зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байгаа ба Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 оны 10 дугаар сард баригдсан 1,438,126.8 мянган төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг өмчид бүртгэх асуудлаар 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 46 тоот албан бичгийг НӨХГазарт дахин явуулсан. НӨХГазраас болон тус цэцэрлэгээс
--	--	---

			Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2018 оны 10 дугаар сарын 03-ны 67 тоот албан тоотоор хүсэлт явуулсан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.					
97	4.1.13	Аялал жуулчлал, амралт, газруудад шалгалт хийнэ.	жуулчлал, сувиллын хяналт	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	МХХ	100%
		<p>Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй амралтын газруудад удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ.</p> <p>Шалгалтанд Багабаян Энхийн төлөө цогцолбор төв, Молор трейд ХХК-ийн ахмадын амралт, Нуган трейд ХХК-ийн Сэлбэ ресорт, Оптимум прогресс ХХК-ийн Санзай амралт, Топклийн ХХК-ийн Баянбулаг, Омега ХХК-ийн “Номун” амралт, иргэн Г.Ганбаатарын “My house” амралтыг хамрууллаа.</p> <p>Дээрх амралтын газруудаас ундны усны 7 дээж, 4 сорьц авч, нян судлал, химийн шинжилгээ хийлгүүлэхээр НМХГ-ын төв лабораторит хүргүүлээд байна. Зөрчилтэй байсан 3 аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага өгч биелэлт 86.5%-тай байна. Дээрх газруудад улсын байцаагчийн зөвлөмж өгч ажиллалаа.</p> <p>Шинжилгээний дүнгээр Омега ХХК-ийн “Номун” амралт, иргэн Г.Ганбаатарын “My house” амралтын газрын гүн өрмийн худгийн ус нянгийн бохирдолтой байгаа нь Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангахгүй байгаа тул зөвхөн ахуйн зориулалтаар хэрэглэх талаар дүгнэлт гаргаж хүргүүлээ.</p> <p>Хяналт шалгалт 2018 оны 6-7 сард хийгдсэн ба 2017 онд дээрх газрууд нь ундны усны шаардлага хангаж байсан ба 2018 онд шаардлага хангахгүй гарч байгаа нь шар усны үер, хур бороо элбэг, ариун цэврийн байгууламжгүй, бохирын шугамд холбогдоогүй зэрэг нь шалтгаан нөхцөл болж байна.</p>						
98	4.1.14	Хууль бус мод бэлтгэлийг зогсооход сэргийлэх шалгалт хийнэ.	бус таслан урьдчилан хяналт	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	МХХ	70%
		<p>Шалгалтын явцад иргэн М.Болор-Эрдэнэ, П.Нямсүрэн нар Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо Санзай, Хандгайтын богинод Сэлэнгэ, Хөвсгөл аймгаас худалдан авч оруулж ирсэн 5 торх нь мод, модон материалын гарал үүслийн бичиггүй байсан тул Монгол улсын Эрүүгийн тухай хуулийн 24.6 дугаар зүйлийн дагуу дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэст харьяалалын дагуу шилжүүлж ажилласан. Дүүргийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж буй Багабаян энхийн төлөө цогцолбор төв, Нуган трейд ХХК-ийн “Сэлбэ ресорт” амралтын газарт албан шаардлага өгч, Сонгинохангай ХХК, Гурван эвтэн ХХК-нд лангуу түрээсэлж буй 4 иргэнд Амьтны тухай хууль, зөрчил гарсан үед хүлээлгэх хариуцлага, загас барих тоо хэмжээ, хугацаа, төлбөр хураамжийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Хяналт шалгалт 2018 оны 4,5 сар, 9,10 сард хийсэн ба 2017 онд шалгалтад хамрагдсан иргэд нь амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг гарал үүслийн бичиг дагалдах тодорхойлолтгүйгээр худалдан борлуулж байсан зөрчил илэрсэн бол 2018 онд дээрх зөрчлийг арилгуулсан үр дүнтэй байна.</p>						

99	4.1.15		Ундны усны эх үүсвэрийн хориглолтын бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжид шалгалт хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	МХХ	100%
			<p>02-01/132 дугаар удирдамжийн дагуу УСУГ-ын харьяа шугамаар ус хангах албаны 10 ус түгээх байр, 27 иргэний гүний худаг, 6 аж ахуйн нэгжийн гүний худаг, 1 гол, 2 булагийн уснаас дээж авч шинжилгээнд хамруулан хяналт шалгалт хийлээ. 10 ус түгээх байрыг 3.5 кодтой “Ундны усны чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-аар эрсдлийг үнэлэхэд 1 бага эрсдэлтэй, 9 дунд эрсдэлтэй гарсан бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилт 68-76%-тай байна. Шалгалтаар нийт 60 дээжинд шинжилгээ хийхэд 1 аж ахуйн нэгж, ус түгээх 1 худаг, 6 иргэний гүн өрмийн худгийн ус нянгийн бохирдолтой байгаа нь Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангахгүй байна. УСУГ-ын Ус хангах албанд 02-03-375/119 дугаартай албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, шинжилгээний дүнд 02-03-375/69 дугаартай дүгнэлт гарган, шалгалтын дүнгийн талаар дүүргийн Засаг даргад албан тоот хүргүүлэхээр бэлдэж байна. Хяналт шинжилгээний явцад 31 зөрчил илрүүлэн, 70 хувийг нь арилгуулж, унд ахуйн усны чанар найрлагад хийсэн шинжилгээний дүнг үндэслэн, 2 иргэнд 150.000 төгрөгийн торгууль ноогдуулж, 20 дүгнэлт, 6 зөвлөмж гарган хүргүүлээд байна.</p> <p>2017 онд хяналт шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангаж байсан ба 2018 оны 5 сар, 7 сар, 9 сард хийсэн хяналтаар нянгийн тоо шаардлага хангахгүй гарч байгаа нь шар усны үер, хур бороо элбэг, ариун цэврийн байгууламжгүй, бохирын шугамд холбогдоогүй зэрэг нь шалтгаан нөхцөл болж байна. Шугамаар ус түгээх цэгийн усанд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийгдснээр гадна тохижилт, засвар үйлчилгээ сайжирч, ард иргэд стандартын шаардлага хангасан усаар хангагдах нөхцөл бүрдэж байна.</p>					
100	4.1.16		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд барилга байгууламж, зам талбай, хөдөлмөр эрхлэлтийн байдалд хяналт шалгалт хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	МХХ	100%
			<p>Шинээр үйл ажиллагаа эрхэлж буй барилга байгууламж, зам талбайн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн стандарт хангаж байгаа байдалд 11 барилгыг хамруулан хяналт шалгалт хийж гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүний амь нас эрүүл мэндийг хамгаалах, ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих зорилгоор арга хэмжээ авч, хэрэгжүүлж ажиллах талаар ажил олгогч нарт мэдэгдэл хүргүүлж ажиллалаа.</p>					

101	4.1.17	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэгийн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангаж байгаад хяналт шалгалт хийнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	-	МХХ	100%
		<p>Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй хүнсний худалдаа, үйлчилгээний чигэлэлээр үйл ажиллагаа явуулж байсан 9 ТҮЦ /Эрхүүгийн гудамж 4-р байр, МҮЭСТО-ны зүүн талын автобусны буудал, АШУҮИС-ийн зүүн талд, Үйлдвэрчин хотхон, 100 айлын автобусны буудалд/-ийг нүүлгэсэн. Иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон дээд байгууллагын үүрэг болгосны дагуу 21 ТҮЦ-т хяналт шалгалт хийж Зөрчлийн тухай хуулийн дагуу 2950.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулсан.</p> <p>Мөн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 85 ТҮЦ-т нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх тухай Газрын алба, дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн хамтарсан шаардах хуудсыг өглөө.</p> <p>Улсын бүртгэлийн газрын хашаанд байсан 2 ТҮЦ гадна талд 1 ТҮЦ-ийг нүүлгэсэн байна.</p> <p>Дүүргийн Засаг даргын А/306, А/151 дүгээр захирамжинд заасан нэр 42 ТҮЦ нүүлгэхээс 9 ТҮЦ нүүлгэсэн.</p>					
102	4.1.18	<p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн, болон дээд байгууллагын шийдвэрээр тусгайлсан аудит болон санхүүгийн хяналт шалгалт хийнэ.</p>	<p>Үүрэг даалгавар, гаргасан хүсэлтийг хуулийн хүрээнд шалгаж, дүгнэлт, зөвлөмж гаргана.</p>	<p>Зөрчил дутагдал арилж, хууль тогтоомжийн биелэлт хангагдан, төсвийн үр ашиг дээшилсэн байна.</p>	-	ДАА	100%
		<p>Сангийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдөр баталсан, Татварын ерөнхий газар болон түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамжийн дагуу дүүргийн Татварын хэлтсийн 2016, 2017 оны, татварын ноогдуулалт, төлөлт, өр авлага санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийхэд ГТЕГ-ын даргын 2016 оны А/88 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтэц чиг үүргийг баталж, 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/195 дугаар тушаалаар 6 тасагт 108 орон тоотой ажиллахаас 115 албан хаагч 32 орон тооны бус байцаагчтай ажиллаж байгаад, 2016 оны 7 дугаар сараас татварын байгууллага бие даасан агентлаг болж, ТЕГ-ын даргын 2016 оны 09-р сарын 07-ны өдрийн А/03 дугаар тушаалаар харьяа нэгжийн бүтэц, чиг үүргийг шинэчлэн баталснаар бүтэц орон тоог өөрчлөөгүй. ТУАБ 8, ТУБ 93, хураагч 14, ТҮ-ний 10 нийт 125 албан хаагч, орон тооны бус байцаагч 41 ажиллаж батлагдсан орон тооноос 17 байцаагч орон тооны бус 9 нийт 26 орон тоо илүү ажиллаж байна.</p>					

			<p>Санхүүгийн хяналт шалгалтаар 12,151,0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажиллав.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг мөрдөж ажиллах; - 2016 оны 09 дүгээр сарын 09 нд баталсан “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай “47 дугаар тогтоолоор “Бүх шатны төсвийн захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах” гэж заасныг хэрэгжүүлж бүтэц орон тоо батлуулж ажиллах; - Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны бүртгэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж ХХК-д харуул хамгаалалтын зардалд илүү шилжүүлсэн 867,5 мянган төгрөгийг “Скай фортун” ХХК-с төлүүлэн авах; - Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийн шинэчлэн тогтоох тухай “Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай 2014 оны 332-р тогтоолоор заасан албан тушаалын цалингийн сүлжээг баримтлан цалинг шинэчлэн тогтоож ажиллах; - Хөрөнгийн ангилалыг буруу бүртгэж 18 нэрийн 3,940.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эргэлтийн хөрөнгө бараа материалын дансанд бүртгэснийг залруулах, биетээр байгаа боловч баримтгүйгээр данснаас хассан 8 нэрийн 1,336.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг буцааж бүртгэлд тусган холбогдох журмын дагуу шийдвэрлэх; - ТЕГ-ын даргын 2016 оны 09-р сарын 07-ны өдрийн А/03 дугаар тушаалаар харьяа нэгжийн бүтэц, чиг үүргийг шинэчлэн баталсан боловч бүтэц орон тоог өөрчлөөгүй байна. Шинэчлэн батлуулах талаар Татварын Ерөнхий Газарт саналаа хүргүүлж шийдвэрлүүлэх. - Бүх салбар, ажил үйлчилгээ, эрхлэгчдийг НӨАТ-ын системд бүрэн хамруулах зэрэг зөвлөмжийг өгснийг хэрэгжүүлж хариуг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/3413 тоот албан бичгээр ирүүлсэн. 					
103	4.1.19	<p>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран нээлттэй өдөрлөг зохион байгуулна.</p>	<table border="1" data-bbox="734 1018 2089 1265"> <tr> <td data-bbox="734 1018 1070 1265">Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</td> <td data-bbox="1070 1018 1301 1265">100</td> <td data-bbox="1301 1018 1637 1265">-</td> <td data-bbox="1637 1018 1973 1265">ХХҮХ</td> <td data-bbox="1973 1018 2089 1265">100%</td> </tr> </table> <p>Олон улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг угтан хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, цахим худалдаа, найдваргүй цахим худалдан авалтаас сэргийлэх талаарх хэрэглэгчдийн мэдлэг боловсрол, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Цахим худалдаан дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалъя” сэдвээр хэрэглэгчдэд зориулсан сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг Мэргэжлийн хяналтын хэлтэс, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Нийслэлийн болон дүүргийн</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ХХҮХ	100%
Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ХХҮХ	100%				

			<p>хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг танилцуулж, “Худалдаа үйлчилгээнд тавигдах шаардлага”, “Эрүүл зөв зохистой дадал” сэдвүүдээр хэрэглэгчдэд хууль эрх зүйн мэдлэг олголоо. Сургалтанд худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл болон хороодоос нийт 102 иргэн хамрагдлаа. 2018 оны 03 сарын 09-ний өдрийн А/25 дугаар тушаалаар 515000 төгрөгөөр 410 ширхэг “Цахим худалдаан дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалъя” зурагт хуудсыг хэвлүүлэн томоохон худалдааны төвүүд, супермаркет, ресторан, кафе, үйлдвэрүүдийн газрууд болон дүүргийн 20 хороодын мэдээллийн самбарт байрлуулан, мэдээллийг түгээн ажиллаж байна.</p> <p>Мөн дүүргийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга Л.Энхмаа 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн нэг цонхны үйлчилгээний 9 дүгээр цонхонд ажиллаж хэрэглэгчдэд мэдээ мэдээлэл өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.</p> <p>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Сүхбаатарын талбайд “Хүүхдийн ертөнц” нэртэй дүүргийн хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээн дээр дүүргийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс дүүргийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн дарга Л.Энхмаатай хамтран “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2018.05.25-ны өдрийн “Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” А/188 дугаар захирамжийн дагуу “Хүүхэд-Хэрэглэгч” сэдэвт хүүхдэд хэрэглээний талаарх мэдлэг, соёлд мэдээлэл өгөх зорилготой 400 ширхэг гарын авлагыг 200000 төгрөгөөр хэвлүүлэн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүүхдүүдэд тараан ажиллалаа.</p> <p>“Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд 2018 оны 10 дугаар сарын 22, 23-ний өдөр болсон “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний зөвлөгөөн”-д оролцож дүүргийн Орон тооны бус салбар зөвлөлийн 2018 онд хийсэн ажлын тайланг танилцууллаа.</p> <p>“Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2017-2018 онд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан болон 2019 онд зохион байгуулан ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг Орон тооны бус салбар зөвлөлийн даргаар батлуулан Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 2/2887 дугаар албан бичгээр хүргүүлэв.</p>				
104	4.1.20	Дэн буудал, зочид буудал, амралтын газар, Гээст хаусд үйлчилгээний чанар, стандартыг хангуулна.	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй дэн буудал, зочид буудал, амралтын газрын ажилчдад 2 удаа сургалт зохион байгуулна.	Үйлчилгээний соёл, стандартыг хангасан байна.	-	ХХҮХ	100%

			<p>1. Дүүргийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дэн буудлуудад хяналт шалгалт явуулах тухай А/358 дугаар захирамж гарсны дагуу ажлын хэсэг 2017 оны 11 дүгээр сарын 6-наас 10-ны өдрийг хүртэл дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй дэн буудлуудад хяналт шалгалт хийсэн.</p> <p>2. Энэхүү шалгалтын гүйцэтгэлийг хянах, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй дэн буудлуудын үйл ажиллагааг зогсоох зорилгоор дүүргийн Прокурорын газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэстэй хамтран 2018 оны 01 сарын 05-ны өдөр зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй дэн буудлуудаар шалгалт хийлээ. Шалгалтад нийт 26 дэн буудал хамрагдсанаас зохих зөвшөөрөлгүй, стандартын шаардлага хангаагүй 7 дэн буудлын үйл ажиллагааг зогсоон лацдаж, зөрчилтэй үйл ажиллагаа явуулж байсан 7 дэн буудалд 2,400,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч зөрчлийг газар дээр нь арилгуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.</p> <p>Стандартын шаардлага хангадаггүй, байнга хэрэг зөрчил гарч байдаг 4 дэн буудал / Фокус, Зүүм, Од, Тайга/ Нийслэлийн аялал жуулчлалын газраас зөвшөөрөл авсан байсан тул эдгээр дэн буудлын зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг 2018 оны 01 сарын 09-ний өдрийн 8/52 дугаар албан бичгээр Нийслэлийн аялал жуулчлалын газарт хүргүүлснээр зөвшөөрлийг хүчингүй болгон стандартын шаардлага хангуулахаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж гүйцэтгэлийн хяналт хийхэд Фокус болон Од дэн буудал зөрчлөө арилган засвар үйлчилгээ хийж стандарт хангасан учир Нийслэлийн аялал жуулчлалын газраас зөвшөөрлөө авч үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.</p> <p>3. Нийслэлийн аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Амарын хамт дэн буудлын зөвшөөрөл сунгах хүсэлтийн 6 дэн буудлын үйл ажиллагаа, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтанд хамрагдсан газрууд 100% дэн буудлын стандарт хангахгүй байсан учир зөвшөөрөл сунгахыг түр түдгэлзүүлж, зөрчил дутагдлаа арилгах, стандарт шаардлага хангах хугацаатай үүрэг өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.</p> <p>4. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй дэн буудлын үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч П.Даваатөмөр, Г.Оюун нартай хамтран “Дэн буудлын эрүүл ахуйн нөхцөл, стандартын хэрэгжилт, түүнд тавих хяналт” сэдвээр 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт 40 гаруй дэн буудлын захирал, менежерүүд хамрагдсан бөгөөд үйлчилгээ эрхлэхэд тулгамдаж буй асуудал, стандартын хэрэгжилтын талаарх асуултанд хариу мэдээлэл өгч гарын авлага бүхий тараах материалыг үйлчилгээ эрхлэгчдэд тараан ажиллалаа.</p> <p>5. Зочлох, үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төвтэй хамтран 2018.09.25-ны өдөр дэн буудал, зоогийн газрын үйлчилгээ эрхлэгч 10 аж ахуйн нэгжид “Бизнесийн концепцоо хэрхэн загварчлах тухай”, “Үйлчилгээний чанар ба борлуулалтыг хэрхэн удирдах вэ” сэдэвт сертификат олгох сургалт зохион байгуулж, ном гарын авлагаар хангасан.</p> <p>6. Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төвтэй хамтран 11 дүгээр сарын 14-ний өдөр дүүргийн 9 давхарын хурлын танхимд “Зочлох үйлчлэх салбарын үйлчилгээ” сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтанд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй зочид буудал, дэн буудал, рестораны үйлчилгээ эрхлэгч 50 аж ахуйн нэгжийн захирал, менежерүүд хамрагдаж үйлчилгээний чанар, борлуулалт,</p>
--	--	--	--

		<p>үйлчилгээний аажилтны харилцаа, хандлага, хоолны цэс төлөвлөлт, зочид буудлын бизнесийн загвар зэрэг үйл ажиллагаанд нь зайлшгүй шаардлагатай мэдээ, мэдээллийг олж авлаа.</p> <p>Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэгчдийг сургалтанд хамруулж, холбогдох стандартын талаарх мэдээллийг олгосноор дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт дэн буудлуудын 60 орчим хувь нь стандартын шаардлагыг ханган зохих зөвшөөрлөө авсан бөгөөд 2017 онтой харьцуулахад энэ үзүүлэлт 20%-аар өссөн байна.</p>					
105	4.1.21	<p>Үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хуулийн дагуу хяналт шалгалт хийж, үр дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлнэ.</p>	<p>Үйлчилгээ эрхлэх гэрээ шинээр авах болон сунгах, архи, тамхины хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Үйлчилгээний стандарт шаардлага хангасан газруудын үйлчилгээ эрхлэх гэрээг олгож, архи, тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	-	ХХҮХ	100%
<p>НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журмын хэрэгжилтийг хангаж, худалдаа, үйлчилгээний чиглэлээр зөвлөгөө авах, үйлчилгээ эрхлэх гэрээгээ сунгуулах, шинээр гэрээ байгуулах хүсэлттэй нийт 2500 гаруй аж ахуйн нэгж, байгууллага иргэдийг хүлээн авч, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, ажлын байрны гаднах хаяг, гэрэлтүүлэг, тохижилтыг сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгч, холбогдох стандартын шаардлага хангасан 1118 үйлчилгээний байгууллагыг бүртгэл мэдээллийн санд бүртгэж, худалдаа, үйлчилгээний байгууллагатай Үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Мөн дараах чиглэлүүдээр хяналт шалгалтын ажлууд хийгдэж, хяналтын ажлын үр дүнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар зөвлөн туслах, үр дүнг мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, үйл ажиллагаанд нь байнгын хяналт тавин, биелэлтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>1. Тус дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Прокурорын газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2018 оны 01 дүгээр сарын 05-наас 07-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй дэн буудал 11, саун массажны 8 газар, Цахим тоглоомын 15 газарт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд Тамхины хяналтын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>2. Нийслэлийн Онцгой комиссын 2018 оны 01 дүгээр Албан даалгавар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны 02-01/129 тоот Мэдэгдлээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу өвчний голомттой, сэжигтэй бүс нутгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нийслэлд тээвэрлэх, худалдах, бүх төрлийн малын шилжилт хөдөлгөөнийг зогсоох зорилгоор дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, 16-20 дугаар хороодын Ажлын албатай хамтран хяналт шалгалт явуулж, мал тооллогын дүнгээс хойш мал нэмж оруулж ирсэн 6 өрхөд МХХ-ийн улсын байцаагчийн зөрчлийн тэмдэглэлээр хориглосон бүсээс малаа 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргахыг шаардаж, дүүргийн Засаг даргын</p>							

		<p>орлогчийн 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 2/327-2/330 тоот албан бичгээр 16, 18, 19 дүгээр хороодын Засаг дарга нарт байнгын хяналт тавих үүрэг чиглэл өгч, биелэлтийг хангуулан, малыг зөвшөөрөгдсөн бүсээс бүрэн гаргаж, дууссан.</p> <p>3. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2018 оны 04 сарын 06-ний өдрийн А/87 дугаар тушаал, “Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдааны газруудыг аттестатчилах” удирдамж, дүүргийн Засаг даргын 2018 оны 04 сарын 17-ны өдрийн Шалгалт хийх тухай А/37 дугаар захирамжаар 310.000 төгрөгийн унааны зардал батлуулан ажлын хэсгийн хамт шалгалтыг зохион байгуулж согтууруулах ундаагаар үйлчлэх 48, худалдах 41 тусгай зөвшөөрлийг сунгах, согтууруулах ундаагаар үйлчлэх 8, худалдах 2 тусгай зөвшөөрлийг цуцлах, согтууруулах ундаагаар үйлчлэх 3, худалдах 2 тусгай зөвшөөрлийг түр түдгэлзүүлэх саналыг УБ хотын Захирагчийн Ажлын албанд хүргүүлэн баталгаажуулж УБЗАА болон дүүргийн сайтад мэдээллийг байршуулаад байна.</p> <p>4. Зар сурталчилгааны тухай хууль зөрчин нийтийн эзэмшлийн зам, талбай, гэрлийн шон, зарлалын самбарууд дээр массажны үйлчилгээний талаарх зар, мэдээлэл ихээр гарч байгаа зөрчлийг таслан зогсоох зорилгоор дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран саун, массажны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй газруудад 2018 оны 04 дүгээр сарын 2-4-ны өдрийн хооронд “Эмзэг цэг-Хяналт шалгалт”, “Гулгаа массаж” хэсэгчилсэн арга хэмжээ явуулж, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Арга хэмжээний хүрээнд саун, массажны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Wellbeing spa, Топ саун массаж, “Увидаст мутар” массаж, бариа заслын сургалтын газар, “ Super b salon” массаж, Мэжиг спа массаж, Бест массаж зэрэг 9 газрыг хэсэгчлэн шалгахад ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй бөгөөд шалгалтын явцад машинт болон явган эргүүл, хэсгийн байцаагч, хорооны цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан, урамшуулалт эргүүлийн ажилтан нар гудамж талбай, гэрлийн шон, олон нийтийн газар байрлуулсан “Массаж”, “Гулгаа массаж” гэсэн нийт 79 зарын хулдаасан самбаруудыг буулгасан.</p> <p>Уг зарыг байрлуулж байгаа этгээдийг олж тогтоох зорилгоор 7 өөр утасны дугааруудыг Эрүүгийн цагдаагийн тасагт илтгэх хуудсаар өгч, шалгуулсан.</p> <p>5. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэстэй хамтран тусгай зөвшөөрөл шинээр авах болон улирлын түр зөвшөөрөл хүссэн 31 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийлээ. Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс 8 аж ахуйн нэгж стандарт шаардлага хангахгүй байсан бөгөөд холбогдох зөвлөгөө мэдээлэл өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>6. Сүхбаатар дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хүүхдийн зуслангийн бэлтгэл ажлыг хангуулах ажил”-ын хэсэгт орж ажиллалаа. Уг ажлын хүрээнд дүүргийн Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах 5 зуслангийн /Янзага, Хандгайт, Сэлбэ, Маргаашийн хөгжил, Хараацай зуслан/ бэлтгэл ажилтай танилцаж эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт шаардлага, хүүхдийн ая тухтай амрах орчин нөхцөл бүрдсэн эсэхэд хяналт тавьж, зөвлөгөө мэдээлэл өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ.</p> <p>7. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/06, А/84, А/164, А/297 дугаар захирамжуудаар Худалдааны газар, түүний үйлчилгээ MNS 5021-2007 стандартын шаардлага хангасан 15 газарт тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 30 цэгийн тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг сунгаж, худалдаа үйлчилгээний салбарт</p>
--	--	--

		<p>тавигдах үндсэн шаардлага, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт Тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй 243 газрын судалгааг шинэчлэн дүүргийн цахим мэдээллийн сайтад байрлуулсан. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудад Цагдаагийн байгууллагаас хяналт тавин ажиллаж байна.</p> <p>8. Барьцаалан зээлдүүлэх чиглэлээр үйлчилгээ эрхлэхээр хүсэлт ирүүлсэн 64 аж ахуй нэгжид Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ MNS 5274:2017 стандартын шаардлагыг ханган ажиллах талаар тухайн хороо хариуцсан хэсгийн байцаагч, цагдаагийн хамт мэргэжлийн заавар зөвлөгөө өгч Үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулан ажиллалаа.</p> <p>9. Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулгын үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа, холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд шалгалт хийх, хүчин чадал, чадавхийг тодорхойлох, зөвлөмж чиглэл өгөх, хүчин чадалгүй мэргэжлийн бус аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоох зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийнхэн 2018 оны 06 дугаар сарын 12-30-ны өдрүүдэд нийслэл хотод Оршуулгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 10 аж ахуйн нэгж байгууллага шалгалтад хамрагдлаа. Шалгалтаар ажлын байрны байдал, ажиллах хүн хүч, машин техникийн чадавхи, үйлчилгээний үнэ тарифыг хэрхэн бодитой тооцсон эсэх зэрэг асуудлуудаар шалгаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.</p> <p>10. Ахуйн үйлчилгээний салбарт саун массаж, үсчин, гоо заслын чиглэлээр үйлчилгээ эрхлэхээр хүсэлт ирүүлсэн Саран зүү, Гурван сондор ХХК-ийн Сондор, Ангария, Эрдэнэбулган, СПА-11, Z hair, K NAIL SENSATION, "Pinky", "Qween spa", Арома тера, Зууны манлай, UB зэрэг үсчин гоо сайхан, массажны газруудад Үс засах үйлчилгээ MNS 5160:2007, Саун, ерөнхий шаардлага MNS 5164:2002 стандартын шаардлага, Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журмын хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллах талаар мэргэжлийн заавар, зөвлөгөө өгсөн.</p> <p>11. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Арга хэмжээ авч ажиллах тухай 02-01/3365 тоот албан бичгийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх Авто засварын газруудад дүүргийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Авто засварын газруудад хяналт, шалгалт явуулах тухай А/303 дугаар захирамжийн дагуу 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 65 иргэн, аж ахуй нэгж байгууллагад авто үйлчилгээний салбарын хууль, дүрэм, журам, стандарт хангаж ажиллах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зохих шаардлага хангах үүрэг өгөөд байна. Мөн тус шалгалтын явцыг дүүргийн фэйсбүүк хуудас болон цахим хуудсаар мэдээлсэн.</p> <p>12. Дүүргийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Дүүргийн хөнгөн үйлдвэрлэлийн салбарт Улсын үзлэг зохион байгуулах тухай А/293 тоот захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтыг зохион байгуулаж 124 үйлдвэрлэл эрхлэгчид хамрагдсан. Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын орчин, ахуйн байрны эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангахгүй зэрэг нийтлэг зөрчил дутагдууд илэрч ажлын хэсэг хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, дүрэм журам, стандарт хангаж ажиллах чиглэлээр мэргэжил арга зүйг өгч холбогдох зардлыг шийдвэрлүүлэн ажиллалаа.</p>
--	--	--

			<p>13. “Үдийн цай” хөтөлбөр, Дэн буудлын хяналт шалгалтын ажил, Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйлчилгээ эрхлэгчдэд зохион байгуулсан 4 сургалт, Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулсан аттестатчиллын хяналт шалгалтын талаарх холбогдох мэдээллүүдийг дүүргийн сайт болон цахим хуудсанд цаг тухайд нь байршуулаж ажиллалаа.</p> <p>14. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс “Тамхины ишгүй байгууллага-Тамхигүй орчин” сэдэвт аяны хүрээнд гаргасан уриалгыг дүүргийн сайт, пэйж хуудас болон хороодын пэйж хуудсаар тараан баршуулж олон нийтэд хүргэсэн.</p> <p>15. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулж буй “Хүүхэд-Хэрэглэгч” аяны хүрээнд гаргасан видео брошурыг дүүргийн сайт, пэйж хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд хүртээсэн.</p> <p>16. Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн дагуу Худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудыг түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд шинээр гарсан хууль, дүрэм журмыг сурталчлан, гарын авлага материал бэлтгэн товхимол хэлбэрээр тарааж, худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материалын жагсаалт, төлбөр хураамжийн талаархи мэдээлэл зэрэг худалдаа, үйлчилгээний байгууллагуудтай холбоотой эрх зүйн болон бусад мэдээллүүдийг дүүргийн sbd.gov.mn цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулж, нийтэд ил тод түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд зохион байгуулагдсан нэгдсэн арга хэмжээ, сургалт, хяналт шалгалтын талаарх нийт 24 удаагийн мэдээллийг дүүргийн хэвлэл, мэдээллийн албатай хамтран олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан.</p>					
4.2 Татварын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, татвар хураалтыг эрчимжүүлнэ								
106	4.2.1	ДЗДҮАХ-ийн 4.2.1 Улс болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган татвар хураалтыг эрчимжүүлэн төлөвлөгөөг биелүүлж ажиллана.	Улс, нийслэл болон орон нутгийн төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлж, татвар хураалтыг эрчимжүүлэх төлөвлөгөөг ханган ажиллана.	Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг сар бүр жигд биелүүлнэ.	Төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна.	-	ТХ	100%
			<p>2018.11.19-ний байдлаар</p> <ul style="list-style-type: none"> Улсын төсөвт 167,237,500.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 152,517,625.5 мянган төгрөг буюу 91.2 хувийн гүйцэтгэлтэй, ХБГ-ээр 14,624,440,9 мянган төгрөг төвийлөрүүлэхээр ажиллаж байна. Нийслэлийн төсөвт 152,362,345.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 127,202,420.6 мянган төгрөг буюу 83.5 хувийн гүйцэтгэлтэй, ХБГ-ээр 25,159,925.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна. Орон нутгийн төсөв дээр 46,900,273.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 60,641,724.6 мянган төгрөг төвлөрүүлэн ажилласан. 					
107	4.2.2	ДЗДҮАХ-ийн 4.2.2 Татварын ерөнхий хууль, нэмэгдсэн өртгийн албан	Татварын баазад бүртгэлгүй үл хөдлөх хөрөнгийг бүртгэх,	Үл хөдлөх хөрөнгөтэй татвар	Үл хөдлөх хөрөнгийн татварын өрийг бүрэн барагдуулсан байна.	-	ТХ	100%

		татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хууль, Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль болон бусад татварын тухай хууль тогтоомжийг сурталчлан ажиллана.	хөрөнгөд дахин үнэлгээ хийлгэх асуудлыг шийдвэрлэх, бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг татварт бүрэн хамруулах, өрийг барагдуулах ажлыг зохион байгуулна.	төлөгчдийг бүрэн хамруулна.				
			<p>1.2018 онд 931 ААН-ийн 1740 ҮХЭХ, 957 иргэний 1070 ҮХЭХ нийт 1888 ААН, иргэний 2818 татвар төлөгчийн үл хөдлөх хөрөнгийн албан татварын ногдолыг Tax_act програмд оруулсан.</p> <p>2.ҮХЭХАТ төлөгчөөр 2018 оны 11 сарын 20-ны байдлаар шинээр 95 ААН, 116 иргэний үл хөдлөх эд хөрөнгийг Тахаст програмд бүртгэлээ.</p> <p>3. ҮХЭХАТ-ын үнэлгээ өөрчлүүлэх, хөрөнгө нэмэх, хасах тухай нийтдээ 75 албан хүсэлт ирснийг тухай бүр нь шийдвэрлэсэн.</p> <p>4. 2018.05.31-ны өдрийн А/30 тоот хэлтсийн даргын тушаалаар үл хөдлөх хөрөнгө өмчилдөггүй, бусдад шилжүүлсэн, ашиглах боломжгүй нураасан зэрэг шилтгаанаар 4 татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийг мөн хуулийн этгээдийн зохих лавлагаа, нотлох баримт, хүсэлтийг үндэслэн 18 татвар телегч нийт 22 татвар төлөгчийг ҮХЭХАТ төлөгчийн бүртгэлээс хассан.</p> <p>5. НТГ-ын 2018 оны 03 сарын 20-ны өдрийн 05/354 тоот албан бичгээр Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт ашиглалтанд орсон боловч татварын албанд бүртгэгдээгүй бизнесийн явуулж байгаа City tower-ийн объектыг үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгчөөр бүртгэх тухай албан тоот ирүүлсний дагуу барилгын эзэмшигчдийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 49 татвар төлөгчийг бүртгэн ногдлыг оруулсан ба хэт бага үнэлгээтэй татвар төлөгчийг хяналт шалгалтанд хамруулахаар дотоод зурвас хүргүүлэн ажилласан байна.</p> <p>6.ҮХЭХАТ төлөгчөөр бүртгүүлэхээр хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн үнэлгээний тайлан зах зээлийн үнээс хэт доогуур үнэлсэн Үнэлгээний компаниудын тайланг шалгуулахаар Сангийн яам руу 2 удаагийн албан тоот хүргүүлэн ажилласан.</p>					
108	4.2.3		Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Татвар төлөгчдийг нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем болон нийслэл хотын	Татварын тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	-	ТХ	100%

				албан татварт бүрэн хамруулна.			
			<p>Татварын ерөнхий газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн А/142 дугаар тушаал, дүүргийн татварын хэлтсийн даргын 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/48 дугаар тушаал “Ажлын дэд хэсэг байгуулах тухай” нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг, эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Маягтаар бүртгэсэн дүүрэгт бүртгэлтэй аж ахуй нэгж 302, иргэн 1086, зах худалдааны төв 34 • Бусад татварын албанд бүртгэлтэй аж ахуй нэгж 417, иргэн 225 • НӨАТУС төлбөрийн баримтыг хуулийн хугацаанд илгээдэг татвар төлөгч 1749 • НӨАТУС нэгдсэн системд холбогдоогүй 281 татвар төлөгчдийг 2018.09.20-ны өдрөөс 2018.10.31-ны өдрийн байдлаар тоолж бүртгэн, Нийслэлийн Татварын газарт 7 хоног бүр дээрх мэдээллийг хүснэгтийн дагуу хүргүүлэн ажилласан. • Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох буюу үндсэн үйлдвэрлэл үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн судалгааг гарган 287 татвар төлөгчийг НӨАТ суутган төлөгчөөр бүртгэсэн. • Дүүргийн татварын хэлтэстэй харилдаг 1358 аж ахуйн нэгж, 898 иргэн нийт 2256 татвар төлөгчийг цахим төлбөрийн системд шинээр бүртгэсэн. • Бараа, ажил, үйлчилгээ эрхлэгч хувь хүн, хуулийн этгээд нь цахим төлбөрийн систем буюу “ebarimt.mn”, посын гүйлгээгээр борлуулалтын гүйлгээгээ шивэхдээ алдаатай шивсэн, падаан давхардсан, дутуу татсан, чөлөөлөгдөх борлуулалт устгуулах гэх мэт алдааг засварлуулахаар 143 албан бичгийг хүлээн авч “Мэдээлэл технологийн төв”, “Улсын төсөвт үйлдвэрийн газар”-т майл хаягаар болон цаасан хэлбэрээр хүргүүлэн албан бичгийг шийдвэрлүүлсэн. • Стандартын шаардлага хангасан пос терминал машин хэрэглээгүй, цахим төлбөрийн системд холбогдоогүй болон холбогдсон хэдий ч төлбөрийн баримт тогтмол олгохгүй байгаа 441 татвар төлөгчид Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар 379,245,100 төгрөгийн шийтгэл ногдуулан ажиллаж байна. • Татварын ерөнхий газрын 1800-1288, Засгийн газрын 11-11 төвд ирсэн 308 гомдлын дагуу 279 гомдолыг шийдвэрлэн цахим төлбөрийн баримт олгохгүй байгаа бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн ажлын байранд очиж, татварын хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлийг арилгуулах, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, зөрчил давтан гаргаж байгаа татвар төлөгчдөд шаардлага өгөн, Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн дагуу 62 татвар төлөгчид 30,467,234 төгрөгийн шийтгэл ногдуулан ажиллаж талаар сануулга өгч ажилласан. • СБД-ийн татварын хэлстийн даргын 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 2018/02 тоот Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх, хяналт тавих ажлын нэгдсэн удирдамжаар 2018.03.19-ны өдрөөс 2018.05.19-ны өдрийг хүртэл Сүхбаатар дүүргийн 10, 11, 12-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгч хувь хүн, аж ахуйн нэгжийн үйл 				

		<p>ажиллагаанд хяналт тавин ажилласан. Мөн 5 дугаар хороонд байрлах “Дэм” худалдааны төвийн татвар төлөгч иргэдэд төлбөрийн баримт тогтмол өгөх талаар сургалт зохион байгуулсан.</p> <p>Нийслэлийн татварын газарт Зах худалдааны төвийн 7 хоног тутмын мэдээ, 14 хоног тутмын судалгааг хүргүүлэн ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт “Шөнийн гудамж” төслийн хүрээнд 7 хоног бүрийн баасан, бямба, ням гаригуудад зохион байгуулагддаг үйл ажиллагаанд худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа татвар төлөгчдийг төлбөрийн баримт тогтмол өгүүлэх талаар ажиллах жижүүрийн хуваарийг гарган мөрдүүлж мэдээ, тайланг Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p>					
109	4.2.4	<p>Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, авто зам ашигласны төлбөрийг холбогдох газруудтай хамтран төвлөрүүлэн ажиллана.</p>	<p>Авто тээврийн болон өөрөө явагч хэрэглэлийн албан татварыг хураах салбар цэгүүдийг ажиллуулж, төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна.</p>	<p>Татварт бүрэн хамруулсан байна.</p>	-	ТХ	100%
		<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны даргын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураалтын хяналтын үзлэг шалгалтын удирдамжийн дагуу дүүргийн замын цагдаагийн хэлтэстэй хамтран АТБӨЯХАТ-ыг хугацаандаа төлөөгүй тээврийн хэрэгслийн гэрчилгээг 2018.05.16-наас эхлэн хурааж эхэлсэн. Түүнчлэн 2018.11.20-ны байдлаар татвар төлөөгүй 282 тээврийн хэрэгслийн гэрчилгээг хураан авч татварыг төлүүлэн ажилласан.</p> <p>Авто тээврийн үндэсний төвөөс ирүүлсэн хасагдах тээврийн хэрэгслийн судалгааны дагуу иргэдээс өргөдлийг хүлээн авч жагсаалтыг гарган Авто тээврийн үндэсний төвийн Тээврийн бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Үүнээс 2018.11.20-ний өдрийн байдлаар 226 иргэний нийт 258 хасагдах тээврийн хэрэгслийн өргөдлийг хүлээж авсан.</p> <p>2018 оны 11.20-ны байдлаар</p> <ul style="list-style-type: none"> • АТБӨЯХАТ-ийн төлөвлөгөө 4,297,102.30 мянган төгрөг гүйцэтгэл 4,478,598.83 мянган төгрөг • АЗАТөлбөр-ийн төлөвлөгөө 1,882,767.40 гүйцэтгэл 1,703,443.30 мянган төгрөг • АБТөлбөр-ийн төлөвлөгөө 170,602.9 мянган төгрөг 					

			Гүйцэтгэл 225,976.2 мянган төгрөг					
			Smartcar.mn цахим үйлчилгээний системийн мэдээллийг Сүхбаатар дүүргийн татварын хэлтэсийн цахим хуудаснаа байршуулан иргэд болон аж ахуй нэгжүүдэд сурталчилан мөн сурталчилгааны материал тараан ажилласан.					
110	4.2.5		Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд хог хаягдлын хураамжийг барагдуулах ажлыг зохион байгуулна.	Хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэх боломжийг ашиглан, төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ.	Иргэн, хуулийн этгээдийг татварт бүрэн хамруулсан байна.	-	ТХ	100%
			Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 29А/351 тоот захирамжийн дагуу ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зөрчилтэй ААНБ, иргэдэд удаа дараагийн арга хэмжээ авсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> Татварын мэдэгдэх хуудас гардуулсан, Мэргэжлийн хяналтын хэлтсийн албан шаардлага хүргүүлсэн, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн албан бичиг хүргүүлсэн, авсан боловч хог хаягдлын үйлчилгээний гэрээ байгуулаагүй, хог хаягдлын үйлчилгээний хураамж төлдөггүй ААНБ, иргэдийн судалгааг төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. 2018 оны төлөвлөгөөг сар сараар гаргаж, хог хаягдлын үйлчилгээний 4 аж ахуй нэгжид хүргүүлсэн. Урьд оны 14,734,000 төгрөгний өрнөөс 11,850,000 сая төгрөгний төлөлт барагдуулж, шинээр 26 ААН Байгууллагатай гэрээ хийсэн. Хог хаягдлын хураамж 11 сарын 15-ны байдлаар дүүргийн төсөвт 1,796,924,000 төгрөгийн орлого орохоос 1,748,202,640 төгрөгний орлого төвлөрүүлсэн ба хүлээгдэж буй гүйцэтгэл 2,020,278,64 төгрөг ба жилийн төлөвлөгөө 54,278,64 төгрөгөөр даван биелэхээр байна.					
4.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.								
111	4.3.1	НЗДҮАХ-ийн 4.2.16 дахь заалт ДЗДҮАХ-ийн 4.3.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах арга	Дотоод, гадаадын хамтын ажиллагаатай улс, орон, дүүрэгт ЭМТ, ЭЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулах, туршлага судлуулна.	Жилд 5-аас доошгүй эмч, мэргэжилтнийг хамруулна.	ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.	-	НХХ, ЭМТ	100%
			-7, 8, 9, 10 дугаар хорооны ӨЭМТ-ийн дарга нар БНСАУ-ын Пусан хотод айлчилж, улсын эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн үйлчилгээ, үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан. Янсаны их сургуулийн эмнэлгээс эмч нар ирж, тус хороодын иргэдэд үзлэг, шинжилгээ хийн, хамтран ажиллах гэрээ байгууллаа.					

		хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.	<p>-ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүд Дархан-уул аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төв, Гос хот ӨЭМТ-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлуулах үйл ажиллагаа зохион байгуулсан.</p> <p>-БНСУ-д зохион байгуулагдсан WONCA 2018 Дэлхийн өрхийн эмч нарын чуулга уулзалтанд 16 ӨЭМТ-ийн дарга, эмч оролцож, “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг өргөжүүлэх нь” төслийн хүрээнд “Сүхбаатар дүүргийн 20-р хорооны 40-65 насны хүн амын дундах халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн судалгааны үр дүн” сэдвээр “Гэрэлт Манал” ӨЭМТ-ийн эмч илтгэл хэлэлцүүлсэн.</p> <p>-Япон улсын Жайка байгууллагын “Өвсний үндэс” техникийн хамтын ажиллагааны Орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж буй “Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлэхэд сувилагчийн хүний нөөцийг хөгжүүлэх” төслийн хүрээнд 1 их эмч, 3 сувилагчийг Япон улсад 14 хоногийн богино хугацааны сургалтад хамруулсан.</p>					
112	4.3.2		Нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох судалгааны ажлыг эрчимжүүлж, онол, практикийн бага хурал зохион байгуулна.	Хамтран ажиллах байгууллага, судалгааны ажлын тоо, чанар нэмэгдэнэ.	Хурал зохион байгуулсан байна.	-	НХХ, ЭМТ	70%
			<p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/100 дугаар захирамжийн дагуу “Эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэл 2018” Онол практикийн бага хурал зохион байгуулж, ЭМТ, ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүд эмнэлзүй, нийгмийн эрүүл мэнд, сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр аман болон ханан 19 илтгэл хэлэлцүүлж, эхний 4 байр шалгаруулан, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. “Эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэл 2018” Онол практикийн бага хурлын илтгэлийн бүтээлээр хураангуй ном хэвлүүлэн, эмч, мэргэжилтнүүдэд гарын авлага болгон гардуулсан.</p>					
113	4.3.3		Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шилэн кабельд холбож, E Health программыг бүрэн нэвтрүүлнэ.	Эмнэлгийн мэдээллийн технологийн хэвийн үйл ажиллагаа хангагдана.	1, 2, 6, 7, 8, 14 дүгээр хороодын ӨЭМТ шилэн кабельд холбогдсон байна.	-	НХХ, ЭМТ	100%
			<p>-“Цахим эрүүл мэнд” төслийг эрчимжүүлэх ажлын хүрээнд 1-20 дугаар хорооны ӨЭМТ-дэд хяналт үнэлгээ хийн, 11,13,14,15 дугаар хорооны ӨЭМТ-дэд утсан сүлжээ татах, 11-20 дугаар хорооны ӨЭМТ-дэд хүчин чадал сайтай 18 компьютер шинээр авах, вирусын программ ашиглах талаар зөвлөмж өгч ажиллалаа.</p> <p>-1-18 дугаар хорооны ӨЭМТ-ийг ehealth програмд бүрэн холбож, ажлын байрны сургалт зохион байгуулж, 7 удаагийн дэмжлэгт хяналт хийж, НЭМГ, ЭМТ-өөс ӨЭМТ-ийн статистик хариуцсан 18 мэргэжилтэнд нэгдсэн програм болон програм хангамжинд гарч буй алдаатай шивэлт болон анхаарах зүйлсийн талаар 2 удаагийн сургалт зохион байгуулсаны үр дүнд ehealth програм ашиглалт 3-р улиралд 74,5%-тай болж, 5,8%-иар өсч, сарын мэдээнд өгсөн үзлэгийн мэдээ болон програм хангамжийн үзлэгийн мэдээний зөрүү буурсан.</p>					

			-Анхан шатны бүртгэл хөтлөлт 82,3%, цахим жор, Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөрийн програм ашиглалт 96%-тай байна. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 тоот тушаалын дагуу артерийн гипертенз, чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн бүртгэл, жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын бүртгэл, диспансерийн хяналтын бүртгэлийн маягтууд зэрэг эмчийн үзлэгийн бүртгэлийн 1А, 1Б маягт, оношилгоо шинжилгээний бүртгэлийн маягтуудыг e-health програмд оруулан ашиглаж хэвшсэн.					
114	4.3.4		Эмийн жор бичилтийн стандарт, антибиотикын зохистой хэрэглээнд хяналт үнэлгээ хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Эмийн зохистой хэрэглээ төлөвшиж, жор бичилтийн стандартын хэрэгжилтийн хувийг өмнөх оноос ахиулсан байна.	-	НХХ, ЭМТ	100%
			<p>-ӨЭМТ-дийн эмийн хадгалалт, зарцуулалт, анхан шатны маягт хөтлөлт, эмийн жор бичилтийг үнэлгээний хуудсаар үнэлж, 9 ӨЭМТ-д зургаан чиглэлээр зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллалаа.</p> <p>-ЭМС-ын 415 дугаар “Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн, мэдээлэх журам”, ЭМС-ын 68 дугаар “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” тушаалын дагуу хяналтын хуудсаар 20 эмийн жорыг түүвэрлэн үнэлгээ хийж, мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жорын маягтад эм олгосон огноо бичээгүй 3/15%, гарын үсгийг тэмдэглээгүй 1/5% зөрчлийг арилгуулав.</p> <p>-2018 оны 7 дугаар сард “Жор бичилт, жорын маягтын стандарт” сэдвээр 33 нарийн мэргэжлийн эмч нараас авч дүгнэхэд дундаж үнэлгээ 80.6%-тай байгаа нь 2017 оноос 15.6%-иар ахисан.</p> <p>ЭМТ-ийн даргын 2017 оны 92 тоот тушаалын хавсралтаар баталсаны дагуу хөнгөлөлттэй эмийн жорыг нарийн мэргэжлийн 15 эмч бичиж байна. 2018 оны 08 дугаар сарын 28-ны байдлаар дээрхи хөнгөлөлттэй эмийн жор бичих эрхтэй эмч нар нийт 741 цахим жор бичснээс 203/27% жор хүчингүй /тухайн иргэн жорын хүчинтэй хугацаанд эмийн санд очоогүй, тухайн эм нь жоронд бичсэн нэршлээрээ эмийн санд байгаагүй тохиолдлууд/, 524/71% жороор нь эм олгогдсон байна.</p>					
115	4.3.5	НЗДҮАХ-ийн 4.2.15 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.3.3 Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцон ажиллана.	Өрхийн эрүүл мэндийн төвийн 3 талт гэрээг шинэчлэн байгуулж, хагас, бүтэн жилээр үр дүнг тооцно.	Өрхийн эрүүл мэндийн төвийн 3 талт гэрээний хэрэгжилт сайжирна.	Өрхийн эрүүл мэндийн төвийн 3 талт гэрээний дундаж 85%-д хүрсэн байна.	-	НХХ, ЭМТ	100%
			<p>-Дүүргийн Засаг даргын 2018.01.24-ний өдрийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 3 талт гэрээний 2017 оны гүйцэтгэлээр шагнаж урамшуулах тухай А/10 дугаар захирамжийн дагуу А буюу Бүрэн хангалттай дүгнэгдсэн 2,3,7,9,10,11,13,14,16,17 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн хамт олныг Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. 2017 оны жилийн үнэлгээний дундаж ӨЭМТ 98,1%, ЗДТГ 80,9%, ЭМТ 95,4% байна.</p> <p>-Нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/83 дугаар захирамж, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын А/08 дугаар тушаалын дагуу 2017 оны гэрээний гүйцэтгэлээр Бүрэн</p>					

			<p>хангалттай 10, Хангалттай үнэлэгдсэн 8 ӨЭМТ-тэй 2018 онд хамтран ажиллах 3 талт гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай” А/68 дугаар захирамжаар батлагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн гэрээний гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу 2018 оны эхний хагас жилийн гэрээг дүгнэхэд, Бүрэн хангалттай буюу А үнэлгээтэй 10, Хангалттай буюу В үнэлгээтэй 6, С үнэлгээтэй дүгнэгдсэн буюу ажил сайжруулах 2 ӨЭМТ байна. Дүүргийн Засаг даргын гүйцэтгэлийн гэрээний үнэлгээ 90,8%, Эрүүл мэндийн төв 94,8% дүгнэгдсэн. Өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээний биелэлтийн дундаж 89,2 % буюу өмнө оны мөн үеэс 1,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэрээний жилийн эцсийн гүйцэтгэлийг 12 дугаар сард дүгнэнэ.</p>					
4.4 Иргэн бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэнэ								
116	4.4.1	<p>НЗДҮАХ-ийн 4.2.1 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.4.1 Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлж иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа хамруулж эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллана.</p>	<p>“Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй халдварт бус өвчнийг бууруулах” дүүргийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, эрт илрүүлгийн хувийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Эрт илрүүлгийн дундаж хувийг 60%-д хүргэнэ.</p>	<p>ХБӨ-ний эрт илрүүлгийн хамрагдалт сайжирч, шинээр оношлогдсон ХБӨ-тэй үйлчлүүлэгч хяналтад оруулах ПАП-ийн хамралтыг 43%, АГ, ЧШ-ийн эрт илрүүлгийг 50%-аас доошгүй хамруулсан байна.</p>	-	НХХ, ЭМТ	100%
			<p>-МУЗГ-ын 2017-09-27-ны 289 дүгээр тогтоолын дагуу “Халдварт бус өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 29 заалттай төлөвлөгөө гарган, биелэлт 90,25% байна.</p> <p>-Артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 35418 хүнээс 18157 буюу 51,3% хамрагдаж, өмнө оны мөн үеэс 2,9%-иар, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 35418 хүнээс 18063 буюу 51% хамрагдаж, өмнө оны мөн үеэс 3,6% тус тус өссөн. Эрт илрүүлэг үзлэгийн үр дүнд артерийн гипертензи өвчний 237 тохиолдол, чихрийн шижингийн 2-р хэв шинжтэй 88 тохиолдлыг шинээр оношилж, эмчийн хяналтад авсан.</p> <p>-Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 5930 хамрагдахаас 2312 буюу 38,99% хамрагдсан нь өмнө оны мөн үеэс 8,5%-иар буурсан. Эсийн шинжилгээний өөрчлөлттэй 64 тохиолдол илрүүлэн 54 тохиолдлыг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт шилжүүлж, умайн хүзүүний хавдар 1, хөхний хавдар 1 тус тус оношлогдсон.</p> <p>-Дүүргийн Засаг даргын А/326 дугаар захирамжаар 9,410,000 төгрөг шийдвэрлэж, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эрт илрүүлэг үзлэг зохион байгуулахад шаардагдах бэлгийн замаар дамжих халдвар, сахар, холестрин илрүүлэх оношлуур олгосон.</p>					
117	4.4.2		<p>ӨЭМТ-ийн халдварт бус өвчний эрт илрүүлгийг тогтмолжуулахад сувилагч, сайн дурын</p>	<p>10%-иар ахиулна.</p>	<p>Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хувийг ахиулсан байна.</p>	-	НХХ, ЭМТ	100%

			идэвхтний оролцоог нэмэгдүүлнэ.						
			<p>-Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлэхэд сувилагчийн хүний нөөцийг хөгжүүлэх төслийн хүрээнд 1 их эмч, 3 сувилагчийг Япон улсад 14 хоногийн богино хугацааны сургалтанд хамруулсан.</p> <p>-“Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлэхэд сувилагчийн оролцоо” 8 удаагийн багийн сургалтад ЭМТ, ӨЭМТ-ийн 105 сувилагчийг сургасан. Төслийн хүрээнд сувилахуйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 40 ширхэг артерийн даралт хэмжих бугуйн электрон аппарат, алхам хэмжигч, 10 ширхэг захын цусан дахь хүчилтөрөгч хэмжигч нийлүүлэгдсэн.</p> <p>-ЭМТ-ийн дотор, зүрх судасны 3 эмчийг сургагч багшаар бэлтгэн, "Эрүүл зүрх-Эрүүл Улаанбаатар" төслийн хүрээнд ӨЭМТ-дийн эмч, сувилагч нарыг 3 шатны чадавхижуулах сургалтанд 100%, 15 сайн дурын туслагчийг "Цусны даралт ихсэх өвчний оношилгоо, эмчилгээ, хяналтыг сайжруулах нь" сэдэвт сургалтад хамруулж, ӨЭМТ-ийг 102 ширхэг цусны даралт хэмжих багажаар хангасан.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/244 дүгээр захирамжийн дагуу “Эрүүл иргэн” аян зарлаж, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа явуулж, зөвлөгөө мэдээлэл өгч, нийт 20 хорооны 4419 иргэн хамрууллаа.</p>						
118	4.4.3	НЗДҮАХ-ийн 4.2.2 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.4.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт, эрүүлжүүлэлтийн хувийг нэмэгдүүлэх, эрүүл зан үйлд сургана.	Урьдчилан сэргийлэх үзлэг 70%, эрүүлжүүлэлтийг 30%-д хүргэнэ.	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт, эрүүлжүүлэлтийн хувь нэмэгдсэн байна.	-	НХХ, ЭМТ	100%	
			<p>-2018 онд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжилтэд дүүргийн харъяа төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 9855, ерөнхий боловсролын 17 сургуулийн 1-5 дугаар ангийн 14579 сурагчдыг хамруулахаас 2018 оны 11 сарын байдлаар сургууль 13495 буюу 92,56%, цэцэрлэг 8873 буюу 90,04%, нэгдсэн дүнгээр хамрагдвал зохих 24434 хүүхдээс хамрагдсан 22368 буюу 91,5% байна. Нийт хүүхдийн 90% нь шүд цоорох өвчтэй эрүүлжсэн хүүхэд 7168 буюу 32,04 % байна.</p> <p>Сургуулийн 1-5 дугаар ангийн үзлэгт хамрагдсан 13495 хүүхдээс 4295 эрүүлжсэн. Цэцэрлэгийн үзлэгт хамрагдсан 8873 хүүхдээс 2873 хүүхэд буюу 34,7% байна.</p> <p>Үүнээс 2018 онд зорилтот 3 цэцэрлэг, 3 сургуулийг сонгон дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэстэй хамтран "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, хамгаалъя" сэдэвт нөлөөллийн уулзалт зохион байгуулж, 160, 109, 135 цэцэрлэгийн эрхлэгч, эмч, багш, эцэг, эхийн төлөөлөл, ЕБС-ийн 2, 6, 58 дугаар сургуулийн захирал, эмч, 1-5-р ангийн багш, сургалтын менежер, эцэг эхийн төлөөлөл бүхий 43 хүн оролцсон. Сургалтын үр дүнд 160,109,135 дугаар цэцэрлэгийн амны хөндийн үзлэгт хамрагдвал зохих 1578 хүүхдээс 1299 буюу 82.3% -ийг хамруулж, 885 буюу 68.2%-д нь өвчлөл илэрсний 285 буюу 33.3%-ийг эрүүлжүүлсэн.</p>						

			<p>ЕБС-ийн 2,6,58 дугаар сургуулийн 1-5 ангийн үзлэгт хамрагдвал зохих 4459 хүүхдээс 3833 буюу 85.9-ийг хамруулсны 3544 хүүхдэд буюу 92.4%-д нь өвчлөл илэрсний 32.4%-ийг эрүүлжүүлсэн.</p> <p>"Амны хөндийн эрүүл мэнд-шүдэнд ээлтэй хоол хүнс" сургалтын хөтөлбөрийг 58-р бага сургууль, 175 дугаар цэцэрлэгт туршихаар сонгож, 175-р цэцэрлэгийн 126 хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 50 эцэг, эхэд сургалт зохион байгуулсан. Мөн Амны хөндийн эрүүл мэндийн сургалтыг 166, 217, 225, 36, 248,150-р цэцэрлэгийн хүүхдийн 700 эцэг эх, багш ажилчдад зохион байгуулсан.</p> <p>-Нийслэлийн Эрүүл мэндийн газар, нийслэлийн Боловсролын газартай хамтран зохион байгуулсан "Амны хөндийн эрүүл мэнд" сургалтанд 58-р бага сургуулийн 1-5 дугаар ангийн багш нарыг 100% хамруулж, урьдчилан сэргийлэх үзлэгт 1192 хүүхдийг хамруулан сургалтын хөтөлбөрийг турших бэлтгэл хангагдсан. 2018 онд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар :</p> <ul style="list-style-type: none"> • Шүдний бор машин 10,680,000 төгрөг • Сувгийн эмчилгээний аппарат /ком/ 9,195,000 төгрөг, ЭМТ-ийн төсвөөс шүдний үзлэг, эмчилгээний багаж, хэрэгсэл /328 ширхэг/ 4,050,000 төгрөгөөр худалдан авч эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. 					
119	4.4.4	<p>НЗДҮАХ-ийн 4.2.3 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.4.3 Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, эмчилгээний хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ.</p>	Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийн хувийг өмнөх оноос нэмэгдүүлнэ.	Идэвхтэй эрт илрүүлэг үзлэгийн хувийг 5%-иар ахиулсан байна.	Өмнөх оноос ахисан байна.	-	НХХ, ЭМТ	100%
			<p>-2018 онд Үйлдвэрлэл урлалын политехникийн коллежийн багш, ажилчид оюутнууд, ШУТИС, ХУИС, МУИС-ийн 1,2,3,4,5 дугаар дотуур байрны оюутнууд, 25,4-р сургуулийн сурагчид, 16,18-р хорооны эрсдэлт бүлгийн хүн амд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг үзлэг зохион байгуулж, 4548 хүн хамруулснаар эмэнд мэдрэг сүрьеэгийн 12 тохиолдол, эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 2 тохиолдол илрүүлж, эмчилгээнд бүрэн хамруулсан. Идэвхтэй илрүүлэг 35,3% буюу өмнөх оны мөн үеэс 19,4%-иар өссөн.</p> <p>Дүүргийн ЕБС-ийн 933 багш ажилчдыг ЭМСайдын 2017 оны А/145 дугаар тушаалын дагуу сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эмэнд мэдрэг сүрьеэ 3, эмэнд тэсвэртэй сүрьеэ 1 тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулсан.</p> <p>-Нийслэлийн Засаг даргын А/339, дүүргийн Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн "Сүрьеэгүй дүүрэг" аян зохион байгуулах тухай А/174 тоот захирамжийн дагуу 1-20 хорооны ЗДАА, ӨЭМТ-дийн дунд болзолт уралдаан зохион байгуулж, үйл ажиллагааны зардал, ЭМТ-ийн сүрьеэгийн диспансерийн агааржуулалтын системийн шүүлтүүр солих, халдвар хамгааллыг сайжруулах, эрт илрүүлэг үзлэг хийхэд шаардагдах 5,656,000 төгрөгийг шийдвэрлэсэн. "Сүрьеэгүй дүүрэг" аяны хүрээнд хийсэн үйл ажиллагаа, хамтран ажиллах удирдамж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлсээр ЗДАА, ӨЭМТ-ийг төвүүд дүгнэхэд:</p> <p>I байрт 18 дугаар хорооны ЗДАА, Гэрэлт манал ӨЭМТ II байрт 16 дугаар хорооны ЗДАА, Мандам ӨЭМТ III байрт 15 дугаар хорооны ЗДАА, Гүн мэдрэмж ӨЭМТ Тусгай байрт 17 дугаар хорооны ЗДАА, Увидаст од ӨЭМТ тус тус шалгарч, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.</p>					

120	4.4.5	НЗДҮАХ-ийн 4.2.4 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.4.4 ХДХВ, БЗДХ-ыг бууруулах, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, ажиллана. /Хорооны Засаг даргын үр дүнгийн гэрээнд Сүрьеэ, ХДХВ/БЗДХ-ыг бууруулах, Халдварт бус өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх, Жирэмсний хяналтыг сайжруулах, Хүүхдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, Дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх, өрхийн эрүүл мэндийн төвийг дэмжиж ажиллах арга хэмжээг тусгайлан тусгаж, үр дүнг тооцох/	ХДХВ, БЗДХ-ыг бууруулах дүүргийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, ХДХВ, БЗДХ-ыг бууруулах, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг 5%-иар нэмэгдүүлнэ.	Эрт илрүүлгийн хувийг өмнө оноос бууруулахгүй.	ХДХВ, БЗДХ-ын эрт илрүүлгийн хувь нэмэгдсэн байна.	-	НХХ, ЭМТ	100%
			-Дүүргийн Засаг даргын 2018.03.09-ний өдрийн А/60 дугаар захирамжаар Сүрьеэ, Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах тухай Эрүүл залуус аяны нээлтийг Үйлдвэр урлалын политехникийн коллеж дээр зохион байгууллаа. Үйлдвэрлэл урлалын политехникийн коллежийн багш, ажилтан, оюутнуудад, ШУТИС, МУИС-1,2,3,4,5 дугаар дотуур байр, 25,4-р сургуулийн нийт 1924 оюутан, сурагч сүрьеэгийн идэвхтэй илрүүлэгт хамрагдаж, сүрьеэгийн тохиолдол 7, тэмбүүгийн 8 тохиолдол ирүүлж, эмчилгээнд хамруулсан. Идэвхтэй илрүүлэг 30,7% -БЗДХ-ын урьдчилан сэргийлэх үзлэгт 17470 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 12.4%-иар өссөн. Идэвхитэй эрт илрүүлэгт 4748 хүнийг хамруулж, тэмбүү өвчтэй 32 тохиолдол, ДОХ-ын 1 тохиолдол илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Идэвхитэй эрт илрүүлэг өмнөх оны мөн үеэс 17.6%-иар өссөн. -Гэр оронгүй тэнэмэл иргэдийг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 70 иргэн эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамрагдаж, БЗДХ-тай 10 иргэнийг оношилж, эмчилгээнд хамруулсан. - Дүүргийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/325 дугаар захирамжийн дагуу залуучуудын дундах бэлгийн замаар дамжих халдварт өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж, “Залуучуудын дундах БЗДХ, ХДХВ-ийн тархалтыг бууруулахад бидний оролцоо” сэдэвт нөлөөллийн уулзалт зохион байгуулж, МУИС, ШУТИС, МУБИС, ҮБТДС, “Түшээ” ДС, “Глобал удирдагч” дээд сургууль, Үйлдвэр урлалын политехникийн коллежийн эмч, мэргэжилтэн, оюутан залуус, нийт 77 хүн оролцон, уулзалт хэлэлцүүлгээс ЗӨВЛӨМЖ боловсруулан, гаргалаа. 16,25,31 дүгээр сургуулийн Х ангийн нийт 53 сурагчийг нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ, ДОХ-ын чиглэлээр сурган, сургагч багшаар бэлтгэв. Захирамжийн хүрээнд 2,495,100 төгрөг шийдвэрлэн, БЗДХ-ын урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, 13-р хороо, 6 их, дээд сургуулийн 2942 оюутан, иргэнийг хамруулж, тэмбүүгийн 12, сүрьеэ 6 тохиолдол илрүүлж, эмчилгээнд бүрэн хамруулсан .					
121	4.4.6		Жирэмсний эрт хяналтыг сайжруулах салбар дундын уулзалт зохион байгуулна.	Жирэмсний эрт хяналтын түвшнийг 80%-д хүргэнэ.	Эрт хяналтын хувь нэмэгдсэн байна.	-	НХХ, ЭМТ	100%
			-Эрүүл мэндийн сайдын 338 дугаар тушаалын дагуу жирэмсний хяналтад 3444 жирэмсэн эмэгтэйг хяналтын үзлэгт хамруулахад 1689 /76,6%/ нь өндөр эрсдэлтэй, 37,9% нь эрхтэн тогтолцооны эмгэгтэй, 50,2% нь бөөр шээсний замын эмгэгтэй, 13,7%-д цус багадалт илрүүлж, эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд 2204 /63,9%/, харьяа ӨЭМТ-ийн хяналтад 1240 /36.1%/ жирэмсэн эх хянагдаж байна.					

			<p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны А/59 дүгээр захирамжийн дагуу “Жирэмсэний эрт хяналтыг сайжруулъя” сэдвээр хороодын Засаг дарга, ӨЭМТ-ийн дарга, холбогдох мэргэжилтнүүдийн дунд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт 52 хүн оролцож, тулгамдсан асуудлын талаар харилцан санал солилцож, цаашид хамтран ажиллах үйл ажиллагааны зөвлөмж гарган ажилласан. Жирэмсний эрт хяналтын хувь 85,1 буюу өмнө оны мөн үеэс 6 %-иар өсч, хороо, ӨЭМТ-ийн уялдаа холбоо сайжирч, төрөх насны эмэгтэйчүүдийн судалгааг тулган шинэчилсэн.</p> <p>-Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр “Гэр үнэлгээний арга зүй”-г нэвтрүүлж, 180 ш үзүүлэн хэвлүүлж, арга зүйг танилцуулах сургалтанд ӨЭМТ-ийн 140 эмч, нийгмийн ажилтан, сайн дурын туслагч хамруулж, 1850 жирэмсэн эмэгтэйг гэр үнэлгээнд хамруулж, сургалт, зөвлөгөө зохион байгуулсаны үр дүнд эхийн эндэгдэл гараагүй, амьгүй төрөлт 12 буюу өмнө оны мөн үеэс 2, гэрийн төрөлт 10 буюу 1, хяналтгүй төрөлт 13 буюу 1 тохиолдлоор тус тус буурсан үр дүн гарсан.</p>					
122	4.4.7	<p>НЗДҮАХ-ийн 4.2.5 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.4.5 Халдварт өвчин, амьсгалын замаар дамжих халдварт өвчний дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, өвчлөлийг бууруулна.</p>	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Амьсгалын замын цочмог халдварын хүндрэл, эндэгдэл буурсан байна.	-	НХХ, ЭМТ	100%
			<p>-ЭМС-ын 346 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын А/577 дугаар захирамж, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 86 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/58 дугаар захирамж, ЭМТ-ийн даргын А/61, А/52 тоот тушаалуудаар ТТТӨ-өөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдлээс сэргийлэх, идэвхжил, дэгдэлтийн үед уртасгасан цагийн хуваариар хүүхдийн кабинет, “Зөвлөгөө өгөх утас” ажиллуулах түр журам, дэмжлэгт хяналтын багуудыг шинэчлэн тодотгож эмч, мэргэжилтнүүдийг холбогдох эрхзүй, стандарт удирдамжаар ханган ажилласнаар 2018 онд амьсгалын замын халдварт өвчин 1218 тохиолдол буюу 10.000 хүн амд 88.8 байгаа нь өмнө оны мөн үеэс бодит тоогоор 576 буюу 10.000 хүн амд 42.0 –оор буурсан. Амьсгалын замын цочмог халдварт өвчнөөр эндэгдэл гараагүй, уушгины хатгалгаагаар 2018 онд 2 эндэгдэл бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 0.8 промил буюу өмнө оны мөн үеэс 0,5-иар буурсан.</p> <p>Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> • ТТТӨ-өөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цэгэн массажын ач холбогдол”, “ТТТӨ-өөс сэргийлье”, “Агаарын бохирдол”, “Гарын ариун цэвэр”, “Эмийн зохитой хэрэглээ” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, 11 сургуулийн 2117, 32 цэцэрлэгийн 1969 хүүхэд, 23 ААН байгууллагын 323 ажилтан албан хаагч, ЭМТ, ӨЭМТ-өөр үйлчлүүлсэн 20339 хүн нийт 24748 мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамруулсан. Дүүргийн харьяа сургууль, цэцэрлэг, өрхийн эмч нарт 4 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 149 эмч, сувилагч хамрагдсан. • Халдварт өвчний чиглэлээр “Монголын мэдээ” сонин, News.mn, Newsmedia.mn, SKY телевиз, Рояль ТВ зэрэг телевиз, радиод 12 удаагийн нэвтүүлэгт оролцож зөвлөгөө, мэдээлэл өгч иргэдийг мэдээлэл сурталчилгаанд хамруулсан. • Олон нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдээллийг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор 41 төрлийн зөвлөгөө, зөвлөмж ДЗДТГ, ЭМТ, ӨЭМТ, Хороо, Иргэний танхимуудын цахим хуудас, зурагт самбаруудад байршуулсан. 					

		<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийг дэмжих сангийн 8 сая төгрөгний санхүүжилтээр ТТТӨ-ний үеийн сургалт, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлж, ТТӨ, агаарын бохирдол, эмийн зохистой хэрэглээ сэдвээр интерактив сургалтын гарын авлага боловсруулж, Монгол HD телевизтэй гэрээ хийж, 1 сарын турш ТТТӨ, агаарын бохирдлоос сэргийлэх сурталчилгааг 27 удаа явуулж, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлсэн. • ТТТӨ-өөр өвчлөх эрсдэл бүхий эмзэг бүлгийн өрхийн хүүхэд, өндөр настан, суурь өвчлөлтэй, томуугаар хүндэрч болзошгүй хүүхдийн судалгаа гарган томуугийн дархлаажуулалтад хамруулсан. 2018 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар нийт хамрагдалт 94,2%. Үүнээс: Эмч, эмнэлгийн ажиллагсад 99,8%, эрсдэлт бүлгийн хүн ам 100%, цэцэрлэгийн насны хүүхдүүд (2-5 нас) 83%-ийг дархлаажуулсан. • СБЭМТ-ийн тасаг, клиникүүд 7 хоног бүр ажиллагсадын дархлаа дэмжих, витаминжуулах ажлыг 5 удаа зохион байгуулж нийт ажилчдыг бүрэн хамруулсан. • Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газраас 1-20 дугаар хорооны ӨЭМТ-үүдэд 20, дүүргийн ЗДТГ-ын төсвөөс сургууль, цэцэрлэг, хэлтэс, хороод 104 ширхэг агаар цэвэршүүлэгч нийлүүлсэн. • Дүүргийн Засаг даргын А/58 дугаар захирамжийн дагуу “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах” ажлын хүрээнд сургууль, цэцэрлэгийн эмч, 1-20 дугаар хорооны ӨЭМТ-д 6,5 сая төгрөгийн өртөгтэй автомат гар ариутгагч, пульсоксиметр нийлүүлсэн. • ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 6,4 сая төгрөгний хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, утлагын аппаратыг ЭМТ-ийн салбарууд, ӨЭМТ-үүдэд хуваарилан үйл ажиллагаанд ашиглаж байна. • ТТТӨ-өөс урьдчилан сэргийлэх, идэвхижил дэгдэлтийн үед бэлэн байдлыг ханган ажиллах тухай” дүүргийн Засаг даргын А/364 дүгээр захирамжийн дагуу ЭМТ, ӨЭМТ, ЕБС, Цэцэрлэгийн эмч нарт ТТТӨ-ний оношилгоо, эмчилгээний алгоритм бүхий гарын авлага, иргэд, эцэг эхэд чиглэсэн зөвлөгөө бүхий зөөврийн самбар хэвлүүлэхэд шаардлагатай 2,6 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн • Дотоод нөөцөөр эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын 10-14 хоногийн нөөц бүрдүүлэхэд 1,5 сая төгрөг зарцуулсан байна. 						
123	4.4.8	<table border="1" data-bbox="739 941 2089 1093"> <tr> <td data-bbox="739 941 1070 1093">Амьсгалын замаар дамжих халдварт өвчний дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлнэ.</td> <td data-bbox="1070 941 1299 1093">Дархлаажуулалтад хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ.</td> <td data-bbox="1299 941 1639 1093">Дархлаажуулалтад хамрагдалтын хувийг өмнөх оны түвшингээс ахиулсан байна.</td> <td data-bbox="1639 941 1814 1093">-</td> <td data-bbox="1814 941 1977 1093">НХХ, ЭМТ</td> <td data-bbox="1977 941 2089 1093">100%</td> </tr> </table> <p data-bbox="739 1093 2089 1431"> -2018 онд Дархлаажуулалтын 7 хоногийн хүрээнд дүүргийн Засаг дарга уриалга гарган зонхилон тохиолдох халдварт өвчнөөс урьдчилан 2 өдөрлөг, 3 сургалт зохион байгуулж 659 хүн хамруулсаны үр дүнд нийт товлолын дархлаажуулалтын хувь 1,8 хувиар ахисан байна. -2018 оны 10 сарын байдлаар товлолт дархлаажуулалтад 25359 хүүхэд хамруулахаас 24527 хүүхэд буюу 96.7% хамруулсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,8%-иар өссөн. -Пневмококкийн эсрэг вакцинд 10 сарын байдлаар 7772 хүүхэд хамрагдахаас 7452 хүүхэд буюу 95,9% хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 6,6%-аар өссөн - 2018 онд амьсгалын замын халдварт өвчин 642 тохиолдол буюу 10.000 хүн амд 46.8 байгаа нь өмнө оны мөн үеэс бодит тоогоор 576 буюу 10.000 хүн амд 42.0 –иор буурсан. Амьсгалын замын цочмог халдварт өвчнөөр эндэгдэл гараагүй, уушгины хатгалгаагаар 2018 онд 2 эндэгдэл бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 0.8 промилл буюу өмнө оны мөн үеэс 0,5-иар буурсан. </p>	Амьсгалын замаар дамжих халдварт өвчний дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлнэ.	Дархлаажуулалтад хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ.	Дархлаажуулалтад хамрагдалтын хувийг өмнөх оны түвшингээс ахиулсан байна.	-	НХХ, ЭМТ	100%
Амьсгалын замаар дамжих халдварт өвчний дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлнэ.	Дархлаажуулалтад хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ.	Дархлаажуулалтад хамрагдалтын хувийг өмнөх оны түвшингээс ахиулсан байна.	-	НХХ, ЭМТ	100%			

			<p>-2018 оны 10 сарын байдлаар нөхөнгөөр тавт болон халдварт саагийн вакцинд 883, УГУ – н вакцинд 509, ВГА –н вакцинд 328, ПЭВ-ийн вакцинд 1204, , В гепатит-н вакцинд 3, БЦЖ – н вакцинд 11 хүүхэд буюу нийт 2938 хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 1150 тохиолдлоор өссөн.</p> <p>-Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Улаанбурхан,гахайн хавдар, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/17 дугаар тушаал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 3 сарын 13-ны өдрийн 2/145 дугаар албан тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЭМТ-ийн 2018 оны 3 сарын 27-ны өдрийн “Улаанбурхан,гахайн хавдар, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” 184 дүгээр тушаалаар 5 Их дээд сургуулийн 7585 оюутныг дархлаажуулсан.</p> <p>-Дархлаажуулалтын товлалын дагуу Сахуу, татрангийн эсрэг вакцинд 6152 хүүхэд хамрагдахаас 5687 хүүхэд буюу 92.4%-тай хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал 3,2%-иар буурсан байна.</p> <p>-2018 оны 09 сарын 21-ний ХӨСҮТ-ийн “Менингококкын халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/84 дугаар албан даалгаварын дагуу эрсдэлт бүлгийн 2-6 настай 1500 хүүхэд хамрагдахаас 1441 буюу 96% хүүхэд хамруулсан.</p>					
124	4.4.9	НЗДҮАХ-ийн 4.2.6 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.4.6 Дүүргийн залуучуудын дунд “Эрүүл чийрэг залуус” аян өрнүүлнэ.	“Эрүүл залуус” аян хэрэгжүүлнэ.	Урьдчилан сэргийлэх үзлэг 70%, эрүүлжүүлэлт 30%-д хүргэнэ.	Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдсэн байна.	-	НХХ, ЭМТ	100%
			<p>“Эрүүл залуус”, “Хорт зуршлын эсрэг аян”-ы хүрээнд “Эрүүл залуус” сургалтын модуль боловсруулан, “Хорт зуршлын эсрэг хамтдаа” сэдвээр Өсвөрийн залуу зохион бүтээгчдийн лаборатори ахлах сургууль, 2, 6, 45, 31 дүгээр сургуулийн сурагч, ҮҮПТХ, Хөгжим бүжгийн коллеж, ШУТИС, МУИС-ийн оюутны байрны 551 оюутан залууст нөлөөллийн сургалт зохион байгуулсан.</p> <p>“Эрүүл залуус” аяны хүрээнд нийслэлийн Засаг даргын А/877, дүүргийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/60 дугаар захирамжийн дагуу сүрьеэ, БЗДХ-ын урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 6 их дээд сургуулийн 2893 оюутныг хамруулж тэмбүүгийн 10, сүрьеэ 6 тохиолдол илрүүлж, эмчилгээнд бүрэн хамруулсан .</p> <p>-ЭМТ, ӨЭМТ хамтран ЕБС-ын 5361 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, зөвлөгөө өгч, 5 удаагийн сургалт зохион</p> <p>-Дүүргийн Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Нийгмийн хөгжлийн хэлтэс хамтран дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч нарын уулзалтыг 4 удаа зохион байгуулж 205 эмч, мэргэжилтэн хамруулж, мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажилласан.</p>					
4.5 Зорилтод бүлгийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин ажиллана								
125	4.5.1	НЗДҮАХ-ийн 4.7.5 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 4.5.1	Зорилтот бүлгийн иргэдийн төрөлжсөн судалгааг гаргана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Зорилтот бүлгийн иргэдийн судалгааг нарийвчлан гаргасан байна. 100%	-	НХХ, ХөХҮХ	100%

		<p>Ахмад настан, эмзэг бүлгийн иргэдийн суурь судалгааг нарийвчлан гаргаж, өрхийн хөгжлийг дэмжин, хөтөлбөр, арга хэмжээнд хамруулна.</p>	<p>-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/04 тоот бичгээр “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэлтэй зорилтот бүлгийн иргэдийн нэрсийг ирүүлсэн. Тухайн зорилтот бүлгийн иргэдээс 2018 онд “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулах 448 өрхийг сонгох ажлыг Хороодын Засаг даргын ажлын албатай хамтран гүйцэтгэсэн. Зорилтот бүлгийн 448 өрхийн хэрэгцээний судалгааг 16 төрлийн хэрэгцээгээр нэгтгэн, 2286 иргэний мэдээллийн сан бүрдүүлж, судалгаанд 2150 иргэнийг бүрэн хамруулсан. Судалгааны төрлөөр: Хүйсийн хувьд: эрэгтэй -977, эмэгтэй -1173 Боловсролын түвшний хувьд: - Дээд боловсролтой -110 - Техник болон тусгай мэргэжлийн -76 - Бүрэн дунд боловсролтой -765 - Суурь боловсролтой -215 - Бага боловсролтой -236 - Боловсролгүй -561 иргэн байна. Нийт 125 хөгжлийн бэрхшээлтэй иргэн судалгаанд хамрагдсан. Үүнд: - Харааны бэрхшээлтэй -16 - Хэл ярианы бэрхшээлтэй -9 - Сонсголын бэрхшээлтэй -16 - Хөдлөх тулах эрхтэний бэрхшээлтэй -16 - Сэтгэц, оюуны бэрхшээлтэй -24 - Дотор эрхтэний бэрхшээлтэй -8 - Бусад хэлбэрийн эмгэгтэй 36 иргэн. Хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд: - Өрхийн бизнес эрхэлж буй -5 - Хувиараа хөдөлмөр эрхлэгч -95 - Хөдөлмөрийн гэрээтэй ажилтан -154 - Улирлын чанартай ажил эрхэлдэг -89 - Ажилгүй -674 иргэн байна. Амьдралын буруу хэвшил, дадал зуршилтай иргэн 25 иргэн байгаагаас архи, согтуурах, мансуурах зуршилтай 21 иргэн, гэр бүл, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг 4 иргэн байна. Тус судалгаанд хамрагдаагүй байсан дүүргийн 18 дугаар хорооны 136 иргэдийн судалгааг дараах төрлөөр гаргаж, мэдээллийн сан бүрдүүлсэн. Хүйсийн хувьд: Эрэгтэй – 53, эмэгтэй -83 Боловсролын түвшний хувьд: - Дээд боловсролтой -34 - Техник болон тусгай мэргэжлийн -12 - Бүрэн дунд боловсролтой -43 - Суурь боловсролтой - 29 - Бага боловсролтой -14 Хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэн.</p>
--	--	---	--

		Хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд: - Өрхийн бизнес эрхэлж буй -2 - Хувиараа хөдөлмөр эрхлэгч -1 - Хөдөлмөрийн гэрээтэй ажилтан -6 - Улирлын чанартай ажил эрхэлдэг -2 - Ажилгүй -125 иргэн байна.					
126	4.5.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалт зохион байгуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн байна.100%	-	HXX, ХөХҮХ	100%
		<p>-Тус дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй 3162 иргэн бүртгэлтэй байдаг. 2018 оны 11 дүгээр сарын 07-ны байдлаар дүүргийн “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс” нь нийт 14 удаа, 309 цаг хуралдаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадвар, хувь хугацааг тодорхойлсон байна. Үүнд:</p> <p>-Шинээр хөдөлмөрийн чадвар алдалт, хувь хугацаа тогтоосон 263 иргэн</p> <p>-Хөдөлмөрийн чадвар алдалт, хувь хугацаа сунгасан 1362 иргэнийг тодорхойлсон байна.</p> <p>-ХХҮХ, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисстой хамтран 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дүүргийн “Эрүүл мэндийн болон өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс”-ын гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “Нийгмийн халамжийн үйлчилгээний эрх зүйн орчин, мэдээлэл, анхаарах зүйлс” сэдвээр танилцуулга бэлтгэн танилцуулсан. Нийт 76 хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцож, Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө авсан.</p> <p>-Дүүргийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсол, нийгмийн хамгааллын салбар комисс” нь 2018 оны 4 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаа явуулж, 325 хүүхдэд байнгын асаргаа тогтоолгосон. Эдгээр хүүхдийн овог нэр, регистр, гэрийн хаяг, онош, хугацаа зэргээр мэдээллийн сан бүрдүүлсэн.</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр буюу 12 дугаар сарын 07-нд дүүргийн ХХҮХ, НХХ хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалт” зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.</p>					
127	4.5.3	Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг илрүүлэх, бүртгэх, нийгэмшүүлэх ажилд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэж, нийгэмшүүлсэн байна. 100%	-	HXX, ХөХҮХ	100%
		-Нийслэлийн хэмжээнд 1800 гаруй тэнэмэл, гэр оронгүй иргэд оролцсоноос тус дүүргийн 29 иргэн бүртгэгдсэн.					

			<p>2018 оны 02 дугаар сард дүүргийн улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран мэдээллийн санд шүүлт хийж, мэдээллийг шалгахад, тус дүүргийн бүртгэлтэй 19 иргэн, 10 иргэн нь харьяаллын бус иргэд байна. Тухайн 19 иргэний орон байр, байршлын хувьд:</p> <ul style="list-style-type: none"> - Байр, гэр байшин, хашаа, газраа зарсан шилжих хөдөлгөөний асуудалтай -3 - Тухайн хаяг дээрээ бүртгэлтэй боловч хаягандаа амьдардаггүй -7 - Бусдын гэрт, нийтийн байр, түрээсийн гэр, байшинд амьдардаг -3 - Үе үе тэнэж, алга болдог хаягандаа амьдарч байгаа -3 - Нас барсан -1 - Хавдар судлалын үндэсний төвд сүүлийн -3 сарын хугацаанд хэвтэн эмчлүүлж байгаа -1 - Өөрийн гэсэн гэр оронтой болж, ажилтай болсон -1 иргэн байна. <p>-Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтран “Гэртээ харих зам” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд” Сайн дурын нийгмийн ажлын оролцоо”сэдэвт хэлэлцүүлгийг 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр “Гэртээ харих зам” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дүүргийн нутаг дэвсгэрт тэнүүчлэн амьдарч буй гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэхэд ТББ, аж ахуйн нэгж, ОУБ-ын хамтын ажиллагааг сайн дурын нийгмийн ажлын хүрээнд удирдан чиглүүлэх, цаашид эрсдэлд өртөж болзошгүй зорилтот бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх ажлыг орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гаргах, санал солилцоход чиглэсэн арга хэмжээ болсон.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/359 тоот захирамжийн хүрээнд “Илрүүлэлт 2018” арга хэмжээг 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 11 дүгээр хорооны “Хайрын билэг” сүмд зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн талаар иргэдийг мэдээллээр ханган ажилласан.</p>					
128	4.5.4	<p>ДЗДҮАХ-ийн 4.5.4 Ахмад настныг эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, тэдний насны онцлогт тохирсон нийгмийн идэвхтэй амьдралд татан оролцуулах Ахмад настны зөвлөх үйлчилгээг өргөжүүлэн ажиллана.</p>	<p>Дадлага, туршлагатай ахмад мэргэжилтний судалгааг хороо бүрээр нь гарган зөвлөн туслах, мэдээлэл өгөх, туршлага дэлгэрүүлэх үйлчилгээг мэргэжлийн өндөр чадвартай ахмад мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>Дадлага туршлагатай ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. 100%</p>	-	<p>НХХ, ХөХҮХ, ЖДҮДТ</p>	<p>100%</p>
			<p>-Дүүргийн тэтгэвэр авагч 14282 ахмад настны судалгааг хороо тус бүрээр гаргасан. Үүнээс дадлага, туршлагатай /мэргэжлээрээ сүүлийн 15 болон түүнээс дээш жилийн хугацаатайгаар ажилласан/ ахмад мэргэжилтний судалгааг хороо бүрээр ангилбал:</p> <ul style="list-style-type: none"> • 1 дүгээр хороо 4 ахмад настан, 11 дүгээр хороо 6 ахмад настан, • 2 дугаар хороо 4 ахмад настан, 12 дугаар хороо 1 ахмад настан, 					

			<ul style="list-style-type: none"> • 3 дугаар хороо 3 ахмад настан, 13 дугаар хороо 3 ахмад настан, • 4 дүгээр хороо 0 ахмад настан, 14 дүгээр хороо 2 ахмад настан, • 5 дугаар хороо 2 ахмад настан, 15 дугаар хороо 4 ахмад настан, • 6 дугаар хороо 0 ахмад настан, 16 дугаар хороо 7 ахмад настан, • 7 дугаар хороо 4 ахмад настан, 17 дугаар хороо 6 ахмад настан, • 8 дугаар хороо 2 ахмад настан, 18-р хороо 7 ахмад настан, • 9 дүгээр хороо 2 ахмад настан, 19 дүгээр хороо 4 ахмад настан, • 10 дугаар хороо 8 ахмад настан, 20 дугаар хороо 3 ахмад настан, нийт 76 ахмад настан байна. <p>-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийг эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, төрийн захиргааны байгууллагын чиглэлээр сургалт зохион байгуулах 26 ахмад мэргэжилтэн хүсэлтээ ирүүлж, 19 ахмад мэргэжилтний төслийг дэмжин ажилласан.</p> <p>-2018 оны 11 дүгээр сарын байдлаар 15 ахмад мэргэжилтэн зөвлөх үйлчилгээг эрүүл мэнд, боловсролын чиглэлээр 240 цагийн хичээлийн төлөвлөгөө боловсруулан 297 өсвөр, хойч залуу үеийнхэнд сургалтыг гэрээгээр зохион байгуулав. Нийт 15 ахмад мэргэжилтэн сургалтыг зохион байгуулж, 12 сая 285 мянган төгрөгний цалингийн урамшуулал олголоо.</p>				
129	4.5.5	Ахмадуудад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Төлөвлөгөөт ажил зохион байгуулсан байна. 100%	-	НХХ, ХөХҮХ	100%
		<p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн дүүргийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний тухай А/25 дугаар захирамж, дүүргийн ЗДТГ-ын даргын А/14 дугаар тушаалаар Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарыг тохиолдуулан 20 хорооны нийт 13500 ахмадыг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ. Хороо бүр ахмадуудад гарын бэлэг гардуулж, урлагийн тоглолт, бөхийн барилдаан, эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах зэрэг арга хэмжээ зохион байгууллаа.</p> <p>-2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Батсүмбэр дэх Ахмад настны үндэсний төвд асруулж байгаа ахмад настнуудыг хүлээн авч уулзаж, ахмад настнуудынхаа биеийн байдалтай танилцаж, асрамжийн төвийн үйлчилгээний талаар санал солилцлоо.</p> <p>-Ахмад настны тухай хуулийн дагуу байгууллага, аж ахуйн нэгж нь татан буугдсан болон харъяалалгүй ахмад настнуудад гарын бэлэг гардуулах ажлыг дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын Засаг даргын ажлын албадтай хамтран 2018 оны сар шинийн баярын өмнө зохион байгуулсан. Нийт 20 хорооны зорилтот бүлгийн 2700 ахмад настанд 27 сая төгрөгийн гарын бэлэг гардуулсан.</p> <p>-Сайн дурын нийгмийн ажлын хүрээнд дүүргийн 14 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулдаг 13 аж ахуй нэгж байгууллагатай хамтран 42 ахмад настанд, 20 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг 9 ААНБ-тай хамтран хэвтрийн 10 ахмад настанд хүнсний тусламж бэлэглэлээ.</p> <p>-“Олон улсын ахмадын өдөр”-ийг тохиолдуулан “Нас ахих тутам зөвхөн бодит сайн сайхныг мэдэрнэ” уриан дор дүүргийн эрүүл мэндээс зохион байгуулсан өдөрлөгт оролцож, Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн талаар танилцуулга хийсэн. Нийт 75 ахмад настанд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.</p>					

			<p>-Ахмадын зөвлөлийн дарга нарын семинар-сургалт зохион байгуулж, 2017 онд зохиосон ажлын тайлан, 2018 онд зохиох ажлын чиглэлтэй танилцлаа.</p> <p>-Герентологийн Үндэсний төв, дүүргийн Ахмадын хороо хамтран эрүүл мэндийн идэвхтэн сургагч багш бэлтгэх 5 хоногийн сургалт зохион байгуулав.</p>					
5. Дэвжин дээшлэх Сүхбаатар дүүрэг								
5.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана								
130	5.1.1	<p>ДЗДҮАХ-ийн 5.1.1 Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдын чуулга уулзалтыг жил бүр явуулна.</p>	Ажлын байр нэмэгдүүлэх аян, Ажил олгогчдын өдөрлөгийг байгууллага, аж ахуйн нэгжийн дунд зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Байнгын ажлын байртай болох иргэдийн тоо нэмэгдсэн байна. 100%	-	НХХ, ХӨХҮХ	100%
			<p>-Байнгын ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил олгогчийг дэмжих арга хэмжээний танилцуулга, мэдээлэл өгөх зорилгоор аян зохион байгууллаа. Нийт 300 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, зорилтот бүлгийн иргэнийг байнгын ажлын байраар хангасан тохиолдолд олгох мөнгөн урамшууллын талаарх мэдээлэл холбогдох бусад танилцуулгын хамт хүргүүлсэн. Аяны хүрээнд дүүргийн хэмжээнд шинээр бий болсон 206 ажлын шинэ байр бүртгэсэн.</p> <p>-Дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, ХХҮХ, Нийгмийн даатгал, Мэргэжлийн хяналтын хэлтэс хамтран дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын дунд Ажил олгогчдын зөвлөгөөн зохион байгуулахаар төлөвлөж, санхүүжилтийн асуудлаас шалтгаалж, тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.</p> <p>-Дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар ажил олгогчдын дунд сарын аян зохион байгуулж, “Эрсдэлийн үнэлгээний сургалт, хэлэлцүүлэг” зохион байгуулж, дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 85 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. Дээрх аж ахуйн нэгжүүдэд хууль тогтоомжийн талаарх танилцуулга, мэдээлэл өгч, хамтран ажилладаг, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтээр шилдгээр шалгарсан Скайтел ХХК, Үйлдвэрлэл урлалын политехникийн дээд сургууль, Бояарс констракшн ХХК-ийг шагнаж урамшуулсан.</p> <p>- Дүүргийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн “Дүүргийн хөнгөн үйлдвэрийн салбарт улсын үзлэг зохион байгуулах тухай” А/293 тоот захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хөнгөн үйлдвэрийн чиглэлийн үйлдвэр, цех, байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах зорилгоор хяналт шалгалт явуулсан. Үзлэгийг 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж, нийт 124 хөнгөн үйлдвэр, цех, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан. Зөрчил, тулгамдсан асуудлыг нарийвчилсан судалгаагаар гаргаж, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.</p>					
131	5.1.2	<p>ДЗДҮАХ-ийн 5.1.3 Хороодод байрлах Е биржийн /Киоск машин/ үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд</p>	Хороодод байрлах Е биржийн хэвийн ажиллагааг ханган иргэдэд ажлын байрны мэдээлэл, хэрэгжиж буй	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Иргэд хороодоос ажлын байрны зар мэдээллийг шуурхай авдаг болсон байна.	-	НХХ, ХӨХҮХ	40%

		ажлын байрны мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж ажиллана.	төсөл хөтөлбөр, сургалтын талаарх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэнэ.						
			Дүүргийн 20 хороо, хэлтсийн байранд Е-бирж ажиллаж, 3 дугаар улиралд хороо бүрийн Е-биржийн програм хангамжийг шинэчилж ХХҮЕГ-ын төв сервертэй холбож, ажлын байрны зар, мэдээлэл тухай бүр шинэчлэгдэж хэвийн ажиллаж байна. Одоогоор тус шинэчлэгдсэн програмд хяналтын менежер програм хийгдэж байгаа тул Е-биржийн ажилласан цагийн мэдээлэл гаргах боломжгүй байна.						
132	5.1.3	НЗДҮАХ-ийн 4.7.3 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 5.1.4 Ажил олоход хүндрэлтэй, зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлд бэлдэн, хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	Зорилтот бүлгийн болон ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдийг байнгын ажлын байранд авч ажиллуулсан ажил олгогчдод цалингийн дэмжлэг, урамшуулал олгох, зөвлөгөө мэдээллийн үйлчилгээнд хамруулж, ажил олгогчийн захиалгад тулгуурлан ажилд бүртгэж зуучилна.	Байнгын ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо, ажлын шинэ байрны тоо, урамшуулал, цалингийн дэмжлэгийн хэмжээ нэмэгдэнэ.	Зорилтот бүлгийн иргэд байнгын ажлын байртай болсон байна.	-	НХХ, ХөХҮХ	100%	
			<p>-Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд 484 иргэн ажлын байранд зуучлагдсанаас зорилтот бүлгийн 18 иргэн ажилд зуучлагдсан байна.Үүнд:</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй -7</p> <p>Өрхийн болон хувийн аж ахуй нь эрсдэлд орж орлогогүй болсон -7</p> <p>Хорихоос суллагдсан -4 иргэн байна.</p> <p>Мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтад зорилтот бүлгийн 190 иргэн хамруулсан. Үүнд:</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн -30</p> <p>Эмзэг, эрсдэлтэй бүлгийн иргэн -30</p> <p>Хорих ангид хүмүүжигч болон суллагдсан иргэн -100</p> <p>Хөдөө орон нутгаас хотруу шилжин ирсэн -30 иргэн.</p> <p>Арга хэмжээний шалгуурын дагуу гэрээ байгуулснаас хойш 12 сарын хугацаа дуусаагүй тул гэрээг дүгнэх боломжгүй.</p> <p>-2017 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан Туст увидас ХХК, СБД-ийн оёдолчдын холбоо ТББ–тай “Ажил олгогчийн урамшуулал олгох” гэрээ байгуулан ажиллаж, 2.880.000 төгрөгийн урамшууллыг олгосон. Мөн 2018 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан “Хайрхан бүрд” ТББ, СӨҮЛ ХХК-тай “Ажил олгогчийн урамшуулал олгох гэрээ” байгуулан ажиллаж байна. Энэхүү</p>						

			гэрээг 2019 онд дүгнэж, ажил олгогчийн урамшууллыг олгоно. Арга хэмжээний хүрээнд ажил идэвхтэй хайгч 2 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэн байнгын ажлын байраар хангагдсан байна.					
133	5.1.4		Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ хэрхэн сонгох, ажил олоход хүндрэлтэй иргэдэд бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээлэл, хөдөлмөрийн харилцааны талаарх зөвлөгөө өгч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Төгсөх ангийн сурагчид, тэдний эцэг эх мэргэжил сонголтын талаар мэдлэгтэй болсон байна. 100%	-	НХХ, ХөХҮХ	100%
			<p>-2018 оны 11 сарын байдлаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг 622 иргэнд ганцаарчилсан мэдээлэл, зөвлөгөө хэлбэрээр өгч ажиллалаа.</p> <p>- Тэнгэр судалгааны төв, Хайрхан бүрд сургалтын төв, Мөнх оюуны холбоос сургалтын төв, Орчин үеийн карьер менежментийн академи, Монголын хүний нөөцийн менежментийн холбоотой хамтран мэргэжил сонголтын чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөөг нийт 136 төгсөх ангийн сурагч, тэдний эцэг эхэд, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг ЕБС-ийн ахлах ангийн 2000 /8-12 дугаар анги/ сурагчийг хамруулж, тэдний мэргэжил сонголт, ур чадвараа тодорхойлоход нь тусалцаа үзүүлж, хамгийн эрэлттэй 20 мэргэжлийг танилцуулсан.</p>					
134	5.1.5	НЗДҮАХ-ийн 4.7.8 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 5.1.5 Дүүргийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг бизнес инкубацийн үйл ажиллагаанд хамруулна.	Аж ахуй эрхлэлтийн сургалт, түрээсийн хөнгөлөлт, борлуулалтын цэгт ажиллах эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэнэ.	Эмэгтэйчүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн байна. 100%	-	НХХ, ХөХҮХ	100%
			<p>-Эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд шаардлага хангасан өрхийн болон бичил бизнес эрхлэгч 58 эмэгтэй хамрагдаж, 176,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 98 эмэгтэйг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулж, чадавхижууллаа.</p> <p>-Борлуулалтын цэг ажиллуулах, түрээсийн хөнгөлөлтийн арга хэмжээнд хамруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг ХХҮХ-ийн даргын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/25 тоот тушаалаар байгуулж, дүүргийн хэмжээнд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 16 иргэнийг ажлын байрны түрээсийн</p>					

			хөнгөлөлтөд хамруулж, 7,653,520 төгрөгийн хөнгөлөлт олгож, 26 иргэний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь борлуулахад нь дэмжлэг үзүүлэхээр Баянзүрх худалдааны төвтэй гэрээ байгуулан ажиллаж байна.					
			Өрхийн тариалан эрхлэгчдэд зориулж онолын танхимын болон практик сургалт зохион байгуулна.	Тариалан эрхлэгчдийн мэдлэг чадварыг сайжруулах чиглэлээр хавар, намрын сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 200 иргэнийг хамруулна.	Дүүргийн тариалан эрхлэгчдийн мэдлэг, ур чадвар дээшилж, хүн амын хүнсний хангамж сайжирсан байна.	-	ХХҮХ	100%
135	5.1.6		<p>Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах, өрхийн тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тарьж ургуулах чиглэлээр аж ахуй эрхэлж буй тариаланчдын мэдлэг чадварыг сайжруулах, харилцан туршлага солилцох, хөдөө аж ахуйн салбарт нэвтэрч буй шинэ техник технологи, зоорь, хүлэмжийн аж ахуйтай танилцах зэрэг хавар, намрын ээлжит сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.Тухайлбал:</p> <p>Адра-Монгол Олон улсын байгууллагатай хамтран пермакултурын ахисан шатны мэдлэгтэй болгох, нэгдсэн талбайд төмс, хүнсний ногоо тарих аргачлалд сургах зорилгоор онолын болон танхимын сургалтаар 1 га газрын үр ашгийн тооцоо, үр тариаланд бэлтгэх, сонголт, хөрс боловсруулалт, бордоо бэлтгэх, хучилга, чийгийн улаан үржүүлэг, ургамал ургалтын үеийн арчилгаа, усалгаа, хог ургамлын менежмент, ургамал хамгаалал зэрэг сэдвүүдээр төслийн ажилтан, багш нар хичээл зааж, тариалан эрхлэгчдийн мэдлэг чадварыг сайжруулж, намрын ээлжит сургалтаар өрхийн тариалан эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, өрхийн тариалан эрхлэгчдийн 2018 онд хийсэн ажлыг дүгнэж, хүнсний тогтвортой байдлыг хангах, бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон борлуулалтын үйл ажиллагаанд өөртөө туслах бүлгүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, мэдээлэл, зөвлөмж өгсөн.</p> <p>Мөн Монгол ногоо төслийн хавар, намрын ээлжит сургалтанд төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа 30 өрхийн тариалан эрхлэгчдийг хүлэмжийн аж ахуй эрхлэх дадлага сургалтанд, Монголын Хүнс, хөдөө аж ахуйн Үндэсний Ассоциацитай хамтран 2018 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Төв аймгийн Борнуур сумын газар тариалангийн бүс нутагт зохион байгуулж, дүүргийн 30 өрхийн тариалан эрхлэгчдийг тус тус хамруулж, өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж ажиллалаа.</p> <p>Монгол ногоо төслийн багийнхантай хамтран “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ даршлах арга” сэдэвт онолын болон танхимын сургалтыг 2018 оны 11 дшгээр сарын 14-ний өдөр амжилттай зохион байгуулж, өрхийн тариаланч 30 иргэнийг хамруулан, өөрсдийн тарьж ургуулсан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг хэрхэн урт удаан хадгалж хүнсэндээ хэрэглэх, хэрхэн боловсруулж, даршлах талаар Монгол ногоо төслийн багш, агрономч Н.Чанцал зааж, төрөл бүрийн ногооны салат, лечо, компот, вино хийх аргуудыг зааж сурган,</p>					

			<p>мэргэжлийн зөвлөгөө өгч, дадлага хичээлээр эдгээр арга техникт суралцуулж, “Хүнсний ногоо боловсруулах технологи, жор” номыг тараан өгч, гарын авлага материалаар хангасан.</p> <p>Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зарласан “Жимсний суулгац зээлээр олгох”-СШ/18ЖЖСЗ-01 төслийг алим, чавга тариалах сонирхолтой иргэн, аж ахуйн нэгжүүдэд танилцуулж, сурталчилснаар уг төслийн шалгаруулалтанд дүүргийн 13, 14, 20 дугаар хорооны 3 иргэн тэнцэж, үхрийн нүд-175 ш, алим-111ш, чавганы 21 ш, нийт 307 ш суулгацыг зээлээр авч, тариалан, амин дэмээр баялаг хүнс хэрэглээгээ хангаж, өрхийн хүнсний хангамжаа нэмэгдүүлсэн байна.</p> <p>МУ-ын Засгийн газрын Монгол ногоо хөтөлбөрийн хүрээнд дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжин, НХХААГ-аас олгосон шар лууван, шар манжин, хүрэн манжин, төл сонгино, сармис, бөөрөнхий сонгино, урт сонгино, гоньд, тарвас, амтат гуа зэрэг нийт 10 нэр төрлийн 50,12 кг хүнсний ногооны 921850 төгрөгний үнэ бүхий үрийг үнэ төлбөргүй олгож, хүнсний хангамжийг сайжруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлснээр дүүргийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар 0,5 га талбайгаас 7,06 тонн төмс, 1.4 га талбайгаас 22.4 тонн төрөл бүрийн хүнсний ногоо, нийт 1.9 га-аас 29,46 ургац хураан авч, үүнээс хүлэмжнээс 16.1 тонн нарийн ногоо хураан авч, хүнсний хэрэгцээгээ хангаж байна.</p> <p>Ургац хураалтын тоон мэдээг 2017 онтой харьцуулбал тариалалтын талбайн хэмжээ 0,1 га-гаар буурч, төмс 1,06 тонн, хүнсний ногоо 1,6 тонноор, ургацын хэмжээ нийт 2.66 тонноор өссөн байна.</p> <p>Мөн дүүргийн 16 дугаар хорооны иргэн, өрхийн тариалан эрхлэгч Ж.Наранцэцэгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг дэмжин, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлж, төслийн шалгаруулалтанд оролцуулан, хүнсний ногоо даршлах анхан шатны тоног төхөөрөмж олгосон.</p>					
136	5.1.7	ЗГҮАХ-ийн 2.15 дахь заалт; НЗДҮАХ-ийн 4.7.7 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 5.1.6 Аж ахуйч өрх хөтөлбөр хэрэгжүүлэн, тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Ажлын байрыг шинээр бий болгох зорилгоор өрхийн аж ахуй, жижиг дунд болон бичил бизнес эрхлэгчдээс санаачлан ирүүлсэн төсөлд дэмжлэг үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Зорилтот бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг олгож, шинээр ажлын байр бий болгосон байна.100%	-	НХХ, ХөХҮХ	100%
			<p>-Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн дагуу эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох 122 төсөл хүлээн авч шаардлага хангасан 87 иргэнд нийт 260,100,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Үүнд:</p> <p>-2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/16 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг аж ахуй, бичил бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 35-аас дээш насны иргэдэд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох 137 төсөл хүлээн авч, шаардлага хангасан 86 иргэнд нийт 243,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 86 иргэний үйл ажиллагаа тогтмолжиж, шаардлагатай тоног төхөөрөмжөө худалдан авч, орлого нэмэгдэж, 86 иргэн ажлын байраа хадгалан, 31 ажлын байр шинээр бий болсон.</p> <p>-12 ахмад настанд 30 сая төгрөгийн, өрхийн үйлдвэрлэл, аж ахуй үйлчилгээгээ өргөтгөх, ажлын байраа хадгалах зорилгоор дэмжин, хөтөлбөрийн үр дүнд нийт 12 байнгын ажлын байр,</p>					

			<p>-Хөгжлийн бэрхшээлтэй 23 иргэнд 87 сая төгрөгийн, өрхийн үйлдвэрлэл, аж ахуй үйлчилгээгээ өргөтгөх, ажлын байраа хадгалах зорилгоор дэмжин, нийт 23 байнгын ажлын байр бий болсон байна.</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 2 дахь удаагийн төсөл сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулахаар ХХҮХ-ийн цахим хуудас болон хороодын хөдөлмөр эрхлэлт, халамжийн мэргэжилтнээр дамжуулан иргэдэд зар хүргэн ажиллаж байна.</p>					
137	5.1.8	НЗДҮАХ-ийн 5.1.9 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 5.1.7 “Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулна.	Албан үүрэгт нь шаардлагатай сургалтад хамруулсан байна.	Мэргэшсэн албан хаагчдын тоо, ажлын хариуцлага, гүйцэтгэлийн чанар нэмэгдсэн байна.	-	ТЗУХ	100%
Удирдлагын академийн Төрийн захиргааны менежментийн мэргэшүүлэх сургалтад 4 албан хаагч суралцаж байна. Мөн 1 сарын хугацаатай мэргэшүүлэх онлайн сургалтад 4, “Олон нийтийн харилцаа, мэдээллийн ил тод байдал” богино хугацааны сургалтад 1 албан хаагч хамрагдлаа. Архивын ерөнхий газрын Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагч суралцаж төгссөн. Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан 11 удаагийн 1-2 өдрийн сургалтад давхардсан тоогоор 74 албан хаагч хамрагдсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 26 удаагийн 1 өдрийн сургалтад нийт 121 албан хаагчийг хамруулсан.								
138	5.1.9	НЗДҮАХ-ийн 5.1.9 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 5.1.7 “Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлнэ.	Мэдээллийн цагаар ажлын байранд сургах сургалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Жилд 12-16 удаа сургалт зохион байгуулна.	Цаг үеийн хэрэгцээт мэдээллээр хангагдсан байна.	-	ТЗУХ	100%
Төрийн албан хаагчдын идэвх санаачлага, бүтээлч, ажил хэрэгч байдлыг дээшлүүлж чадваржуулах, тэдний харилцааны соёл, өөрийгөө хөгжүүлэх, илэрхийлэх, ярих, илтгэх ур чадвар, ёс зүй, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэхээс гадна өөрийн ажлын онцлог, гүйцэтгэх үүргийн талаар бусаддаа танилцуулах замаар Мэдээллийн цагийг сонирхолтой, үр дүнтэй зохион байгуулж, мэдээ, мэдээллээр хангах, харилцан бие биенээсээ суралцах зорилгоор 2018 оноос албан хаагчдаар өөрсдөөр нь сургалт, илтгэлийг бэлдүүлэн танилцуулах ажлыг эхлүүлээд байна. Энэ хугацаанд 27 албан хаагч 9 удаагийн сургалтыг зохион байгуулж, бусаддаа илтгэлээ танилцуулсан. Нийтдээ Мэдээллийн цагаар 13 удаа сургалт зохион байгуулж албан хаагчдыг хамруулсан байна.								
139	5.1.10		Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	Жилд дунджаар 10-15 албан хаагч хамрагдана.	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдсан байна.	-	ТЗУХ	100%
Засаг даргын Тамгын газрын болон хороодын 30 албан хаагчид нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж 222,0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.								

140	5.1.11		Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр тэмцээн, уралдаан зохион байгуулна.	Шаардлагатай, хэрэгцээт тэмцээн, уралдаан зохион байгуулна.	Албан хаагчдын багаар ажиллах чадвар, шинэ санаа, бүтээлч чанар нэмэгдсэн байна.	-	ТЗУХ	100%
			Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Авлигагүй Сүхбаатар дүүрэг” сэдэвт мэтгэлцээний тэмцээнийг дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, Тамгын газар, хороодын төрийн албан хаагчдын дунд 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, тэмцээнд 36 багийн 72 албан хаагч мэдлэг, ур чадвараа сорин оролцсон. Шалгарсан багийг 1, 2, 3, тусгай байр эзлүүлэн Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.					
141	5.1.12	НЗДҮАХ-ийн 5.4.2 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 5.1.8 Дүүргийн иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэнэ.	Батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг дүүргийн иргэдэд сурталчлах, иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад шалган туслах ажлыг тогтмолжуулан иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн иргэд Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй болж, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй болсон байна.	-	ЦШ	100%
			<p>Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээ, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 оны зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус мөрдлөг болгон дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 2018 онд Засаг даргатай нийт 4 чиглэлээр 48 төрлийн 96 ажил үйлчилгээ явуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс жилийн хугацаанд 94 ажил үйлчилгээ төлөвлөснөөс бүрэн биелсэн.</p> <p>Батлан хамгаалахын сайд, нийслэлийн Засаг даргатай 2018 онд хамтран ажиллах гэрээний 4.1 дэх заалтад тусгагдсан ажлыг 100 хувь биелүүлсэн байна.</p> <p>Батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг дүүргийн иргэд, хүүхэд залууст сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, хороодтой байнга хамтран ажиллаж байна.</p> <p>“Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 97 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/141 дүгээр захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/55 дугаар захирамжийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Дүүргийн хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг штабын бүрэлдэхүүнээр</p>					

		<p>хэлэлцэн нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төлөвлөгөөтэй уялдуулан 12 ажил үйлчилгээг төлөвлөж явуулсан.</p> <p>Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 97 жилийг ойг тохиолдуулан нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ажиллаж байгаад гавьяаны амралтандаа суусан ахмадууд, ажиллаж байгаа офицер, ахлагч нарын дунд шатар, даам, олс таталт, гар бөмбөг, дардас гэсэн спортын таван төрлөөр цогцолбор тэмцээнийг 2018 оны 02 дугаар сарын 21, 23-ны өдрүүдэд БХЯ-ны Багабаян цэргийн амралтын газар зохион байгууллаа.</p> <p>Спортын арга хэмжээний багийн нийлбэр дүнгээр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын баг тэргүүн байранд шалгарсан.</p> <p>Сүхбаатар дүүргийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг, спортын “Дөл” тоглолт ҮБХИС-ийн материаллаг баазыг түшиглэн 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан. “Дөл” тоглолтод төрийн болон төрийн бус өмчийн 11 сургуулийн баг, тамирчид цэрэгжилтийн спортын 8 төрлөөр ур чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.</p> <p>Тэргүүн байранд ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн “Цэгц-11” баг шалгарсан.</p> <p>Өсвөр үеийн хүүхэд багачуудад цэрэг, эх оронч хүмүүжил төлөвшүүлэх үүднээс дүүргийн ерөнхий боловсролын 16 дугаар сургуулийн 4-6 дугаар ангийн 240 сурагчдад 03 дугаар сарын 19-ний өдөр Монгол цэргийн музейг үзүүлэн эх орон, цэрэг эрсээрээ бахархах түүх дурсгалтай танилцуулах мэдлэг олгох талаар үйл ажиллагааг дүүргийн Цэргийн штабаас 4 дэх жилдээ зохион байгуулав.</p> <p>Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 97 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас зохион байгуулсан “Монгол цэргийн алдар” зохион бичлэгийн уралдааны нэгдүгээр шатны уралдаанд дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 24 сургуулийн 115 сурагч бүтээлээ ирүүлснээс дүүргийн Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран шалгаруулан эхний 5 байранд шалгарсан бүтээлийг уралдааны хоёрдугаар шатанд оролцуулснаас 3-р байрт 31 дүгээр сургуулийн 10б ангийн сурагч Г.Тэмүүлэнгийн бүтээл шалгарч нийслэлийн Засаг даргын өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулсан. Нэгдүгээр шатны уралдаанд шалгарсан 5 хүүхдийг дүүргийн Засаг даргын өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасныг нийслэл, дүүргүүдийн Цэргийн штабуудын ажлаа сурталчлах өдөрлөгийн арга хэмжээний үеэр гардуулав.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2018 онд А/37 дугаар захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн 8, төрийн бус 4 нийт 12 байгууллагын Захиргаа, хуулийн тасгийн мэргэжилтэн, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байдалд шалган туслах ажлыг явуулах талаар арга зүйн сургалт явуулсан.</p> <p>Жилд дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Гэрлэх ёслолын ордон, Дуурь бүжгийн эрдмийн театр, Юнигаз ХХК, Тэспетролиум ХХК, АШУҮИС, Нийслэлийн түргэн тусламжийн төв, зэрэг 12 байгууллагын 769 цэргийн үүрэгтний үүргийн биелэлтэд хяналт, шалгалт явуулж, 940 гаруй иргэнд хууль тогтоомжийн талаар мэдээлэл хүргэн цэргийн бүртгэлд хамрагдаагүй 83 шилжилт хөдөлгөөний журам зөрчсөн 46 иргэнийг сануулж, цэргийн үүрэгтний үнэмлэхгүй 36 иргэнд үнэмлэхийг шинээр олгон, цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 72 иргэнд цэргийн дүйцүүлэх албаны</p>
--	--	--

			мөнгөн төлбөрийн хэлбэрээр оруулан хаалгахаар төлбөрийн мэдэгдэх хуудас бичиж олгон барагдуулахад хяналт тавин ажиллаж байна.					
142	5.1.13		Дайчилгааны бэлтгэл нөөцийн болон цэргийн бэлтгэл үүрэгтний сургалт дадлагын чанарыг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Цэргийн штабын бэлэн байдал хангагдсан байна.	-	ЦШ	100%
			<p>Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөө, хавсралтуудыг тодотгон биелэлтийг ханган ажиллаж байна.</p> <p>Дүүргийн Засаг даргын захирамжаар батлагдсан дадлагын дохио тогтоох тухай, цугларах болон шилжүүлэх байр, тэдгээрийн дарга нарыг томилох, малтай иргэдийг даалгаваржуулах, хороодод дайчилгааны даалгавар өгөх, орон нутгийн цэргийн томилгоот отрядын бүрэлдэхүүнийг томилгоог тодотгон орон нутгийн отрядын бүрэлдэхүүнийг зэвсэг, галт хэрэглэл, тээврийн хэрэгсэл, хүнсээр хангах тооцоог урьдчилан гарган ажилласан.</p> <p>Цэргийн штабын сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу техник шилжүүлэх болон цугларах байрын болон дайчилгаа удирдах бүлгийн гишүүдтэй тус тус 1 удаа сургалтыг зохион байгуулж явуулсан. Эдгээр сургалт, дадлагуудаар албан тушаалтан бүрийг үүрэг, оролцоо цугларах болон шилжүүлэх байруудыг дэлгэн хөтлөгдөх баримт бичгүүдийг хөтлөх, тасгуудын дарга нар болон томилгоот бие бүрэлдэхүүнд ажиллах заавар, хэрхэн ажиллах талаар зааварчилгаа өгч ажилласан.</p> <p>Тодотголыг тухайн ангийн захирагч, штабын дарга, дайчилгааны офицеруудыг байлцуулан ангийн угтах байр, татан нийлүүлэх хугацаа, байршлыг тогтоон тодотгол явуулсан тухай тэмдэглэлийг 3 хувь үйлдэн, “Монгол Улсын Зэвсэгт хүчний нууцыг хамгаалах журам”-ын дагуу баримт бичгийг хөтлөн ажилласан.</p> <p>2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн Зэвсэгт хүчний дугаар ангиуд хуваарийн дагуу тодотгол явагдаж байна.</p> <p>Дайчилгааны бэлтгэл нөөцийг бүрдүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2018 оны сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 011 дүгээр ангитай хамтран цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн иргэнийг жолооны “В” ангиллаас “С” ангилал ахиулах сургалтад суралцуулан төгссөний дараа мэргэжлийн дагуу анги, командуудад оногдуулан дансалсан.</p> <p>Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/100, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/39 дүгээр тушаалын дагуу дүүргийн Улсын дайчилгааны төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнийг 2018 оны 04 дүгээр сарын 12-13-ны өдөр БХЯ-наас зохион байгуулсан “Цэргийн бэлтгэл” сургалтад хамруулсан.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2018 оны А/358 дугаар захирамж, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын 2018 онд зохион байгуулах сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Нийслэл, дүүргүүдийн Цэргийн штабын офицер, ахлагч нарын “Цэргийн бэлтгэл сургалт”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн байрлалд зохион байгуулсан.</p>					

143	5.1.14	<p>Цэрэг техникийн тоо бүртгэл, цэрэг халалт татлага,Цэргийн алба хаах хэлбэрүүд, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дээшлүүлэх төрөөс үзүүлдэг халамж үйлчилгээг цэргийн алба хааж байгаа иргэдийн ар гэр, цэргийн албанаас халагдсан иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал сайжирч, цэргийн алба хааж байгаа болон хаасан иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ сайжирсан байна.</p>	-	ЦШ	100%
<p>2018 оны цэргийн бүртгэлийг зохион байгуулж явуулах тухай нийслэлийн Засаг даргын 2017 оны А/932 дугаар захирамжийг үндэслэн, дүүргийн Засаг даргын 2017 оны А/404 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг, хороодод цэргийн бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулж явуулах аргачлалын талаарх сургалтыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга нарт сургалтыг зохион байгуулж, хороодыг хариуцуулан бүртгэлийн үед хяналт тогтоон ажиллах талаар чиглэл зөвлөмж өгч, цагийн хуваарийг баталгаажуулан үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилласан.</p> <p>Цэргийн бүртгэлийн ажлын явцад хорооны зохион байгуулагч нарын санал хүсэлтийг сонсон, бүртгэл хөтлөх аргачлал болон өдөр тутмын мэдээг нэгтгэх асуудлыг дахин тодотгож өгснөөр хороодын ажил бүрэн жигдэрсэн. Хороод хүн ихээр зорчдог газруудад цэргийн бүртгэлийн талаарх зарлал мэдээллийг тавьсан бөгөөд мөн айл өрхүүдээр хэсгийн ахлагч нар зар тарааж цэргийн бүртгэлд байх насны эрэгтэйчүүдийг цэргийн бүртгэлд бүрэн хамруулах талаар анхаарч ажилласан.</p> <p>Дүүргийн хэмжээнд статистик мэдээгээр цэргийн бүртгэлд хамрагдвал зохих бүрэлдэхүүний 98,3 хувь нь цэргийн тоо бүртгэлд хамрагдлаа. Өмнөх онуудад цэргийн бүртгэлд хамрагдаагүй байсан иргэдийг ирүүлэн бүртгэх талаар анхаарч ажилласан. Цэрэгт шаардлагатай чухал мэргэжлийн эмэгтэйчүүдийн судалгааг гаргасан. 2000 онд төрсөн залуучуудад цэргийн үүрэгтний үнэмлэх шинээр олгох, цэргийн үүрэгтний үнэмлэх аваагүй иргэдийг үнэмлэхжүүлэв.</p> <p>Цэргийн бүртгэл явагдаж байгаа талаарх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор зар сурталчилгаа, сурталчилгааны плакатуудыг худалдааны цэгүүд, томоохон аж ахуйн нэгж, хороодын байр, хэсэг гудамж, хүн ам олноор төвлөрсөн газруудад байрлуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажилладаг TV-9, SBN, VTV телевизүүдийн урсдаг зараар цэргийн бүртгэл явагдаж байгаа талаар, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабаас бэлтгэн гаргасан “Цэрэг хүү” шторк тус бүрийг өдөрт 3 удаа явуулсан ба хороодын гадна байрлах LED дэлгэцээр бүртгэл явагдаж байгаа тухай зарыг мөн дүүргийн цахим сайт www.sbd.gov.mn болон хороодын facebook page хуудсаар тогтмол хүргэж байлаа.</p>							

			<p>Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/292, А/860 дүүргийн Засаг даргын 2018 оны А/119, А/309 дүгээр захирамжуудыг удирдлага болгон тус дүүргийн нутаг дэвсгэрт цэргийн жинхэнэ албаны 2018 оны нэгдүгээр, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулан явууллаа.</p> <p>Цэргийн албаны ээлжит татлага, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзлэгийн бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөөг боловсруулан дүүргийн Цэрэг татлагын товчооны даргаар батлуулж хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Цэрэг татлагын байрны эрүүл мэндийн үзлэгээр орсон, цэргийн албанд татагдагчдаас 13.7 хувь нь эрүүл мэндээр, 71,3 хувь нь суралцахаар, 10,5 хувь нь ар гэрийн гачигдлаар, 6 иргэн хэргийн холбогдолтой гэсэн шалтгаанаар түр чөлөөлөгдөж, тэнцсэн иргэд цэргийн албанд албаа хааж байна.</p> <p>2018 оны нэгдүгээр, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндээр түр чөлөөлөгдсөн иргэдийн тоо өмнөх жилийн цэрэг татлагаар орж мөн шалтгаанаар түр чөлөөлөгдсөн иргэдээс 0,4 хувиар буурч эрүүл мэндээр чөлөөлөгдөж байсан 31 иргэн эрүүлжиж цэргийн албанд татагдсан. 2017 оны нэг, хоёрдугаар ээлжээр татагдан цэргийн албаа хааж халагдаж ирсэн иргэдийг хүлээн авах өдөрлөгийг 05 дугаар сарын 01, 02. 10 дугаар сарын 15,16-ний өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллав.</p> <p>Нийт халагдсан иргэдийг хүлээн авч 94.8 хувь нь хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс хөдөлмөр зуучлал, мэргэжлийн сургалтын талаарх мэдээллийг 160 иргэнд өгч Жигүүр гранд групп, Сод монгол групп, Эко констракшин ХХК, Буян ХХК, Номин холдинг ХХК, Арвайн үндэс ХХК, Юниссервис ХХК, Хүчит зам ХХК, Финпак ХХК, Сод тэнгэр түшээ ХХК, зэрэг байгууллагуудын нээлттэй зарласан 141 сул ажлын байрыг танилцуулсан.</p> <p>Байнгын ажлын байранд 21, сургуульд 31, мэргэжил олгох болон давтан сургалтад 40, эд материалын тусламж 21, бусад халамж үйлчилгээг 6 дайчдад хүргэлээ.</p> <p>2017 оны хоёрдугаар ээлжээр цэргийн жинхэнэ албанд явсан иргэдийн ар гэрээс эрүүл мэндийн үзлэгт 51 иргэн, хувцас, эд материалын тусламжид 11, мөнгөн тусламжид 7 хүнд 1400000 төгрөг, түлээ, нүүрсний тусламжид 8, 2 хүнд гэр олгуулж, 48 иргэний бусад халамж үйлчилгээнд хамруулах ажлыг хороодтой хамтран зохион байгууллаа.</p> <p>Тус дүүргээс 2017-2018 онд цэргийн алба хаасан дайчдын 51,8 хувийг ажлын байраар зуучлан, мэргэжил олгох сургалт, эд материалын тусламж, бусад халамж үйлчилгээнд хамруулан, халагдан ирсэн дайчдын ар гэрийн 65,4 хувьд нь 7-8 төрлийн нийгмийн халамж үйлчилгээ үзүүлж ирсэн байна.</p>				
144	5.1.15	Архив албан хэрэг хөтлөлт, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг цаг тухай бүрд	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Цэргийн штабын архив албан хэргийн хөтлөлт сайжирч иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ цаг алдалгүй хүлээн авдаг болсон байна.	-	ЦШ	100%

			нь хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.						
			<p>Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны а/25 дугаар тушаалаар мэдээллийн аюулгүй байдлын офицер, ахмад Э.Батсүрэн нь Архивын ерөнхий газарт зохион байгуулагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй” сэдэвт сургалтад 2018 оны 04 дүгээр сарын 02-15-ний өдрүүдэд хамрагдсан.</p> <p>Цэргийн штабын 2018 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нөхөн бүрдүүлэх төлөвлөгөө, архивын баримт хүлээн авах хуваарийн дагуу ажилтнуудаас 2018 онд хөтлөгдсөн баримт бичгүүдийг эмхэлж цэгцлэн, архивлуулж, 24 баримтыг хүлээн аваад байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу Цэргийн штабт ашиглагдаж байгаа компьютер, техник хэрэгсэлд 2018 оны 01 дүгээр сарын 16-17-ний өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын компьютерын завсар үйлчилгээ, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн болон мэдээллийн технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэн нартай хамтран үзлэгийг явуулж, гарсан зөрчлийг арилгасан</p>						
145	5.1.16		Нийслэл дүүргийн бүтээн байгуулалт, байгалийн гамшиг давагдашгүй хүчин зүйлийн хор хөнөөлийг арилгахад цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаагчдыг татан оролцуулах, Зэвсэгт хүчнээс томилгоот бүрэлдэхүүнийг оролцуулж иргэн цэргийн хамтын ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлнэ.	Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаагчдын анхан шатны болон үүрэг гүйцэтгэх үеийн гүнзгийрүүлсэн шатнуудын сургалт дадлагыг олгох сургалтыг зохион байгуулна.	Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаагчдын цэргийн хэргийн мэдлэг нэмэгдэж, үүрэг гүйцэтгэлтийн бэлтгэл хангагдсан байна.	-	ЦШ	100%	
			<p>Монгол улсын Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар бүлгийн 29 дүгээр зүйл Монгол улсын Засгийн газрын 2018 оны Журам батлах тухай 80 дугаар тогтоол, 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Тооны дээд хязгаар мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай 79 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг элсүүлэх тухай А/359 дүгээр захирамж дүүргийн Засаг даргын 2018 оны А/164 дүгээр захирамжаар 2016-2018 онд цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж хугацаа дууссан 4 алба хаагчийг халж баримт бичигт бичилтийг хийж олгосон. 2018 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын товчоогоор орж товчооны шийдвэрээр цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах хүсэлт гаргасан 8 иргэнээс шаардлага хангасан 6 иргэнийг элсүүлэн алба хаах гэрээг байгуулан ажиллаж байна.</p>						

			<p>Нийслэлийн Цэргийн штабын даргын 2018 оны А/09 дүгээр тушаалаар 2018 оны 05 дугаар сарын 16-наас 28-ны өдрүүдэд цэргийн анхан шатны бэлтгэлийг Зэвсэгт хүчний 350 дугаар ангид зохион байгуулахад төлөвлөлт сургалтын офицер хошууч И.Нямсүрэн ротын захирагчаар, шуурхай байдлын ахлагч, жолооч ахлах ахлагч Э.Төмөрчулуун салааны захирагчаар үүрэг гүйцэтгэсэн.</p> <p>Цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүй иргэдэд Цэргийн албаны тухай хуульд заагдсан дагуу мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэх хаалгах ажлыг хэрэгжүүлснээр 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар нийт 173 иргэний 100.7 сая төгрөгийг нийслэлийн төрийн санд төвлөрүүлээд байна.</p>					
5.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.								
146	5.2.1	ЗГҮАХ-ийн 3.3.4 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 5.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, үүний дотор Старт ап бизнес компаниуд, инновацийн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулна.	Ажил, мэргэжилгүй залуучуудыг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Сургалтад хамрагдсан иргэд ажлын байранд 100% зуучлагдсан байна.	-	HXX, ХөХҮХ	100%
			<p>-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 42 мэргэжлийн чиглэлээр 70 сургалтын төв мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах эрхийг олгосны дагуу 2018 онд тус дүүргийн хэмжээнд үсчин, гоо сайхан, оёдол эсгүүр, тогооч, зэрэг мэргэжилүүдээр нийт 121 иргэн суралцсан.</p> <p>-Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системд бүртгэлтэй 1010 залууст ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтанд хамруулан ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Хугацаат цэргийн албан хаагч -200 -Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй -99 -Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч -340 -Их, дээд сургуулийн оюутан -440 -Ерөнхий боловсролын сургуулийн 2000 сурагч байна. <p>-Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системд бүртгэлтэй 293 ажил, мэргэжилгүй залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>-Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран "Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр"-ийн хүрээнд "Мэргэжлийн болон давтан сургалт"-нд дүүргийн ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй, ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч байгаа 117 иргэнийг хамруулав.</p> <p>-"Start up marketing space" байгууллагатай гэрээ залуучуудын гарааны бизнес хэрхэн эхлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх явц, санхүүгийн асуудлаа хэрхэн удирдах зэрэг асуудлаар сургалт хийж, 1-20 дугаар хорооны 67 залуучууд бүртгүүлэн 12 баг болон өрсөлдөж, хурдасгуурт шалгарсан 5 багтай гэрээ хийж санхүүжилт олголоо.</p>					
147	5.2.2		Хөгжлийн бэрхшээлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн өөрөө өөртөө ажлын байр бий	Олгох санхүүжилт, хувиар	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрөө өөртөө ажлын байр бий болгосон байна. 100%	-	HXX, ХөХҮХ	100%

		болгох санал, санаачилгыг дэмжих төсөл зарлан, шаардлагатай санхүүжилтийг зориулалтын дагуу олгоно.					
		<p>-Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн танилцуулга, зар мэдээллийг нийт 20 хорооны иргэдэд хүргэн ажиллалаа. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн дунд төсөл хөтөлбөрийн зарыг 2018 оны 05 дугаар сард 21 хоногийн турш зарлан, нийт 44 иргэний төсөл хүлээн авснаас 23 иргэний төсөл дэмжигдэж, нийт 87,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Арга хэмжээний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй 23 иргэн байнгын ажлын байртай болж, өрхийн орлого нэмэгдсэн. Санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдсан иргэдэд бизнесээ хэрхэн эхлэх, өргөжүүлэх, санхүүгийн тайлан, тооцоогоо хэрхэн хөтлөх талаарх сургалтыг зохион байгуулж, 23 иргэн хамрагдсан.</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 2 дахь удаагийн төсөл сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулахаар ХХҮХ-ийн цахим хуудас болон хороодын хөдөлмөр эрхлэлт, халамжийн мэргэжилтнээр дамжуулан иргэдэд зар хүргэн ажиллаж байна.</p>					
148	5.2.3	Дүүргийн шинэлэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэдийг илрүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлыг зохион байгуулна.	Сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч, хөтөлбөрт хамрагдсан байх.	Үйлдвэрлэх бараа бүтээгдэхүүний гарц өсөж, үйл ажиллагаа нь өргөжсөн байна.	-	ХХҮХ, ЖДҮДТ	100%
		<p>2018 оны 01 дүгээр сарын 18-наас 02 дугаар сарын 15-ны өдөр хүртэл зохион байгуулсан “Сүхбаатарт үйлдвэрлэв 2018” үзэсгэлэн худалдаанд 15 дугаар хорооны хүүхдийн боолт хавчаар хийдэг өрхийн үйлдвэрлэгч Б.Анхцэцэг, хүүхдийн хувцас үйлдвэрлэгч 13-р хорооны иргэн Н.Энхцэцэг нарыг үзэсгэлэн худалдаанд хамрууллаа.</p> <p>2018 оны 03 дугаар сарын 05-ны өдөр 13 дугаар хорооны эмульсний үйлдвэрлэл эрхлэх зорилготой иргэн П.Алтанхуягт зээл болон бизнес төлөвлөгөө боловсруулах ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.</p> <p>2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 3-р хорооны иргэн “Смок” загварын хагас ханцуйтай цамц үйлдвэрлэл эрхлэгч Х.Тулгыг хөнгөлөлттэй ажлын байрны түрээсийн үйлчилгээнд хамруулсан.</p> <p>Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвөөс 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний сургалтанд дүүргийн 38 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамрууллаа.</p> <p>2018 оны 05 дугаар сарын 07-29-ний өдрүүдэд ахмад мэргэжилтэн Б.Очирхуягийн нэхмэлийн талаарх сургалт, зөвлөгөөнд 2 иргэнийг хамруулан 40 цагийн сургалт зохион байгуулсан.</p>					

			<p>2018 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Сүхбаатар дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвөөс үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “MLC training” сургалтын төвтэй хамтран “худалдан авагчтай харилцан ойлголцлыг бий болгох, сонирхол төрүүлэх, шийдэл санал болгох, худалдан авах сэдэл төрүүлж, шийдвэр гаргуулах” зэрэг ур чадварыг эзэмшүүлэх онол, практик хосолсон “Мастер борлуулагч” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд дүүргийн 21 үйлдвэрлэл эрхлэгчдэд хамрагдаж борлуулалтын маркетингийн талаарх мэдээллийг олж авлаа.</p> <p>Үйлдвэрлэл эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажлын байрны хөнгөлөлт, бизнес инкубацын арга хэмжээ, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт зэрэг арга хэмжээ болон гарааны бизнесийн сургалт, зөвлөгөөнд оролцуулах, мэдээллээр хангаж зэрэг үйл ажиллагаанд 2017 онд 30, 2018 онд 43 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан байна.</p>					
149	5.2.4	НЗДҮАХ-ийн 4.7.3 дахь заалт; ДЗДҮАХ-ийн 5.2.2. Дүүргийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлуулах борлуулалтыг дэмжиж ажиллана.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн борлуулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор томоохон худалдааны төвүүдэд борлуулалтын цэг ажиллуулах арга хэмжээ зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдсэн байна. 100%	-	НХХ, ХөХҮХ	100%
			Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн “Борлуулалтын цэг ажиллуулах” арга хэмжээг хүрээнд зохион байгуулан ажиллалаа. Борлуулалтын цэг ажиллуулах, түрээсийн хөнгөлөлтийн арга хэмжээнд хамруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг ХХҮХ-ийн даргын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/25 тоот тушаалаар байгуулж, дүүргийн хэмжээнд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 16 иргэнийг ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд хамруулж, 7.653.520 төгрөгийн хөнгөлөлт олгож, 26 иргэнийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь борлуулахад нь дэмжлэг үзүүлэхээр Баянзүрх худалдааны төвтэй гэрээ байгуулан ажиллаж байна.					
150	5.2.5		Эрүүл баталгаатай төмс, хүнсний ногооны борлуулалтын сүлжээ цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, өрхийн тариалан эрхлэгчдийн болон хөдөө орон	/Өрхийн тариалан эрхлэгч-24 иргэн, ЖДҮ эрхлэгч-30 иргэн, нийт 54 иргэн/	Борлуулалтын хэмжээ нэмэгдэж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж ажлын байраар хангасан байна.	-	ХХҮХ	100%

			<p>нутгийн ногоог хямд үнээр дүүргийн иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна.</p>					
			<p>Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хүүхдийн урлан бүтээх төв, Эвт үйлчилгээний төв, Хан-Эрдэнэ худалдааны төв, Дарь эхийн 33-ын автобусны буудлын талбай дахь 4 борлуулалтын цэгт эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ худалдаалах чиглэлээр хамтран ажиллах гэрээг 9 иргэн, 1 ААН-тай байгуулж, хөдөө орон нутгийн ногоочдын болон дүүргийн өрхийн тариаланчдын тарьж ургуулсан ногоог иргэдэд шууд хүргэж, хүн амын хүнсний хэрэгцээнд эдгээр төвлөрсөн худалдааны цэгүүдээр 94,2 тн төмс, 25,0 тн лууван, 13,85 тн манжин, 24,45 тн сонгино, 38,4 тн байцаа, 16,23 тн нарийн ногоо, 30,58 тн тарвас, нийт 242,71 тн ногоо борлуулсан нь өмнөх оныхтой харьцуулахад 70,0-80,0 тонноор нэмэгдсэн байна.</p> <p>Өрхийн тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, үндэсний үйлдвэрлэгчид, тариаланчдын шилдэг бараа бүтээгдэхүүн, шинэ ургацын дээжийг хэрэглэгч түмэнд хүргэх зорилгоор Мишээл экспо төвд “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриан дор зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний хүнсний бүтээгдэхүүн, шинэ ургацын “Алтан намар” өргөтгөсөн худалдаанд дүүргийн өрхийн тариалан эрхлэгч Ж.Наранцэцэг оролцож, 12 нэр төрлийн 700 ш нөөшилсэн бүтээгдэхүүн, 7 нэр төрлийн 500 орчим кг төмс, хүнсний ногооны борлуулалт хийсэн.</p> <p>Мөн АДРА-Монгол ОУБ-ын Тогтвортой тариалан төсөлтэй хамтран 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Барилгачдын талбай дээр “Ургацын баяр-2018” нэгдсэн арга хэмжээнүүдэд дүүргийн өрхийн тариаланчдын төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний борлуулалтыг дэмжин, дундын зуучлалгүйгээр шууд худалдан борлуулах нөхцөл бололцоог олгож, ургацын баярт дүүргийн 5 өрхийн өөртөө туслах бүлгийн гишүүд идэвхтэй оролцож, 1,2 тонн төмс, хүнсний ногоо, 200 гаруй шил даршилсан ногооны борлуулалт хийж, шинэ ногооны салат, ногооны болон жимсний чанамал, амтат жимсээр өдөрлөгт оролцсон иргэдийг дайллаа.</p> <p>Өрхийн тариалан эрхлэгчдийг ЖДҮ-ийн бизнесийн салбарын зах зээлд гаргах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор АДРА-Монгол Олон улсын байгууллагаас “Хатаасан ногоо”, “Чийгийн улааны бордоо”, “Эсгий шаахай” төслүүдийг хэрэгжүүлж, бүлгийн гишүүдийн хийсэн бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгууллаа.</p> <p>Мөн АСА циркийн арын талбайд хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг ХХААХҮЯ, НХХААГ, Хүнсний ногоо эрхлэгчдийн холбоотой хамтран 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулж, Дархан, Сэлэнгийн ногоочдыг ажлын байраар хангаж, нийт 8,02 тн төмс, хүнсний ногоо, 1200 шил нөөшилсэн бүтээгдэхүүн, 400 шил зөгийн бал, 10-12 нэр төрлийн эмийн ургамал зарж, борлуулсан байна.</p> <p>Дүүргийн хэмжээнд 2018 онд өргөтгөсөн худалдаа болон борлуулалтын цэгүүдээр худалдаалагдсан төмс, хүнсний ногооны борлуулалтын тоон мэдээллийг авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> • Төмс-95,9 тонн 					

			<ul style="list-style-type: none"> • Хүнсний ногоо-156,53 тонн • Шийгуа-33,6 тонн • Нөөшилсөн бүтээгдэхүүн-4660 шил • Зөгийн бал-400 шил тус тус борлуулагдсан нь өмнөх онтой харьцуулахад нийт 48.7 тонн буюу 20 %-иар өссөн үзүүлэлттэй байна.
151	5.2.6	<p>Нийслэл болон дүүргээс зохион байгуулж буй үзэсгэлэн худалдаанд дүүргийн үйлдвэрлэгчдийг хамруулна.</p> <p>Үзэсгэлэн худалдаанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн тоо,</p> <p>Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч болон өрхийн үйлдвэрлэгчдийн борлуулалт өссөн байна.</p> <p>-</p> <p>ХХҮХ, ЖДҮДТ</p> <p>100%</p>	<p>Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэгчдийг дараах үзэсгэлэн худалдаануудад оролцуулж, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажиллалаа. Үүнд:</p> <p>1. Монголын уламжлалт Цагаан сарыг угтаж дүүргийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/03 дугаар тоот “Цагаан сар -2018, Сүхбаатарт үйлдвэрлэв” өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай захирамж, дүүргийн Засаг даргын Тамыгн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/03 дугаар тоот тушаалаар 2.185.000 төгрөгийг шийдвэрлүүлэн 7 дугаар хорооны нутаг дэвсгэр 11 дүгээр хороолол, Саруул хотхоны Дөрвөн- Уул худалдааны төвийн 2 давхарт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 30 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнээ сурталчлан оролцлоо.</p> <p>Үзэсгэлэн худалдаанд Үндэсний дээл хувцас, шүрэн урлал, модон эдлэл, эсгий урлал, жааз бэлэг дурсгал, ноосон эдлэл, арьсан цүнх бүс тэлээ, Хүүхдийн хувцас, хүүхдийн буриад гутал, Хүүхдийн ном хэвлэл, Тод оймс, Дэгжин ретүз, Хүүгийн гутал, Архангай аймгийн ааруул цагаан идээ, хэвийн боов, Сэлэнгийн зөгийн бал, Барагшун гэх мэт 30 -аад нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдаалагдлаа. Мөн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвөөс цагаан сард зориулсан сав баглаа боодол бүхий Монголдоо, Монголжингоо бэлгийг үйлдвэрийн үнээр худалдааллаа.</p> <p>2. Бэлх худалдааны төв, Улаанбаатар их дэлгүүр, АСА цирк, “Мишээл-Экспо, UB palace, Скай их дэлгүүр зэрэг томоохон худалдааны төвүүдэд нийт 130 гаруй аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулсан.</p> <p>3. “Улаанбаатарт үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаа 2018 оны 04 дүгээр сарын 06-09-ны өдрүүдэд Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдсан. Үзэсгэлэн худалдаанд дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгч 13 иргэн ноос ноолуур, хүүхдийн хувцас, гоёл чимэглэл, гар урлал, “И-Отто-Күзин” ХХК-ийн Зөгийн бал, “Цэвэр Монгол” ХХК- ийн цэвэр ус, “Гэ-БЭ ЗЭ БЭ” ХХК-ийн Арьс ширэн эдлэл, Лаа-Ферма Гоо сайхны бүтээгдэхүүн, бэлэг дурсгал, Дүүрэн буудай хоршоо, Морин хуур, Монгол гутал зэрэг бүтээгдэхүүнүүдээ сурталчлан оролцсон болно.</p> <p>4. 2018 оны 07-р сарын 11-12-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдсан Наадмын үзэсгэлэн худалдаанд дүүргийн 8 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамрууллаа.</p>

			<p>5. 2018 оны 08 дугаар сарын 4,5-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Даншиг наадам-Хүрээ цам-2018” шашин соёлын наадмын хүрээнд Сүхбаатар дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн худалдааны цэг болон 5 үйлдвэрлэл эрхлэгчийн 12 нэр төрлийн 100 гаруй бараа бүтээгдэхүүнээр оролцлоо.</p> <p>6. 2018 оны 08 дугаар сарын 31-ны өдрөөс 09 дүгээр сарын 02-ны өдрүүдэд “Мишээл Экспо” төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдсан “Улаанбаатарт үйлдвэрлэв-2018” худалдаанд дүүргийн 3 үйлдвэрлэл эрхлэгч оёмол бүтээгдэхүүн, гоёл чимэглэл гар урлалын төрлөөр өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээрээ оролцлоо.</p> <p>7. 2018 оны 10 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, зах зээлд таниулан сурталчлах зорилгоор “Мишээл Экспо” төвд зохион байгуулагдсан “Улаанбаатарт үйлдвэрлэв-2018” үзэсгэлэн худалдаанд дүүргийн “Дүүрэн буудай хоршоо”- үндэсний хувцас, эсгий эдлэл, “Тод оймс” ХХК -төрөл бүрийн оймс, “Милаан херо брэнд” фудволк, “Саян брэнд”-эсгий эдлэл, “Шинэ сүлжээ” ХХК - ноолууран бүтээгдэхүүн, “Миний таны гоёл” ХХК- чулуун ээмэг, бөгж, бугуйвч, зүүлт зэрэг өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр оролцлоо.</p> <p>2017 онд 10 удаагийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 190 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн үйлдвэрлэсэн үндэсний хувцас, арьс, арьсан эдлэл, бэлэг дурсгал зэрэг 40 нэр төрлийн 800 гаруй бүтээгдэхүүнээр оролцож 60 гаруй сая төгрөгийн борлуулалт хийж ажилласан бөгөөд 2018 онд 11 удаагийн үзэсгэлэн худалдаагаар 78 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, аж ахуйн нэгж байгууллагууд үндэсний дээл хувцас, шүрэн урлал, модон эдлэл, эсгий урлал, жааз бэлэг дурсгал, ноосон эдлэл, арьсан цүнх бүс тэлээ, хүүхдийн хувцас, хүүхдийн буриад гутал, зэрэг 85 нэр төрлийн 1200 гаруй бараа бүтээгдэхүүнээр оролцож, 80 орчим сая төгрөгийн борлуулалт хийж, өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ сурталчлан, харилцан туршлага солилцож ажилласан байна.</p>					
152	5.2.7	ДЗДҮАХ-ийн 5.2.3. Зорилтот бүлгийн иргэн, нөхөрлөл, хоршоодыг бизнес инкубацийн арга хэмжээнд хамруулна.	Зорилтот бүлгийн шаардлага хангасан иргэдийг үйлдвэрлэл, үйлчилгээний түрээсийн хөнгөлөлтийн арга хэмжээнд хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Түрээсийн хөнгөлөлтөд хамрагдах иргэдийн тоо нэмэгдсэн байна. 100%	-	НХХ, ХөХҮХ, ЖДҮДТ	100%
			<p>-Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн “Түрээсийн хөнгөлөлтөд хамруулах” арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа. 2017, 2018 онуудад эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, ажлын байр нэмэгдүүлэх жижиг зээлд хамрагдсан иргэдээс сүүлийн 12 сарын хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ажлын байр түрээслэн, үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг арга хэмжээнд хамруулахаар ХХҮХ-ийн даргын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/25 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажилласан.</p> <p>-2017, 2018 онуудад ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдээс бүтээгдэхүүнээ борлуулах хүсэлтэй иргэдээс шалгаруулан дараах ажлын байрны түрээсийн хөнгөлөлт олгосон. Үүнд:</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1 иргэнд түрээсийн хөнгөлөлт 480.000 төгрөг,</p>					

			-Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 22 иргэнд, 7,800,000 төгрөгийн түрээсийн хөнгөлөлт олгосон байна. Дээрх 23 иргэдэд түрээсийн хөнгөлөлт олгосноор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэж, эерэг үзүүлэлт гарсан.				
153	5.2.8	Зорилтот бүлгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнесийг дэмжих, тэдгээрийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, үзэсгэлэн худалдаанд оролцуулж, бизнес инкубатор төвүүдийн үйл ажиллагаатай бизнес эрхлэгчдийг танилцуулна.	Зорилтот бүлгийн нөхөрлөл, хоршоодын бизнес эрхлэгч 100 иргэнийг хамруулна.	Нөхөрлөл хоршоодын үйл ажиллагаа тогтворжиж бие даасан шинжтэй болсон байна.	-	ХХҮХ	100%
		<p>1. “Монголын Үндэсний Их Сургуулиас “ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан гарааны бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг дэмжих сурталчлах зорилгоор “Энтрепренёр эвент” арга хэмжээнд Сүхбаатар дүүргээс, Ноос, ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүүхдийн хувцас , эсгий урлал, оёдлын үйлдвэрлэл эрхлэгч 4 эмэгтэй өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ арга хэмжээний үеэр зөвлөгөөнд оролцогчдод танилцуулсан.</p> <p>Монголын Үндэсний Их Сургуулиас цаашид бизнес эрхлэгч 4 үйлдвэрлэгчдэд бизнесээ хэрхэн өргөжүүлэх, хөрөнгө оруулагч олоход туслах, бизнесийн зөвлөх үйлчилгээг үзүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар шийдвэрлэлээ.</p> <p>2. Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэмжих төвийн үйлдвэрлэл эрхлэгчдээс шаардлага хангасан 13 дугаар хорооны хүүхдийн гутлын үйлдвэр эрхлэгч н.Алтанцэцэгийг үйлчилгээний түрээсийн хөнгөлөлтийн арга хэмжээнд хамруулан ажиллалаа.</p> <p>3. 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр 17-р хорооны иргэн, оёдлын чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгч Л.Доламжавыг ажлын байрны хөнгөлөлтөнд хамруулсан.</p> <p>4. 15-р хорооны 85 настай ахмад үйлдвэрлэл эрхлэгч Ц.Баасанг 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн ажлын байрны түрээсийн хөнгөлөлттэй үйлчилгээнд /инкубаци/ хамруулсан.</p> <p>Зорилтот бүлгийн иргэн, нөхөрлөл, хоршоодыг бизнес инкубацийн арга хэмжээнд хамруулах ажлын хүрээнд 2017, 2018 онуудад бизнес инкубацийн арга хэмжээ, гарааны бизнесийн сургалт, зөвлөгөөн, үйлчилгээний түрээсийн хөнгөлөлт зэрэг чиглэлээр нийт 30 гаруй ажил зохион байгуулж 120 гаруй жижиг, дунд үйлдвэрлэгч болон зорилтот бүлгийн иргэн, нөхөрлөлийг хамруулан ажиллалаа.</p> <p>Уг бизнес икубацийн арга хэмжээг хэрэгжүүлснээр бизнесээ хэрхэн өргөжүүлэх, хөрөнгө оруулагч олоход дэмжлэг авах, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөнд хамрагдах, бизнесийн зөвлөх үйлчилгээг авах зэрэг үйлчилгээг авах боломжтой болсон бөгөөд түрээсийн хөнгөлөлтийн үйлчилгээнд 10 иргэн хамрагдсан байна.</p>					

154	5.2.9	ДЗДҮАХ-ийн 5.2.4 дахь заалт, Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийг түшиглэн жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт судалгаа мэдээллийн төвийг байгуулна.	Жижиг дунд үйлдвэрлэгч болон өрхийн үйлдвэрлэгч нарын бүртгэл, мэдээллийг эмхэтгэн бүртгэлийг санг шинэчлэн сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Бүртгэлийн санг шинэчилсэн байна.	-	ХХҮХ, ЖДҮДТ	100%
			<p>1. Дүүргийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/157 тоот захирамжаар Үйлдвэрийн тооллого, судалгаа хийх ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>Аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн санд аж ахуй нэгжүүдийг бүртгэх ажлын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн татварын газраас ирүүлсэн дүүргийн хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд татвар төлсөн, “С” ангиллын буюу боловсруулах үйлдвэрт хамаарах аж ахуй нэгжийн хяналтын тоо буюу нийт 474 аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг хянан үзэж, бүртгүүлэх шаардлагатай ААНБ-ын тоог тодруулахаар шийдвэрлэлээ. - Сүхбаатар дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудыг цахим мэдээллийн санд www.industry4.nda.gov.mn хаягаар орж хэрхэн бүртгүүлэх тухай мэдээллийг дүүргийн http://sbd.gov.mn/ цахим хаяг болон дүүргийн /Нээлттэй Сүхбаатар дүүрэг/ facebook хаягуудад байршуулж, 1-20 дугаар хороодын Ажлын алба болон холбогдох бусад хэлтсүүдээр дамжуулан түгээн ажиллаж байна. - Нийслэлийн үйлдвэрлэл, инновацийн газраас 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хуваарилсан Аж үйлдвэрийн тооллогын талаарх 20ш А3 хэмжээтэй зурагт хуудсыг хүлээн авч 20 хорооны ажлын албаны мэдээллийн самбарт байршуулсан. Мөн 1ш сурталчилгааны самбарыг дүүргийн Татварын хэлтсийн нэг цонхны үйлчилгээний хэсэгт байршуулан мэдээллийг түгээж байна. - Ажлын хэсэг 2018 оны 01 дүгээр сарын 16, 02 дугаар сарын 06, 21-ны өдрүүдэд хуралдаж, мэдээллийн санд бүртгэх ажлын явц, бүртгэлийн явцад тулгамдаж буй асуудлууд, хэрхэн шийдвэрлэх арга зам болон бүртгэх ААНБ-ын тоог эцэслэн шийдвэрлэсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 8/754 тоот албан бичгээр мэдээллийн санд бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн дүн мэдээг Нийслэлийн үйлдвэрлэл, инновацийн газарт хүргүүлэн ажиллалаа. <p>2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас жижиг, дунд үйлдвэрийн бодлогын нөлөөллийг судлах, шинэчлэх зорилгоор зохион байгуулсан “Жижиг дунд үйлдвэрийн ажиглалт судалгаа” –ны ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 110 аж ахуйн нэгж байгууллагаас судалгааг авч мэдээллийн санд шивж оруулан kanadzen@gmail.com хаягаар хүргүүлэн ажиллалаа. Цуглуулсан судалгааны мэдээлэлд үндэслэн судалгааны тайлан хэвлэгдэн гарсан ба уг тайлангаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүү, зээл, үйл ажиллагаа, төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг олж авах боломжтой болсон байна.</p>					
155	5.2.10		Сургалт судалгаа мэдээллийн төвийн тохижилтын ажлыг эхлүүлнэ.	2-3 иргэн үйлчлүүлэх боломжтой байна.	Иргэд үйлчлүүлэхэд тав тухтай болсон байна.	-	ХХҮХ, ЖДҮДТ	70%

			<p>2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн дүүргийн Засаг даргын А/185 дугаар захирамжийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид ая тухтай орчинд үйлчилгээг хүргэх зорилгоор “Сургалт, судалгаа, мэдээллийн төв”-ийг тохижуулж, үйлдвэрлэл эрхлэгч нарыг ая тухтай орчинд үйлчилгээ авах нөхцлөөр хангаад байна. Одоогийн байдлаар сургалт мэдээллийн төвийн өрөөний тохижилтын ажлыг хийж дуусгасан бөгөөд цаашид үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Сургалт мэдээллийн төвийг бүрэн ашиглалтанд оруулснаар төвөөр дамжуулан өрхийн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг мэдээ, мэдээллээр хангаж зөвлөгөө өгөх, бизнес төсөл боловсруулах, мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулах, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах зэрэг нөхцөл бүрдэнэ.</p>					
156	5.2.11	<p>ДЗДҮАХ-ийн 5.2.5 дахь заалт, Дүүргийн жижиг дунд үйлдвэр, бичил бизнес, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллана.</p>	<p>Монгол улсын Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин олгож буй зээлийн талаарх мэдээллийг олон нийтэд гарын авлага хэвлүүлэн, сурталчлан түгээж, бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.</p>	<p>Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 300 иргэнд гарын авлага хэвлүүлэн сурталчилна.</p>	<p>Үйлдвэрлэл эрхлэгчид хууль эрх зүй, эдийн засгийн мэдлэг мэдээлэлтэй болсон байна.</p>	-	ХХҮХ	100%
			<p>2018 оын 03 дугаар сарын 16-ны өдөр Монгол улсын Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооны хөгжлийн талаар төрөөс баримталж буй бодлого, бизнес эрхлэгчдийг дэмжин олгож буй зээл, төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл олгох зорилгоор зохион байгуулсан сургалтанд оролцогсдод дараах сурталчилгааны материал, гарын авлагуудыг тараалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Зээлийн батлан даалтын сангийн танилцуулга • Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн танилцуулга • Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Ажлын байрыг дэмжих хөтөлбөр • Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр зэрэг нийт 110 гаруй гарын авлагыг иргэдэд хүргэлээ. <p>Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гарын авлагаар хангах тухай А/365 тоот захирамжаар 300 ширхэг гарын авлагын материалыг хэвлүүлэхэд шаардагдах 450.000 төгрөгийг шийдвэрлүүлэн ажиллалаа. Энэхүү гарын авлагад Монгол улсын Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин олгож буй зээл, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомжийн талаарх мэдээлэл багтсан бөгөөд дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн сургалтын төвөөр дамжуулан өрхийн үйлдвэрлэгчдийг мэдээллээр хангахаар төлөвлөн ажиллаж байна.</p>					

157	5.2.12		Зээлийн батлан даалтын сантай хамтран сургалт зохион байгуулна.	Үйлдвэрлэгчид Зээлийн батлан даалтын сангийн тухай мэдлэг, мэдээлэлтэй болно.	Сургалт зохион байгуулсан байна.	-	ХХҮХ, ЖДҮДТ	100%
			<p>ХХААХҮЯ, Зээлийн батлан даалтын сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнес эрхлэгч нарт Монгол улсын Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооны хөгжлийн талаар төрөөс баримталж буй бодлого, бизнес эрхлэгчдийг дэмжин олгож буй зээл, төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл олгох зорилгоор 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын 9 давхрын хурлын танхимд дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулан сургалт зохион байгууллаа. Сургалтанд 1-20 дугаар хорооны 62, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвөөс 31 жижиг, дунд бизнес эрхлэгчид хамрагдлаа.</p> <p>2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудад Зээлийн батлан даалтын сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран бизнес эрхлэгчдийг дэмжин олгож буй зээл, төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 20 гаруй аж ахуйн нэгж хамрагдлаа.</p> <p>Зээлийн батлан даалтын сангаас зээл авахаар материалаа бүрдүүлж буй 16 дугаар хорооны бууз баншны үйлдвэрлэгч “Очирваань сүлд уул” ХХК, 10 дугаар хорооны хэвлэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн М.Мергенбай нарт жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн тодорхойлолтыг Зээлийн батлан даалтын санд гарган өгч, дэмжин ажиллалаа.</p> <p>Зээлийн батлан даалтын санд 2017 онд дүүргийн 10 үйлдвэрлэл эрхлэгч хандаж 5 үйлдвэрлэл эрхлэгч батлан даалтын сангаас 2 сая төгрөгийн зээл авсан бол 2018 онд 39 үйлдвэрлэл эрхлэгч хүсэлт гаргаснаас 12 үйлдвэрлэл эрхлэгчид 3 сая төгрөгийн зээл тусламжинд хамрагдсан байна.</p>					
158	5.2.13	ДЗДҮАХ-ийн 5.2.6 дахь заалт, Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтран ажиллах, гадаад болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг	Халуун усны үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд аттестатчилал явуулж, стандартын шаардлага хангуулан ажиллана.	20 халуун усны газарт хяналт шалгалт явуулна.	Иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ бий болсон байна.	-	ХХҮХ	100%
			<p>Нийслэлийн “Хүн амын ахуйн үйлчилгээ-2020” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд халуун усны үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг шалгаж, зөрчлийг арилгуулах, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг ханган ажиллах талаар мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэхэд зорилгоор</p>					

		дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ.	халуун усны чиглэлээр үйлчилгээ явуулж буй 20 иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Хороодын Ажлын албатай хамтран хяналт, шалгалт явуулж, Эрүүл ахуйн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах нийтлэг журам, Халуун усны үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 5163:2002 стандартын хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн 5 аж ахуйн нэгж, иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 550,0 мянган төгрөгний торгууль оногдуулж, 5 албан даалгавар, 7 зөвлөмж өгч, зөрчлийг арилгуулан, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажилласнаар халуун усны газруудын стандарт, эрүүл ахуйн шаардлага хангагдаж, үйлчилгээ эрхлэгчдийн сэтгэл ханамжийн баталгаа дээшилсэн.				
159	5.2.14	Бизнесийн болон мэргэжлийн чадавхжуулах төрөлжүүлсэн сургалтыг мэргэжлийн багш, зөвлөхтэй хамтран зохион байгуулна.	Сургалтын тоо нэмэгдэнэ.	Үйлдвэрлэгчдийн чадвар, бүтээгдэхүүний төрөл, борлуулалт нэмэгдсэн байна.	-	ХХҮХ, ЖДҮДТ	100%
<p>1. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвөөс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Сошиал медиа маркетинг” сэдэвт сургалтанд 5 үйлдвэрлэгч бүхий Эсгий урлал, Үндэсний хувцас, Тэмээний ноосон нэхмэл бүтээгдэхүүн, Тавилгын үйлдвэрлэлийн бизнес эмэгтэйчүүдийг хамрууллаа. Уг сургалтаар сошиал медиа орчинд бараа бүтээгдэхүүнээ хэрхэн сурталчлах, сурталчилгааг хэрхэн байршуулах зэрэг сэдвүүдээр мэдээлэл олголоо.</p> <p>2. Оёдлын салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, үйлдвэрлэлээ өргөжүүлэх талаар харилцан туршлага солилцуулах, үндэсний томоохон жишиг үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өрхийн үйлдвэрлэгчид, болон дүүргийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвд бойжиж буй үйлдвэрлэгчдийг хамруулан 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвтэй хамтран Оёдлын салбарын бизнес уулзалт, аяллыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын 9 давхрын хурлын танхим болон Төв аймагт байрлах “Төмөр трейд” ХХК-ийн үйлдвэрийн байранд сургалт аяллыг зохион байгууллаа. Бизнес уулзалтанд “Монгол Бид Үйлдвэрлэв” ТББ-ийн тэргүүн, Exclusive Mongolian Brand-ийн захирал Г.Майцэцэг идэвхжүүлэх сургалт хийж, 8 үйлдвэрлэгчтэй хамтран ажиллахаар болсон. Мөн “Төмөр трейд” ХХК-ийн үйлдвэрийн байртай танилах аялалд оёдлын үйлдвэрлэл эрхлэгч 47 иргэн хамрагдлаа.</p> <p>3. 2018 оны 05 дугаар сарын 07-30-ны өдрүүдэд оёдол, эсгүүр, дизайны сургалт зохион байгуулсан. Сургалтанд 9, 13, 14, 17,18, 20 дугаар хороодын иргэд хамрагдсан ба нийт 10 иргэн суралцсан. Энэхүү сургалтаар суралцагчид нийт 22 загварын загварын дээл, даашинз хийж амжилттай төгссөн.</p> <p>4. 2018 оны 10 дугаар сарын 01-19-ний өдрүүдэд төсөл бичих ур чадвар олгох анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 30 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, иргэн хамрагдаж төсөл бичих анхан шатны мэдлэгийг олж авлаа.</p> <p>5. 2018 оны 10 дугаар сарын 03-23-ны өдрүүдэд “Очир заяа урлан” НҮТББ-тай хамтран “Оёдол, эсгүүрийн анхан шатны чадвар эзэмших” 15 хоногийн сургалт зохион байгуулав. Сургалтад 16 үйлдвэрлэл эрхлэгчид хамрагдан оёдол эсгүүрийн анхан шатны мэдлэгийг олж авсан..</p>							

		<p>Сургалтын явцад бусдыгаа манлайлан суралцаж пиджак, юбканы хослол урлан амжилттай төгссөн Л.Баттөмөрт дараагийн шатны сургалтад суралцах эрхийн бичиг гардуулав.</p> <p>6. 10 дугаар сарын 08-ны өдөр Сүхбаатар дүүргийн Улаан загалмайн хорооны эрүүл мэндийн яаралтай анхны тусламжийн үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар 4С-ийн зарчим, анхны тусламжийн боолтыг хэрхэн зөв хийх, гэмтсэн болон бэртсэн тохиолдолд түргэн тусламж иртэл бид юун дээр анхаарах талаар практик хосолсон өргөн мэдлэгтэй олгосон сургалт байв. Сургалтад төвийн 30 үйлдвэрлэл эрхлэгч хамрагдав.</p> <p>7. 12 дугаар сард гар урлалын чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний төрөл нэмэгдүүлэх зорилгоор сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>8. ЖДҮДТ-тэй хамтран 2017 онд нийт 14 сургалтыг зохион байгуулж 170 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид хамрагдаж, төсөл бичих арга зүй, мэргэжлийн болон бизнесийн зөвлөх үйлчилгээ, сошиал медиа маркетинг зэрэг сэдвүүдээр мэдээллийг авсан байна. Харин 2018 онд 20 удаагийн оёдол эсгүүр хийх, борлуулалтын сувгаа хэрхэн сайжруулах маркетинг зэрэг сэдэвт онолын болон практикийн сургалтуудад нийт 263 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид хамрагдсан байна.</p>					
160	5.2.15	Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий иргэдэд төлөвлөлт, төсөл боловсруулах, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмших, зах зээлийн өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2 удаагийн сургалт зохион байгуулж, салбарын 100 бизнес эрхлэгчийг хамруулсан байна.	-	ХХҮХ	100%
		<p>1. Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний салбарт ажиллаж буй бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран “Бүтээлч маркетинг” сургалтанд салбарын 30 бизнес эрхлэгчдийг хамруулсан. Сургалтыг JICA Сайн дурын зөвлөх, IKEA брэндийн Япон дахь салбарын худалдааны мэргэжилтэн Араки Шино, Хөгжлийн Шийдэл ТББ-н сургалтын баг удирдан явуулж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээн дээр тулгуурласан маркетинг нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд ухаалаг байдлаар таниулахаас гадна борлуулалтын өсөлттэй шууд холбогдох байдлаар төлөвлөх нь зардал хэмнэх, хэрэглэгчийн сонголтыг хөнгөвчлөх оновчтой загварчлалын талаар онолын болон практикт суурилсан мэдлэгийг олгож, сургалтаар олж авсан мэдлэгээ шууд ашиглах боломжийг олголоо.</p> <p>2. Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Халдварт өвчин судлалын Үндэсний төв, Сүхбаатар дүүргийн Сэтгэл амар төвтэй хамтран саун, массажны үйлчилгээ эрхлэгч 30 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдэд нөлөөллийн уулзалт зохион байгуулж, салбарын холбогдох хууль тогтоомж, нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам, Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2010 стандартын</p>					

			<p>хэрэгжилтийг хангах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг оролцоог идэвхжүүлэх сургалт явуулж, 2017 онд хийсэн хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, цаашид үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр хэрхэн ажиллах талаар мэргэжлийн заавар зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.</p> <p>3. Мөн Эрүүл мэндийн яам, УБЗАА, Гал голомт Үндэсний хөдөлгөөн ТББ-тай хамтран 2018-2020 онд Глобал сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “ДОХ-той тэмцэх, сэргийлэхэд бүх түвшний шийдвэр гаргагчид болон салбар дундын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааны төсөл”-ийн хүрээнд дүүргийн одны зэрэглэлтэй зочид буудлуудын дэргэдэх 15 саун, массажны үйлчилгээний газруудын менежерүүдэд сургалт зохион байгуулж, үйлчилгээний чанар, стандарт, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудын заавар, зөвлөгөө өгч, мэдээллээр ханган ажиллалаа.</p> <p>4. Хүн амын ахуйн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, салбарын ажиллагсдын мэргэжлийн ур чадвар, хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт саун, массаж, халуун усны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдэд шинээр мөрдөгдөж буй салбарын хууль тогтоомж, үйлчилгээний стандарт, эрүүл ахуйн норм, дүрмийг сурталчлан танилцуулах сургалтыг Стандарт, хэмжил зүйн газрын бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулж, салбарын 80 гаруй хүнийг хамруулсан.</p> <p>5. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Улаанбаатар хотын ЗАА, Мэргэжлийн холбоодын хамтран зохион байгуулсан “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэлэлцүүлэгт дүүргийн ахуйн үйлчилгээний салбарын 40 гаруй төлөөллийг оролцуулан, холбогдох санал өгсөн.</p> <p>Тайлангийн хугацаанд ахуйн үйлчилгээний салбарт ажиллаж байгаа нийт 200 гаруй ажилтнуудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран төрөл бүрийн сургалт явуулж, мэргэжлийн ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлсэн нь үйлчилгээний чанар дээшилж, үйлчлүүлэгчдийн сэтгэлд хүрсэн үйлчилгээ бий болоход түлхэц болсон.</p>						
161	5.2.16		<table border="1"> <tr> <td data-bbox="734 1002 1070 1246">"Үсчин, гоо засалчдын аварга" шалгаруулах уралдаант тэмцээн зохион байгуулна.</td> <td data-bbox="1070 1002 1301 1246">Салбарын залуу боловсон хүчний дунд уралдаан тэмцээн зохион байгуулж, ур чадварыг дээшлүүлнэ.</td> <td data-bbox="1301 1002 1637 1246">Мэргэжлийн ур чадвар дээшилж, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох чадвартай болсон байна.</td> <td data-bbox="1637 1002 1816 1246">-</td> <td data-bbox="1816 1002 1973 1246">ХХҮХ</td> <td data-bbox="1973 1002 2089 1246">100%</td> </tr> </table> <p>“Хүн амын ахуйн үйлчилгээ-2020” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын ажиллагсдыг дэмжих, дүүргийн үсчин, гоо засалч, хумс засалчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, орчин үеийн чиг хандлагыг тодорхойлох, шинэ арга техник, технологиос харилцан суралцах, туршлага солилцох, өвөрмөц урсгалуудыг үсчин, гоо сайхны үйлчилгээнд нэвтрүүлэх, Монгол Улсын аварга шалгаруулах “Үсчин, гоо засалч, хумс дизайн урлалын XXIV их наадам” болон 2018 оны 11 дүгээр сард зохион байгуулагдах Ази, Номхон далайн орнуудын олон улсын тэмцээн уралдаанд оролцох дүүргийн аварга үсчин, гоо засалчдыг</p>	"Үсчин, гоо засалчдын аварга" шалгаруулах уралдаант тэмцээн зохион байгуулна.	Салбарын залуу боловсон хүчний дунд уралдаан тэмцээн зохион байгуулж, ур чадварыг дээшлүүлнэ.	Мэргэжлийн ур чадвар дээшилж, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох чадвартай болсон байна.	-	ХХҮХ	100%
"Үсчин, гоо засалчдын аварга" шалгаруулах уралдаант тэмцээн зохион байгуулна.	Салбарын залуу боловсон хүчний дунд уралдаан тэмцээн зохион байгуулж, ур чадварыг дээшлүүлнэ.	Мэргэжлийн ур чадвар дээшилж, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох чадвартай болсон байна.	-	ХХҮХ	100%				

			<p>шалгаруулах тэмцээнийг Монголын үсчин, гоо засалчдын холбоотой хамтран зохион байгуулж, Видал, Хос шагай, Сити сургууль, Үйлдвэрлэл урлалын Политехникийн коллеж, Мастер, Грийс, Лакме, Болор, Цоогий академи, Ангария, Руби, Charming, Маргад, Сөүл, Этура, Шварцкоф, Дистрой, Аура зэрэг 18 салоны мэргэжлийн 100 гаруй үсчин, гоо засалч, хумс дизайны урлалчид болон салбарын ажилтнууд, хөгжөөн дэмжигчид идэвхтэй оролцож, уг тэмцээнийг зохион байгуулах санхүүгийн асуудлыг дүүргийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрий А/276 дугаар захирамжаар 3,0 сая төгрөгийг Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргаж, санхүүжүүлсэн.</p> <p>Уралдаант тэмцээн үндсэн 8 төрөл, салбарын шоу үзүүлбэр, хумс урлалын бүтээлийн үзэсгэлэн зэрэг төрлүүдээр явагдаж, эхний 3 байр эзэлсэн оролцогчдыг, алт, мөнгө хүрэл медаль, дүүргийн Засаг даргын нэрэмжит Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулан, төрөл тус бүрт тэргүүн байр эзэлсэн үсчин, гоо засалчдыг Улсын аварга шалгаруулах уралдаанд оролцох эрх олголоо. “Дүүргийн Шилдэг үсчин”-ээр Хос шагай салоны үсчин Ө.Цацралтуяа, эрэгтэй шилдэг моделиор Ангария салоны О.Сүлдбаатар, эмэгтэй шилдэг моделиор Хос шагай салоны Э.Очирдулам тус тус шалгарч, алтан цом, мөнгөн шагналаар шагнагдлаа.</p> <p>Мөн гоо засалч, хумс засалчдын ажилбарыг өвөрмөц шийдэлтэй урлагийн бүтээл ба материал сонголт, өнгөний уусгалт, зохицол, будалтын болон зураглалын техник, моделийн сонголт, хувцаслалт чимэглэл зэрэг нь төрөлдөө зохицсон эсэхийг харгалзан оноо өгч, шалгаруулалтыг явуулж, үсчин, гоо засалч, хумс урлалын салбарт шинээр түрэн орж ирж байгаа залуу мэргэжлийн ажилчдад МУ-ын мастер үсчин, гоо засалчид мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч, өөрсдийн арвин туршлагаас хуваалцаж, тэмцээнд оролцогсод болон хөгжөөн дэмжигч, сонирхогчид харилцан туршлага солилцож, 2018 оны үс болон гоо сайхны чиг хандлага, өвөрмөц урсгалуудаас үзэж сонирхлоо.</p> <p>Салбарын хөгжил дэвшил, ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг олон нийтэд хүргэх зорилгоор уралдаант тэмцээнийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилж, Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллалаа.</p>				
162	5.2.17	<p>Дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж дотоод гадаадын үзэсгэлэн, яармаг худалдаанд хамруулж, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаанд 2-3 үйлдвэрлэл эрхлэгчийг оролцуулна.</p>	<p>Гадаад зах зээлд гаргах үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог нэмэгдүүлсэн байна.</p>	-	ХХҮХ, ЖДҮДТ	100%
			<p>Дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж гадаадын дараах үзэсгэлэн, яармаг худалдаанд хамруулж, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажиллалаа. Үүнд:</p> <p>1. 2018 оны 01 дүгээр сарын 12-оос 23-ны өдрүүдэд МҮХАҮТ, Эрээн хотын худалдааг дэмжих хорооны хамтран зохион байгуулсан “Эрээн хотын Цагаан сарын үзэсгэлэн худалдаа”-нд Сүхбаатар дүүргийн 10 үйлдвэрлэгч 4 төрлөөр оролцож 20 орчим сая төгрөгний борлуулалт хийсэн.</p>				

			<p>2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн борлуулалтыг дэмжих, гадаад зах зээлд сурталчлан таниулах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлөөлөл 10 үйлдвэрлэгчийг 2018 оны 6 дугаар сарын 22-оос 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Эрээн хотын 2 дахь удаагийн олон улсын үзэсгэлэнд 3 сая төгрөгийг шийдвэрлэн ажиллалаа. Үзэсгэлэн худалдаанд Р.Батнаран Б.Жаргал Ц.Дашзэвэг Д.Цэрэндулам нар Үндэсний хувцас, Н.Болормаа цүнх, арьсан эдлэл, Д.Отгонбаяр Ээмэг, зүүлт, гоёл чимэглэл, М.Булгантуул гутал, Ш.Галаа оёдол, бэлэг дурсгалын 28 нэр төрлийн 200 гаруй бараа бүтээгдэхүүнээр оролцож үндэсний өв соёлоо гадаадад сурталчлан оролцсон.</p> <p>3. 2018 оны 08 дугаар сарын 16-22 –ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод Монгол, Хятад, Орос улсын эдийн засаг, худалдааны чуулга уулзалт, үзэсгэлэн худалдаанд дүүргийн 3 үйлдвэрлэгч Р. Батнаран үндэсний хувцас, гоёл чимэглэл, Ц.Дашзэвэг Арьсан эдлэл, ноос ноолууран бүтээгдэхүүний төрлөөр Д.Мөнхөө нар оролцож 20 төрлийн 70 гаруй бараа бүтээгдэхүүнээр оролцсон.</p> <p>4. Тус дүүрэг болон ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Хамтын ажиллагааны хүрээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг гадаад зах зээлтэй холбох зорилгоор дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгч 5 үйлдвэрлэгчийг 2018 оны 5-10 өдрүүдэд зохион байгуулагдсан “Хайлаар-Орос-Монгол гурван улсын 14 дүгээр Аж ахуйн арилжааны хэлэлцээрийн бүтээгдэхүүний үзэсгэлэн”-д оролцууллаа. Үзэсгэлэн худалдаанд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үйлдвэрлэгч Р.Батнаран үндэсний хувцас, эсгий болон арьсан урлал, алт, мөнгөн эдлэлээр “Дуут урлан” ХХК, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Инару биомедикал” ХХК, ноос, ноолууран бүтээгдэхүүнээр “Хос бэхи” ХХК, хүнсний бүтээгдэхүүний чиглэлээр “Гэрэлт шонхор” ХХК-ууд өөрсдийн 40 нэр төрлийн 1300 гаруй бараа бүтээгдэхүүнээр оролцон, нийт 20 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ. Мөн эдгээр аж ахуйн нэгжүүд зөвхөн үзэсгэлэн худалдаанд оролцоод зогсохгүй цаашид хамтран ажиллах шинэ түншүүдтэй болсон нь борлуулалтаа нэмэгдүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх боломжоо нээсэн чухал алхам болсон юм.</p> <p>2017 онд дотоодод зохион байгуулсан 9, гадаадын 1 нийт 10 үзэсгэлэнд 194 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулж 60,858,670 төгрөгийн борлуулалттай ажилласан бол 2018 онд дотоодод зохион байгуулсан 7, гадаадын 4 нийт 11 үзэсгэлэнд 78 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулж, нийт 79,913,560 төгрөгийн борлуулалттай ажилласан байна.</p>					
5.3 Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлнэ								
163	5.3.1	ДЗДҮАХ-ийн 5.3.1 Гадаад харилцааг өргөжүүлэн уламжлалт харилцаатай улс орны хот, дүүрэгтэй хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлж, шинээр улс орны хот,	Хүүхэд солилцооны хөтөлбөрийг өргөжүүлнэ.	Шинээр хот дүүргүүдтэй хамтын ажиллагаа эхэлж Хүүхэд солилцооны хөтөлбөр өргөжнө.	Хүүхэд солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн орны ёс заншил, уламжлалт түүхтэй танилцах боломж бүрдсэн байна.	-	ТЗУХ	100%

		дүүргүүдтэй харилцаа тогтооно.	<p>1. БНСУ-н Сөүл хотын Жунгру дүүрэгтэй байгуулсан “Глобал гэр бүл соёлтой танилцах” хөтөлбөр 2018 оны 08 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд БНСУ-н Сөүл хотод зохион байгуулагдсан. Энэхүү хөтөлбөрт дүүргийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 28-ны Б/35 дугаар захирамжын дагуу Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга /Д.Тунгаа/-р ахлуулсан 1 албан хаагч, 4 сурагч хамрагдсан. Хөтөлбөрт хамтын ажиллагаатай дүүргүүд болох БНХАУ-ын Бээжин хотын Дунчөн, БНСУ-н Сөүл хотын Жунгру, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргүүдийн сурагчид нэг дор цуглан өөр өөрсдийн түүх, соёл, зан заншлаа сурталчилсан онцлогтой хөтөлбөр болж өнгөрсөн.</p> <p>2. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/68 дугаартай тушаалын дагуу уламжлалт хамтын ажиллагаатай Япон Улсын Нагано мужийн Саку хоттой хамтран хэрэгжүүлдэг “Хүүхэд солилцоо”-ны хөтөлбөр 10 дах жилдээ амжилттай зохион байгуулагдсан. Энэ удаагийн хөтөлбөрт 3 багш, 7 сурагч хамрагдсан бөгөөд сурагчид Монгол орны түүх, соёл, зан заншил, монгол ахуйтай танилцсан.</p>					
164	5.3.2	Уламжлалт харилцаатай хот дүүрэгтэй хамтын ажиллагааг үргэлжлүүлнэ.	Хамтын ажиллагаатай хот, дүүргүүдтэй хамтын ажиллагаагаа олон салбарт хөгжүүлнэ.	хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламж, хандив зэргийг авах боломж нээгдсэн байна.	-	ТЗУХ	100%	
			Уламжлалт харилцаатай ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймагтай байгуулсан Санамж бичгийн дагуу худалдаа, эдийн засгийг сайжруулах хэлцлийг 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Хөлөнбуйр хотын Засаг даргын орлогч Ма Жинь тэргүүтэй төлөөлөгчдийн айлчлалын үеэр хэлцэлд гарын үсэг зурсан. Энэхүү хэлцлээр эдийн засаг, худалдаа, хөдөө аж ахуй, технологи, аж үйлдвэр, хөрөнгө оруулалтыг зохион байгуулах хүрээнд хамтран ажиллана.					
165	5.3.3	ДЗДҮАХ-ийн 5.3.2. Харилцаат хот, дүүргүүд рүү албан хаагчдыг албан айлчлал, сургалт, хурал, үзэсгэлэн, туршлага судлах аялалд хамруулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.	Харилцаат хот дүүргүүд рүү албан хаагчдыг албан томилолт болон сургалт, уулзалтад хамруулах ажлыг зохион байгуулна.	Гадаад, дотоодод сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо нэмэгдэнэ.	Албан хаагчдын ур чадвар дээшилсэн байна.	-	ТЗУХ	100%
			1. Дүүргийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Б/43 дугаар захирамжын дагуу ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Засаг даргын урилгаар Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга В.Гомбодорж тэргүүтэй баг бүрэлдэхүүн Хайлаар хотод 2018 оны 09 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Нэг бүс нэг зам” сэдэвт Орос, Монгол, Хятад, гурван улсын эдийн засгийн форум, бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд оролцсон. Мөн Хөлөнбуйр аймгийн Гадаад Худалдааны газрын дарга Лю Жинжунын урилгаар дүүргийн ЖДҮТ-ийн дарга /Ц.Булган/-аар ахлуулсан жижиг дунд					

		<p>үйлдвэрлэл эрхлэгч 5 аж ахуйн нэгж, амжилттай оролцож үндэсний үйлдвэрлэлээ сурталчиллаа. Аж ахуйн нэгжүүд зөвхөн үзэсгэлэн худалдаанд оролцоод зогсохгүй цаашид хамтран ажиллах шинэ түншүүдтэй болсон нь борлуулалтаа нэмэгдүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх боломжоо нээсэн чухал алхам болсон.</p> <p>2. БНХАУ-н Бээжин хотын Дунчөн дүүргийн Засаг дарга Жинь Хүйгийн урилгаар дүүргийн Засаг дарга Х.Болормаа тэргүүтэй баг бүрэлдэхүүн 2018 оны 09 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд “6 дах удаагийн Бээжингийн Олон Улсын Бренд Фестивальд” оролцсон. Энэхүү арга хэмжээний үеэр Дунчөн дүүрэгтэй эгч, дүүсийн хамтын ажиллагаатай нийт 9 хот, дүүргийн удирдлага оролцож “Орчин үеийн хотын хөгжил болон Соёлын өвийг хадгалах, хамгаалах” тухай сэдэвт илтгэлүүд тавигдсан. Мөн айлчлалын үеэр Дунчөн дүүрэг эрүүл мэнд, боловсролын чиглэлээр 2 тал цаашид салбар бүрт хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.</p>
--	--	--

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Х.БОЛОРМАА

ХЯНАСАН:
ТГХШХ-ийн ДАРГА

М.БЯМБАСҮРЭН

НЭГТГЭСЭН:
ТГХШХ-ийн МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТЦЭЦЭГ